



**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”
ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ**



2022 он

“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ТӨСЛИЙН
ХҮРЭЭНД БОЛОВСРУУЛСАН ХУУЛИЙН ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ
СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

Эмхэтгэсэн:

Төслийн зохицуулагч

А.Амармэнд

Хэвлэлийн дизайнер:

П.Энххүлэг

Зохиогчийн эрх © Авлигатай тэмцэх газар

Энэхүү бүтээл нь зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон бүтнээр дахин хэвлэх, хайлтын системд байршуулах, цахим, механик, фото хуулбар зэрэг ямар ч хэлбэрээр хувилан олшруулах, түгээн тараахыг хатуу хориглоно.

АХБ-ны “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн санхүүжилтээр

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

1

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**



ТАНИЛЦУУЛГА

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

“Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн тухай

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Авлигын гэмт хэргийг шийдвэрлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор заасан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэр, холбогдох судалгааны үр дүнг үндэслэж боловсрууллаа.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн Азийн сангийн судалгааны багаас практик хэрэглээнд гарч байгаа зөрчлийг арилгах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн заалтад нийцүүлэх чиглэлээр Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тодорхой зөвлөмжүүд өгснийг судалж хуулийн төсөлд тусгалаа.

1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид оруулахаар хуулийн төсөлд тусгасан өөрчлөлтийн талаар

- Авлигын эсрэг конвенцийн 29 дүгээр зүйлд оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт хэрэг үүсгэх хөөн хэлэлцэх хугацааг уртаар тогтоохоор заасныг үндэслэн хөнгөн гэмт хэрэг болон хорих ялын дээд хэмжээг 8 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа 1, 3, 5 жил байхаар заасанд Авлигын гэмт хэрэг хамаарахгүй болгож, 1.10 Дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.5-Д хамаарах Авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш найман жил байхаар өөрчиллөө.
- Судалгааны багийн зөвлөмжид Авлигын гэмт хэргийн онцлогт тохирсон эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлийг хуульд нэмэхээр заасны дагуу хуулийн 6.6 Дугаар зүйлд албан тушаалын байдал, албаны эрх нөлөөгөө ашиглаж үйлдсэн бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр тусгасан.
- Авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх зөвлөмжийг үндэслэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ

хэрэглэх, хорих ялаас хугацааны өмнө суллах хуулийн заалт Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд хамаарахгүй байхаар хуулийн 6.7 Дугаар зүйлд тусгалаа. Мөн Авлигын гэмт хэрэг үйлдсэн төрийн өндөр албан тушаалтан, зохион байгуулалттай бүлэг болон их хэмжээний хохиролтой Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд өршөөл, уучлал үзүүлэхгүй байхаар заалаа.

- Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд бодитой тусалсан хамтран ажиллах этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохоор 6.15 Дугаар зүйлд нэмлээ. Дээр дурдсан конвенцийн 37 дугаар зүйлийн 3-т “оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг мөрдөн шалгах буюу яллахад идэвхитэй хамтран ажиллаж буй этгээдэд яллагдахаас чөлөөлөгдөх дархан эрхийг олгох боломжийг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн олгох асуудлыг авч үзнэ” гэж заасан болно.
- Судалгааны багаас “Авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах” гэсний дагуу хуулийн 7.1 Дүгээр зүйлд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх нь Авлигын гэмт хэрэгт хамаарахгүй байхаар өөрчлөлт орууллаа.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Авлигын гэмт хэрэг” 22 дугаар бүлэгт оруулахаар хуулийн төсөлд тусгасан өөрчлөлтийн талаар

Тус судалгааны багаас гаргасан дүгнэлтэд “Эрүүгийн хуулийн 22.1, 22.4, 22.5 дугаар зүйлийн хэсгүүдэд заасан гэмт хэргийн шинжийн томъёолол, тэдгээрийн уялдаа, хүндрэх нөхцөлийн логик дараалал өөр, өөр, холбогдох тайлбарууд нь логикийн хувьд ойлгоход төвөгтэй, бүх заалтад адил ашиглах боломжгүй, эргэлзээ үүсгэхүйц байна. Энэ нь эдгээр гэмт хэрэг хоорондын онцлог шинж, ялгааг мөрдөгч, прокурор, шүүгч өөр, өөрөөр зөрүүтэй ойлгож, тайлбарлах, улмаар гэмт хэргийн шинжийг анхнаас нь зөв тодорхойлох, зүйлчлэхэд саад учруулахаар байна. Тиймээс 22 дугаар бүлэг болон холбогдох бусад заалтуудыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенци болон олон Улсын сайн туршлагад нийцүүлэн хэрэглэхэд ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай” гэжээ.

Авлигын эсрэг конвенцийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн хэмжээг тогтоохдоо гэмт үйлдлийн хүнд ноцтой байдлыг харгалзахаар заасан.

Иймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлгийн холбогдох

зүйлүүдэд үндсэн шинжээс бусад шинж рүү хүндрэх дараалалтай болгож, нийтийн албаны гүйцэтгэх, удирдах албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд, зохион байгуулалттай гэмт бүлгийн хүлээх эрүүгийн хариуцлагын хэмжээг харилцан адилгүй ялгамжтай байхаар тусгалаа.

- Албаны эрх нөлөөгөө урвуулан ашиглах гэмт хэргийн талаар тусад нь зүйл болгон шинээр нэмлээ. Авлигын эсрэг конвенцийн 18 дугаар зүйлд эрх нөлөөгөө урвуулан ашиглахыг гэмт хэрэг гэж тогтоох шаардлагатайг заасан байна.
- Судалгааны багийн зөвлөмжийн дагуу зарим хөнгөн гэмт хэрэгт хорих ялын доод хэмжээ 6 сараас эхлэхээр, мөн нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэхээр нэмж заалаа.
- Эрүүгийн хуулийн 1.2 Дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон Улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална” гэж заасныг үндэслэн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжийг тодруулах тайлбар нэмж, шаардлагагүй болсон тайлбарыг хасч, өөр хуульд заасан холбогдох тайлбарыг тухайн зүйлийн агуулгыг тодруулах үүднээс нэмж тусгалаа.
- Дураараа аашлах гэмт хэргийг тохиромжтой бүлэгт оруулах, нийтийн албан тушаалтан үйлдсэн бол эрүүгийн хариуцлага нь өөр байхаар зохицуулах зөвлөмжийн дагуу дураараа аашлах гэмт хэргийг хуулийн 23 дугаар бүлэгт, албан тушаалтны нэр барих гэмт хэргийг 22 дугаар бүлэгт нэмэхээр тусгалаа.
- Авлигатай тэмцэх газраас өгсөн саналын дагуу хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн шинжээс ялгамжтай тогтоохын тулд 17.6 Дугаар зүйлийн 2.2-ыг өөрчилж, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэргийг нийтийн албан тушаалтан үйлдсэн бол эрүүгийн хариуцлага нь өөр байх зохицуулалтыг 22.12 Дугаар зүйлд нэмсэн.
- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн тайлбарт Авлигын эсрэг хуульд мөн агуулгаар тусгасан тайлбарыг нийцүүлэх зорилгоор Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай дагах хуулийн төсөл боловсрууллаа.

БАТЛАВ

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байна.

Өнгөрсөн хугацаанд энэхүү хуулийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар хийсэн судалгааны ажлаас тодорхой сэдвээр өргөн хүрээг хамарсан, хамгийн сүүлийн үеийн судалгааны ажил нь Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн судалгааны багаас “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ” сэдвээр хийсэн судалгааны ажил болно.

Энэхүү судалгааны хүрээнд асуумж судалгаа авах, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, шийдвэр судлах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх зэрэг ажлыг гүйцэтгэсэн ба тоон болон чанарын дүн шинжилгээ нь сүүлийн 3 жилийн хугацааг хамарсан байна. Авлигын гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж, Авлигын гэмт хэргийн онцлогийг харгалзан эрүүгийн хариуцлагын асуудлыг нарийвчилж өөрчлөх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой зүйл, заалтыг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид заасантай нийцүүлэн гэмт хэргийн шинжийг тодорхой тусгах чиглэлээр зөвлөмж гаргасан.

Дээрх судалгаанд оролцсон хуулийн байгууллагын алба хаагчдаас гаргасан санал, дүгнэлтээс үзэхэд, Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлээр холбогдох хууль боловсронгуй бус байгааг нэрлэсэн байна. Тодруулбал, Авлигын гэмт үйлдэл, эс үйлдлийн шинж, түүнийг бүрэн тодорхойлох асуудал, Авлигын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлагад татах нийтийн албан тушаалтны ангилал, оногдуулах ял шийтгэлийг ялгамжтай болгох, хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг нэрлэжээ.

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, тус судалгааны багаас гаргасан дүгнэлтэд “эрүүгийн хуулийн 22.1, 22.4, 22.5 Дугаар зүйлийн хэсгүүдэд заасан гэмт хэргийн шинжийн томъёолол, тэдгээрийн уялдаа, хүндрэх нөхцөлийн логик дараалал өөр, өөр, холбогдох тайлбарууд нь логикийн хувьд ойлгоход төвөгтэй, бүх заалтад адил ашиглах боломжгүй, эргэлзээ үүсгэхүйц байна.Эрүүгийн хуульд заасан Авлигын гэмт хэргийн тодорхойлолт нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид заасан агуулга, томъёололтой бүрэн нийцэхгүй байна. Тухайлбал, конвенцийн 15 дугаар зүйлийн (б) хэсэгт “давуу байдал олж авахаар шууд ба шууд бусаар шаардсан эсвэл авсан” үйлдэл нь суурь гэмт үйлдэл байхаар тусгажээ. Харин эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд “тохиролцсон байх” шинж орхигдсон байна. Түүнчлэн, Авлигын гэмт үйлдэл, эс үйлдэлд хамаарах хэд хэдэн шинжийг нэг хэсэгт багтаасан нь нотлогдож буй шинжээр нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс 22 дугаар бүлэг болон холбогдох бусад заалтуудыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенци болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн хэрэглэхэд ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай” гэжээ.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн хэмжээг тогтоохдоо гэмт үйлдлийн хүнд ноцтой байдлыг харгалзахаар заасан тул хахууль авах гэмт хэргийн хувьд бага хэмжээний хахууль авсан хүн, их хэмжээний хахууль авсан хүнд оногдуулах ял шийтгэл харьцангуй ижил төстэй байгаа тул ял шийтгэлийг хахуулийн хэмжээтэй уялдуулан шатлалтай болгох шаардлагатай байгааг дурдсан байна

Дээр дурдсан судалгаанаас үзэхэд 2017 оны 7 сарын 1-нээс 2019 он дуусах хүртэл хугацаанд хэрэг бүртгэлтийн шатанд 44, мөрдөн байцаалтын шатанд 21, шүүхийн шатанд 5, нийт 70 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. Энэ нь 3 жилд шийдвэрлэгдсэн нийт Авлигын хэргийн 42%-тай тэнцэх тоо юм. Судлагдсан хэрэг бүртгэлтийн хэргийн 12%-д нь (хэрэг бүртгэлтийн хэрэг нээх үед) хэрэг үйлдэгдсэнээс хойш 5 буюу түүнээс дээш жил өнгөрсөн буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан байв. Түүнчлэн хэрэг бүртгэлтийн дундаж хугацаа хагас жил орчим байгаа бөгөөд зарим хэргийн хувьд 1 жил буюу түүнээс ч удаан үргэлжилж байгаа нь хөөн хэлэлцэх хугацаа хэрэг бүртгэлтийн шатанд дуусах нөхцөл болж байна. Бусад төрлийн гэмт хэргийг бодвол Авлигын гэмт хэрэг нууц далд, зохион байгуулалттай үйлдэгддэг нь цөөнгүй, хэргийн хувьд уг хэрэг удаан хугацааны дараа илрэх, гомдол мэдээлэл ирэх шалтгаан болж байна. Тухайлбал, дээр дурдсан 12%-ыг эзэлж буй гэмт хэргийн талаарх

мэдээлэл 6-10 жилийн дараа ирж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн байна. Тиймээс Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дунджаар 3 жилээр нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ.

Эрүүгийн хууль батлагдсанаас хойших хугацаанд Авлигын гэмт хэргийн тухай 22 дугаар бүлэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн болон 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт орсон боловч холбогдох судалгааны дүгнэлтээс үзэхэд 2015 онд батлагдсан эрүүгийн хууль, энэ хугацаанд түүнд орсон нэмэлт, өөрчлөлт нь Авлигын хэрэг түүний ял шийтгэлийн асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Авлигын гэмт хэргийг шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулах шаардлага байгааг төр засгийн зүгээс анхаарч, бодлого шийдвэртээ тусгайлан зааж, хэрэгжүүлэх үүрэг хүлээлгэж байгаа ба тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “авлигагүй засаглал” гэсэн 5.6 Дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, **зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат болох 2021-2030 онд** авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлж, **хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан.** Тухайлбал, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, Авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэжээ.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “4.4.7. Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр тус тус заасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 болон 13 дугаар зүйлд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан

судалсан байх талаар заасныг үндэслэн эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг тогтоосон тандан судалгааны тайлан гарсан.

Авлигын гэмт хэрэгтэй холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэлийг тодорхойлсон холбогдох судалгааны үр дүн, үүссэн асуудлыг хуульд тусгах замаар шийдвэрлэхийг тогтоосон тандан судалгааны тайлан, тухайн асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр өөрчлөлт хийхээр заасан Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй үзлээ.

Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Шаардлагатай өөрчлөлтийн цар хүрээг харгалзан хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.1-д заасны дагуу “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” төрлийг сонгон хуулийн төслийг боловсруулна. Хуулийн төслийн бүтэц зүйл, хэсэг, заалтаас бүрдэнэ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа эрүүгийн хуульд заасан “эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчмыг мөрдлөг болгоно.

Эрүүгийн хуулийн 1.2 Дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “...Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно” хэмээн заасан тул энэ хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг эрүүгийн хуулиас ангид тусгайлан авч тайлбарлах шаардлагагүй юм.

Хуулийн төсөлд дараахь өөрчлөлтийг тусгана:

- Бага хэмжээний хахууль авсан, өгсөн, хохирол багатай, бага хэмжээний давуу байдал олгосон хэргүүдэд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэлийг хэрэглэхээр тусгах;
- Авлигын хэрэгт тэнсэх албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх өөрчлөлт оруулах;
- Өндөр албан тушаалтан, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, хахууль, давуу байдлын хэмжээ, хохирол ихтэй Авлигын хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх зохицуулалтыг нэмэх;

- Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг гэмт хэргийн хүнд, ноцтой байдал, түүний улмаас учирсан хохирлын хэмжээ, албан тушаалын байдалтай нь уялдуулан тогтоох зохицуулалтыг тусгах. Тухайлбал, гүйцэтгэх, удирдах албан тушаалтан үйлдсэн бол ялын доод хэмжээ нь тус тус өөр байхаар тогтоох;
- Хүндрүүлэх нөхцөлгүй Авлигын хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг Эрүүгийн хуульд заасан хорих ялын доод хэмжээгээр тогтоох;
- Улс төрийн болон өндөр албан тушаалтны үйлдсэн, хохирол, хахуулийн хэмжээ ихтэй авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх зохицуулалтыг оруулах;
- Авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтан оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг эдэлсэн бол хугацаанаас өмнө суллах, хахууль, давуу байдлын хэмжээ, хохирол ихтэй авлигын хэрэг үйлдсэн этгээдийг хугацаанаас өмнө суллахгүй байх зохицуулалтыг тусгах;
- Хуулийн 17 дугаар бүлэгт заасан өмчлөх эрхийн эсрэг зарим гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэнийг 22 дугаар зүйлд заасан авлига албан тушаалын гэмт хэргээс ялгах шинжийг тодорхой тусгах;
- Хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн томъёолол, харилцан хамаарал, логик дарааллыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийг томъёолж буй аргачлалаар тусгаж, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх;
- Хуулийн 22.1 Дүгээр зүйлд заасан гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгах;
- Нийтийн албан тушаалтанд давуу байдал бий болгосон, мөн хууль бусаар давуу байдал олж авсан нийтийн албан тушаалтан биш этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгах;
- Дураараа аашлах, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэргийг нийтийн албан тушаалтан үйлдсэн бол эрүүгийн хариуцлага нь өөр байхаар зохицуулах;
- Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Авлигын эсрэг конвенцид нийцүүлэн эрүүгийн хуулийн тусгай ангид засан бусад бүлгийн гэмт хэргээс их байхаар тогтоох.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөлд ямар нэгэн шинэ ялын төрөл нэмж тусгахгүй учраас хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй. Хуулийн төсөл батлагдсанаар хууль дээдлэх ёсны зарчимд нийцсэн, гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчинд ахиц дэвшил гарна. Мөн Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим бодитой хэрэгжинэ.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан Авлигын эсрэг хууль зэрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

1/1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Энэ зүйлийн 1.1, 1.2, 1.5-д хамаарах авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш найман жил байна.”

2/6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.11 дэх заалт:

“1.11.Албан тушаалын байдал, албаны эрх нөлөөгөө ашиглаж үйлдсэн.”

3/6.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Энэ зүйлийн 1-3 дахь хэсэгт заасан хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл нь Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд хамаарахгүй.”

4/6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6.Энэ зүйлийн 1.1-1.3-т заасан хугацаанаас өмнө суллах тухай заалт авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтанд хамаарахгүй.”

5/22.1 дүгээр зүйлийн тайлбар:

“Тайлбар: - энэ хуульд заасан “давуу байдал” гэж Авлигын эсрэг хуулийн 3.1.4-Т заасны дагуу уг хуулийн 4.1-Д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг ойлгоно.

- Энэ хуульд заасан “эрх бүхий этгээд” гэж мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадлагаа гаргах үйлчилгээ үзүүлэх этгээд, байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн болон эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгоно.”

6/22.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”

7/22.8 дугаар зүйлийн тайлбар:

“Тайлбар: -энэ хуульд заасан “төсвийн захирагч” гэж төсвийн тухай хуулийн 4.1.35-д заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчийг ойлгоно.”

8/22.13 дугаар зүйл:

“22.13 дугаар зүйл.Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах

1.Нийтийн албан тушаалтан болон эрх бүхий этгээд өөртөө, эсхүл бусдад давуу байдал олгуулах зорилгоор өөрөө болон бусдаар дамжуулан албаны эрх нөлөөг урвуулан ашиглаж давуу байдал олж авсан, эсхүл давуу байдал олгосны улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албан тушаалтан болон эрх бүхий этгээд албаны эрх нөлөөг урвуулан ашиглаж аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хууль бусаар оролцсоны улмаас аж ахуйн нэгжийн төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг нийтийн албаны удирдах албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албанд томилогдох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

9/22.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг нийтийн албан тушаалтан үйлдсэн бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван

жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

10/23.8 дугаар зүйл:

“23.8 дугаар зүйл.Дураараа аашлах

1. Дураараа аашлах, өөрөөр хэлбэл өөртөө үнэхээр байгаа буюу байна гэж үзсэн, эсхүл бусадтай маргаж байхдаа хуулиар тогтоосон журмыг зөрчиж эрхээ дураараа хэрэгжүүлснээс бусдад их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Хоёрдугаар зүйл.Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “эсрэг” гэсний дараа “гэмт хэрэг, төрийн өндөр албан тушаалтан эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдсэн авлигын гэмт хэрэг, эсхүл их хэмжээний хохиролтой авлигын” гэж, 6.15 Дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хэрэг” гэсний дараа “авлигын гэмт хэрэг” гэж, 7.1 Дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бол” гэсний өмнө “авлигын гэмт хэрэг үйлдсэн” гэж, 22.5 Дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “холбогдуулан” гэсний дараа “мөнгө” гэж, мөн хэсгийн “торгох” гэсний дараа “эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх” гэж, 22.6 Дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “зорилгоор” гэсний дараа “мөнгө” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/22.1 дүгээр зүйл:

“22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах

1.Нийтийн албаны гүйцэтгэх албан тушаалтан болон эрх бүхий этгээд албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө эсхүл бусдад давуу байдал бий болгосон, тохиролцсон бол нийтийн албанд томилогдох эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж, хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албаны гүйцэтгэх албан тушаалтан болон эрх бүхий этгээд албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж их хэмжээний хохирол учруулсан бол нийтийн албанд томилогдох эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг нийтийн албаны удирдах албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд үйлдсэн бол нийтийн албанд томилогдох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж, таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2/22.4 дүгээр зүйл:

“22.4 дүгээр зүйл.Хахууль авах

1.Хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, хэрэгжүүлэхийн тулд эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, тохиролцсон, эсхүл хахууль авсан бол нийтийн албанд томилогдох эсхүл мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нийтийн албаны гүйцэтгэх албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, хэрэгжүүлэхийн тулд эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, тохиролцсон, эсхүл хахууль авсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг нийтийн албаны удирдах албан тушаалтан үйлдсэн бол нийтийн албанд томилогдох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг улс төрд нөлөө бүхий этгээд эсхүл зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”

3/22.11 дүгээр зүйл:

“22.11 дүгээр зүйл.Албан тушаалтны нэр барих

1. Нийтийн албан тушаалтан болон эрх бүхий этгээд өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласны улмаас бусдын эрх ашигт хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Дөрөвдүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлийн 2.2-т “албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн” гэснийг “албан тушаалын байдлаа ашиглаж” гэж өөрчилсүгэй.

Тавдугаар зүйл.Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн тайлбараас “Энэ хуульд заасан “албан тушаалын байдал” гэдэгт эрх нөлөө хамаарна” гэснийг, 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийг 1924 онд батлан гаргасантай холбоотойгоор 1926 онд анхны Эрүүгийн хууль гарсан. 1926, 1929, 1934 Оны хууль “Шүүх цаазын бичиг”¹ нэртэйгээр батлагдан мөрдөгдөж байсан ба 1942 оноос “Эрүүгийн хууль” болж, түүнээс хойш хэд хэдэн шинэчилсэн найруулга батлагдаж, холбогдох нэмэлт, өөрчлөлт орсон.

Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэргийн шинжийг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж томъёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл чиглэгдэж ирсэн ба өнөөгийн нөхцөлд ч хуулийг сайжруулан хэрэгжүүлэх хэрэгцээ байсаар байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Авлигагүй засаглал” гэсэн 5.6 дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, **зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат болох 2021–2030 онд** авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлж, **хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан.Тухайлбал**, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т

¹ Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009он/ УБ, 2012, 23 дахь тал

“4.4.7.Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр заасан.

Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн судалгааны баг “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ”² хийж, Авлигын гэмт хэргийн онцлогт тохирсон эрүүгийн хариуцлагын асуудлыг нарийвчилж өөрчлөх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой зүйл, заалтыг НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид заасантай нийцүүлэн гэмт хэргийн шинжийг тодорхой тусгах чиглэлээр зөвлөмж гаргасан.

2015 Онд батлагдсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж боловсронгуй болгох талаар чиглэл, зорилт тавьж, тодорхой судалгаа явуулж, дүн шинжилгээ хийснээс үзэхэд энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах шаардлага байна.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын³ /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

Нэг.Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Одоогийн даган мөрдөж байгаа Эрүүгийн хуулийг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдсөнөөс хойших хугацаанд 16 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

² Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, УБ, 2021

³ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

2015 Оны Эрүүгийн хуульд Монгол Улсын 2005 онд нэгдэж орсон Авлигын эсрэг НҮБ-ийн конвенцид заасан агуулгаар “Авлигын гэмт хэрэг” гэсэн шинэ бүлгийг нэмж авлига, албан тушаалтанд холбогдох гэмт хэргийг шинжийг шинээр томъёолсон. Үүнд: урьд нь албан тушаалын байдлаа хортойгоор урвуулан ашиглаж үлэмж хэмжээний буюу 9.600.000 Төгрөгөөс доош хохирол учруулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хариуцлага хүлээлгэх боломжгүй байсныг өөрчилж, төрийн албан хаагч албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлээгүйгээс өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон бол хохирлын хэмжээнээс үл хамааран гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар хуульчилсан. Үүнд: төрийн албан хаагч өөртөө, эсхүл өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгуулах зорилгоор өөрөө эсхүл өөрийн удирдлагад ажилладаг албан тушаалтнаар дамжуулан албаны эрх нөлөөг урвуулан ашиглаж давуу байдал олж авсан, эсхүл олгосноос бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан бол гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан. Гадаад Улсын албан тушаалтан, олон Улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглавал Монгол Улсын хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон. Хахууль авах гэмт хэргийн субъект нь нийтийн албан тушаалтнаас гадна хууль, захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр үүрэг хүлээсэн хүн байж болохыг тодорхой болгож, хууль тогтоомж, дүрэм журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөнөөс гадна дээрх албан үүргээ зохих журмын дагуу хэрэгжүүлсний төлөө бусдаас мөнгө, эсхүл давуу байдал олж авсан бол хахууль авах гэмт хэрэгт тооцно гэж заасан. Түүнчлэн хахууль авах, өгөхөөс гадна өгөхийг шаардсан, хахууль өгөх саналыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл хахууль өгөхийг санал болгосон, амласан зэрэг үйлдэл хийснээр гэмт хэрэг төгссөнд тооцохоор, өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байж болохыг хуульчилсан. Төрийн албан хаагчийн хууль ёсны дагуу албан үүргээ гүйцэтгэж, үзүүлэх байсан төрийн үйлчилгээг хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд хахууль өгч, авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж, ял шийтгэлээс чөлөөлөх, харин хахууль авагчийг хууль бус үйлдэл хийлгэхээр хахууль өгсөн хүнийг ялаас чөлөөлөхгүй, харин хахууль өгсөн хүн эрх бүхий байгууллагад сайн дураараа хэргээ илчлэн ирсэн бол ял шийтгэлийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцохоор заасан. Дээр дурдсан Авлигын гэмт хэрэгтэй холбогдох заалтуудын хэрэгжилтийн байдалд судалгаа хийсний дүнд зарим зохицуулалтыг нарийвчлах, нэмэлт оруулах асуудал үүссэн байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх

тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хийгдсэн “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ”-г Азийн сангийн судалгааны баг эдгээр байгууллагуудын хамтран баталсан арга зүйн дагуу 2020 оны 1 сарын 10-наас мөн оны 9 сарын 17-ны хооронд гүйцэтгэжээ.

Судалгааны хүрээнд асуумж судалгаа авах, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, шийдвэр судлах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, дотоодын хууль тогтоомж судлах зэрэг ажлыг гүйцэтгэсэн ба тоон болон чанарын дүн шинжилгээ нь сүүлийн 3 жилийн хугацааг хамарсан бөгөөд 2017-2019, мөн 2020 оны эхний улирлын мэдээлэл, баримтуудыг хамруулжээ. Судалгааны зөвлөмжүүдийг одоогийн эрх зүйн орчин, нийтлэг ойлголт, тогтсон практикийн хүрээнд хязгаарлалгүйгээр онол практикийн хувьд боломжтой гэж үзсэн, хэрэгжүүлж болохуйц бүх саналыг багтаах зарчим баримталсан байна.

Авлигын гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах тухай зөвлөмжийг үзэхэд Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт багтсан авлигын гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлагын асуудлыг эргэж харах, Авлигын эсрэг конвенцид бүрэн нийцүүлэх чиглэлээр байна.

Иймд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, уг асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1. Эрүүгийн чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, авлигатай тэмцэх ажлыг сайжруулах талаар гарсан Монгол Улсын Их Хурал болон засгийн газрын тогтоол, шийдвэр, “шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдвээр 2019 онд болсон хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөний илтгэлүүд, мөн 2019 онд Азийн сангаас Бүгд Найрамдах Солонгос Улсын хөгжлийн Институт, Канад Улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн төлөө авлигатай тэмцэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь: Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага” сэдэвт сургалтын материал, 2020 онд Авлигатай тэмцэх газраас гаргасан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны хэрэгжилтийн тайлан”, 2021 онд Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны төслөөс гаргасан “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан” болон энэхүү асуудлын талаар эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгааны ажил, нийтлэл зэргийг судалж үзсэн болно.

Мөн Эрүүгийн хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойших хугацаанд уг хуульд авлигын гэмт хэрэгтэй холбогдон орсон өөрчлөлтийг харьцуулан судалсан. Тухайлбал, тус хуульд 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан ба үүнд: эрүүгийн хуулийн 22.1, Болон 22.2 дугаар зүйлүүдэд заасан гэмт хэргийн объектив тал буюу үйлдэл, үйлдлийн арга, хэлбэр нь ижил байхад гэмт хэргийн субъект буюу албан тушаалтан “албан тушаалын байдлаа” эсхүл “эрх нөлөөгөө” ашигласнаас хамааран тус тусад нь зүйлчилсэн байгааг оновчтой бус гэж үзэж дээрх 2 зүйлийг нэгтгэж, ингэхдээ аль аль бүрэлдэхүүний бүхий л шинжийг хэвээр хадгалан, хууль зүйн техникийн шинжтэй засвар хийж, эрх хасах ялын хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг өөрчлөлт оруулжээ.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Эрүүгийн хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Эрүүгийн хуульд заасан эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн хувьд сөргөөр нөлөөлөх байдлыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийтийн албан тушаалтан	Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлига, хээл хахуулийн гэмт хэргүүдэд оноож байгаа ялын төрөлд нийтэд тустай ажил хийлгэх ял байхгүй байгаа нь нийтийн албан тушаалтны үйлдсэн гэмт хэрэгт сонгон хэрэглэх ял хязгаарлагдмал болж эрх зүйн байдлыг нь дордуулж байна.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас Эрүүгийн хуулийн ялын бодлогод гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй гэсэн шударга ёсны зарчим алдагдахаар байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн явцад шийдвэл зохих асуудал байсаар байна. 2015 Онд

батлагдсан Эрүүгийн хууль, энэ хугацаанд түүнд орсон нэмэлт, өөрчлөлт нь авлигын хэрэг түүний ял шийтгэлийн асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Азийн сангийн судалгааны багаас хийсэн асуумж судалгааны дүнгээс үзэхэд авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлээр холбогдох хууль боловсронгуй бус байгааг нэрлэсэн байна. Тодруулбал, авлигын гэмт үйлдэл, эс үйлдлийн шинж, түүнийг бүрэн тодорхойлох асуудал, Авлигын гэмт хэрэгт эрүүгийн хариуцлагад татах нийтийн албан тушаалтны ангилал, оногдуулах ял шийтгэлийг ялгамжтай болгох, хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг нэрлэжээ.

Тус судалгааны багаас гаргасан дүгнэлтэд “Эрүүгийн хуулийн 22.1, 22.4, 22.5 дугаар зүйлийн хэсгүүдэд заасан гэмт хэргийн шинжийн томъёолол, тэдгээрийн уялдаа, хүндрэх нөхцөлийн логик дараалал өөр, өөр, холбогдох тайлбарууд нь логикийн хувьд ойлгоход төвөгтэй, бүх заалтад адил ашиглах боломжгүй, эргэлзээ үүсгэхүйц байна. Тухайлбал, Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэргүүд, мөн 22.5 дугаар зүйлд заасан хахууль авах гэмт хэргийн хэсгүүд үндсэн шинжээс бусад шинж рүү хүндрэх дараалалтай байхад 22.1, 22.4-т заасан гэмт хэрэгт логик дараалалгүй байна. Энэ нь эдгээр гэмт хэрэг хоорондын онцлог шинж, ялгааг мөрдөгч, прокурор, шүүгч өөр, өөрөөр зөрүүтэй ойлгож, тайлбарлах, улмаар гэмт хэргийн шинжийг анхнаас нь зөв тодорхойлох, зүйлчлэхэд саад учруулахаар байна. Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэргийн тодорхойлолт нь авлигын эсрэг НҮБ-ын конвенцид заасан агуулга, томъёололтой бүрэн нийцэхгүй байна. Тухайлбал, конвенцийн 15 дугаар зүйлийн (б) хэсэгт “давуу байдал олж авахаар шууд ба шууд бусаар шаардсан эсвэл авсан” үйлдэл нь суурь гэмт үйлдэл байхаар тусгажээ. Харин эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд “тохиролцсон байх” шинж орхигдсон байна. Түүнчлэн, Авлигын гэмт үйлдэл, эс үйлдэлд хамаарах хэд хэдэн шинжийг нэг хэсэгт багтаасан нь нотлогдож буй шинжээр нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс 22 дугаар бүлэг болон холбогдох бусад заалтуудыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенци болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн хэрэглэхэд ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай” гэжээ.

Мөн хахууль авах гэмт хэргийн хувьд бага хэмжээний хахууль авсан хүн, их хэмжээний хахууль авсан хүнд оногдуулах ял шийтгэл харьцангуй ижил төстэй байгаа тул ял шийтгэлийг хахуулийн хэмжээтэй уялдуулан шатлалтай болгох шаардлагатай байгааг дурдсан байна. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн хэмжээг тогтоохдоо гэмт үйлдлийн хүнд ноцтой байдлыг харгалзахаар заасан.

Дээр дурдсан судалгаанаас үзэхэд 2017 оны 7 сарын 1-нээс 2019 он дуусах хугацаанд хэрэг бүртгэлтийн шатанд 44, мөрдөн байцаалтын шатанд 21, шүүхийн шатанд 5, нийт 70 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. Энэ нь 3 жилд шийдвэрлэгдсэн нийт авлигын хэргийн 42%-тай тэнцэх тоо юм. Судлагдсан хэрэг бүртгэлтийн хэргийн 12%-д нь (хэрэг бүртгэлтийн хэрэг нээх үед) хэрэг үйлдэгдсэнээс хойш 5 буюу түүнээс дээш жил өнгөрсөн буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан байв. Түүнчлэн хэрэг бүртгэлтийн дундаж хугацаа хагас жил орчим байгаа бөгөөд зарим хэргийн хувьд 1 жил буюу түүнээс ч удаан үргэлжилж байгаа нь хөөн хэлэлцэх хугацаа хэрэг бүртгэлтийн шатанд дуусах нөхцөл болж байна.

Бусад төрлийн гэмт хэргийг бодвол Авлигын гэмт хэрэг нууц далд, зохион байгуулалттай үйлдэгддэг нь цөөнгүй, хэргийн хувьд уг хэрэг удаан хугацааны дараа илрэх, гомдол мэдээлэл ирэх шалтгаан болж байна. Тухайлбал, дээр дурдсан 12%-ыг эзэлж буй гэмт хэргийн талаарх мэдээлэл 6-10 жилийн дараа ирж, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн байна. Тиймээс Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дунджаар 3 жилээр нэмэгдүүлэх шаардлагатай. Эрүүгийн хуулийн 1.10 Дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг яллагдагчаар татах хүртэл тоолно гэж заасан нь дараахь асуудлыг үүсгэж болзошгүй байна. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэлтийн хэргийн ойролцоогоор 14% нь тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас 1-2 жилийн өмнө хэрэг бүртгэлтэд ирсэн байна. Нөгөө талаас хэрэг бүртгэлтийн хэргийн 16%-д хэрэг бүртгэлт 1 жилээс дээш 2 жил хүртэл хугацаанд үргэлжилсэн байна. Энэ нь хэргийн ээдрээ төвөгтэй байдал болон бусад шалтгаанаар хэрэг бүртгэлт удааширч, улмаар хөөн хэлэлцэх хугацаа нь дөхсөн, хэрэг хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болох нэг шалтгаан болж байна. Түүнчлэн, гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй цаг хугацаа нь хэрэг бүртгэлтийн явцад тодорхой болж байгаа нь мөрдөгч, прокурор нэг бол яарч чанаргүй хэрэг бүртгэлт явуулж, яллагдагчаар татах, эсхүл хэргийн холбогдогчдоос хэрэг бүртгэлтийг удаашруулах зорилгоор нөлөөлөл үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж дүгнэжээ.⁴

Иймээс эрүүгийн хуульд заасан Авлигын гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулах чиглэлээр үзэл баримтлалаа тогтоож, хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

⁴ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, УБ, 2021, 52-57 дахь тал

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах зорилго нь нэгдэн орсон авилгын эсрэг конвенцийн зохих заалтад нийцүүлэх, тухайн хуулийг сайжруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангахад оршино.

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, уг ажлын хүрээнд эрүүгийн хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан тул аргачлалын 5.4.4-Т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон болно.

Энэ тохиолдолд асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр одоо үйлчилж байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулах нь зүйтэй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.1-д “Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хуулийг бүхэлд нь эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна” гэж заасныг баримталсан болно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Эрүүгийн хуульд заасан Авлигын гэмт хэргийн ялын бодлогыг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэх, нийтийн болон үндэсний ашиг сонирхлыг тухайн гэмт хэргийн халдлагаас хамгаалах чиглэлээр өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байна.

Иймд эдгээр асуудлыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой болно.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөлд ямар нэгэн шинэ байгууллага, нэгж бий болгохоор нэмж тусгахгүй бөгөөд хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй болно.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Авлигын гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах тул шударга үр дүнтэй ажиллагаа нь, хууль сахиулах байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлнэ.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, Арвандөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”Гэж тус тус заасан тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь Үндсэн хуулийн зарчимд нийцэж байна.

Энэ чиглэлээр хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь олон улсын хэм хэмжээний жишигтэй нийцэж байна. Тухайлбал Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 5 дугаар зүйлд “Оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн нийгмийн оролцоог дэмжсэн, хууль дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмыг илэрхийлсэн үр дүнтэй, уялдаа холбоо бүхий авилгалын эсрэг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасан.

Мөн Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон Улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ” хэмээн заасантай зөрчилдөхгүй болно.

Тав.Зохицуулалтын хувилбаруудыг Харьцуулсан дүгнэлт

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараахь дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

Зургаа.Олон Улсын болон бусад Улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

Бусад орны Эрүүгийн хуулийн авлигын гэмт хэрэгтэй холбогдох зохицуулалтын талаар дурдахад:

- Франц Улсын хуульд хээл хахууль авахаар хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран хээл хахууль өгөхөөр санал болгосон, эсхүл амласан л бол түүнийг идэвхтэй хээл хахууль гэж үзнэ. Гэхдээ Францын шүүхүүд тус улсын нийтийн албан тушаалтнуудын хээл хахуулийн хэргийг дүгнэж үзээд хахуульдагч тал ба хүлээн авагч талын санаа зорилго нэгдсэн эсэх талаар нотолгоо шаарддаг байх авлигын тохиролцооны талаарх зохицуулалт бий болгосон байна. Шаардагдах зүйл нь гэрээ хийгдсэн тухай нотолгоо бус харин хахуульдагч тал өөрийн үйлдлийн зорилго нь тодорхой үйлдэл хийлгэх, эс хийлгэх гэдгийг мэдэж байх, хахууль хүлээн авагч тал нь тодорхой үйлдэл, эс үйлдэхүйн дүнд зүй бус давуу байдал

олж авч байгаагаа ухамсарласан байсан талаарх нотолгоо болно. Энэ нь статутын эрх зүй гэхээсээ нийтийн /жишгийн/ эрх зүйг бий болгож байгаа явдал юм.⁵

- ӨАБНУ-ын авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай 2004 оны хуулиар төр, хувийн хэвшил дэх авлигыг гэмт хэрэгт тооцож, авлига авахыг завдах, завших, хээл хахууль авах үйлдэл эс үйлдэл, гадаадын албан тушаалтанд хээл хахууль өгөх, албан тушаалаа урвуулан ашиглах, мөнгө угаах зэрэг тодорхой гэмт хэргийг кодчилжээ. Энэ нь мөрийтэй тоглоом, спортын арга хэмжээг хүртэл багтаасан байдаг (нэг тал ялсан эсэхийг тогтоох шүүгчид мөнгө өгөх гэх мэт). Авлигын хэрэгт буруутгагдсан хүмүүст ногдуулах хориг арга хэмжээнд их хэмжээний торгууль, удаан хугацаагаар хорих ял (бүх насаар нь хорих ялын дээд хэмжээтэй) ба эсхүл засгийн газарт ажиллахыг хориглох зэрэг ордог байна.⁶
- Люксембургийн вант улсад албан тушаалтан тухайн холбогдох асуудлаар чиг үүргээ хэрэгжүүлэхийн өмнө, эсхүл чиг үүргээ хэрэгжүүлэхээс татгалзахын өмнө Авлигын талаар хэлэлцэн тохирсон бол түүнийг хээл хахуулийн гэмт хэрэг гэж тооцдог байсан. Ийм тохиролцоо хийхээр оролдоод амжилтгүй болсон бол тэрхүү үйлдлийг “завдсан” гэж үзнэ. Тиймээс хээл хахууль өгсөн үйлдлийг ч төгссөн гэмт хэрэг гэж үздэггүй байв. Авлигын гэмт хэргийг шинээр дахин тодорхойлсон люксембургийн эрүүгийн хуулийн 249 дүгээр зүйлд ex post facto үйл ажиллагааг оруулсан ба албан тушаалтныг тухайн холбогдох асуудлаар чиг үүргээ хэрэгжүүлснээс, эсхүл чиг үүргээ хэрэгжүүлэхээс татгалзсаных нь дараа Авлигын талаар хэлэлцэн тохиролцоо хийснийг гэмт хэрэг гэж үзэх болсон. Тиймээс өмнө нь талуудын хооронд урьдчилсан тохиролцоо хийгдээгүй байсан ч хээл хахууль өгсөн үйлдэл нь хээл хахуулийн гэмт хэрэг болно.⁷
- Транспэрэнси интернэшнл байгууллага 2010 онд европын холбооны улсууд дахь авлигын хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа ямар нөлөө үзүүлсэн талаар судалгаа хийжээ. Судалгаанд хамрагдсан хэд хэдэн улсын хөөн хэлэлцэх хугацаа маш богино байсан бөгөөд энэ нь авлигын гэмт хэргийн мөрдөн байцаалт, яллах, шүүн таслах ажиллагаанд бодитой хүндрэл учруулж

⁵ Авлигатай тэмцэх гарын авлага, ЕАБХАБ, УБ., 2016 он, 204 дэх тал

⁶ <https://www.u4.no/publications/international-good-practice-in-anti-corruption-legislation>

⁷ [Авлигатай тэмцэх гарын авлага, ЕАБХАБ, УБ., 2016 он, 204 дэх тал](#)

байсан. Хэдийгээр шаардлагатай үед хугацааг уртасгах тодорхой алхам хийсэн ч ихэнх улс эрх зүйн харилцан туслалцаа гэх мэт олон улсын хамтын ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахад зориулан хугацааг сунгадаггүй байна. Түүнчлэн авлигын хэрэг дээр гүйцэтгэх санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа нь нарийн түвэгтэй, хугацаа их зарцуулдаг ажиллагаа юм. Нэлээд хэдэн улсад албан тушаалтан нийтийн албанаас халагдах, чөлөөлөгдөхөөс өмнө хөөн хэлэлцэх хугацаа дууссан байдгаас тус улс дахь халдашгүй дархан байдлын талаарх зохицуулалт асуудал учруулдаг байна. Хууль сахиулах, шүүх байгууллагын санхүүгийн хүрэлцээгүй байдал, хүний нөөц, дадлага туршлагын дутагдалтай байдал зэрэг хүчин зүйл мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажиллагаанд саад учруулж байгаа ба хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалт гол нөлөөлөх хүчин зүйл болж байгааг судалгааны тайланд өгүүлжээ. Судалгааны тайлан нь бодлого боловсруулагчдад хандан Авлигын гэмт хэрэгтэй холбогдуулан дотоодын хууль тогтоомж дахь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг дахин хянаж үзэхийг зөвлөөд дараахь зөвлөмжийг гаргажээ. Үүнд:

- Дотоодын хууль тогтоомжид авлигын гэмт хэргийн нийгэмд үзүүлэх аюулын хэр хэмжээг тодорхой тусгах;
- Авлигын хүнд, ноцтой гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 10 болон түүнээс олон жилээр тогтоох;
- Хөөн хэлэлцэх хугацааг тооцоолохдоо Авлигын хэргийн онцлогийг харгалзан үзэх;
- Улс дамнан үйлдэгдсэн хэрэг дээр тооцох хөөн хэлэлцэх хугацааг илүү уртаар тооцох;
- Улс төрчид, Засгийн газрын гишүүдийг ял шийтгэлээс чөлөөлөхгүй байх;
- Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх;
- Албан тушаалтны халдашгүй байдал болон хөөн хэлэлцэх хугацааны хамаарлыг харуулсан статистикийн системчилсэн мэдээлэл бий болгох зэрэг болно.⁸

⁸ Авлигатай тэмцэх гарын авлага, ЕАБХАБ, УБ., 2016 он., 211-212 дахь тал

Долоо. Зөвлөмж

Эрүүгийн хуульд оруулах шаардлагатай асуудлыг тусгахын тулд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах хувилбар хангагдахаар байна.

Тус хуулийн төсөлд дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

- Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн томъёолол, харилцан хамаарал, логик дарааллыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийг томъёолж буй аргачлалтай уялдуулж, тодорхойлолтыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх;
- Бага хэмжээний хахууль авсан, өгсөн, хохирол багатай, бага хэмжээний давуу байдал олгосон хэргүүдэд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэлийг хэрэглэх заалт тусгах;
- Өндөр албан тушаалтан, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, хахууль, давуу байдлын хэмжээ, хохирол ихтэй авлигын хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх зохицуулалт тусгах;
- Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг гэмт хэргийн хүнд, ноцтой байдал, түүний улмаас учирсан хохирлын хэмжээ, албан тушаалын байдалтай нь уялдуулан тогтоох зохицуулалтыг оруулах. Тухайлбал, гүйцэтгэх, удирдах албан тушаалтан үйлдсэн бол ялын доод хэмжээ нь тус тус өөр байхаар тогтоох;
- Хүндрүүлэх нөхцөлгүй авлигын хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг өөрчлөх;
- Улс төрийн болон өндөр албан тушаалтны үйлдсэн, хохирол, хахуулийн хэмжээ ихтэй авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх зохицуулалт тусгах;
- Гэм буруу нь тогтоогдсон нөхцөлд хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, хохирлыг нөхөн төлүүлэх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтны хугацаанаас өмнө суллах эсэх зохицуулалтыг тодруулах;
- Нийтийн албан тушаалтанд давуу байдал бий болгосон, мөн хууль бусаар давуу байдал олж авсан нийтийн албан тушаалтан биш этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгох;

- Авлигын гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгах;
- Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох талаар судалж, өөрчлөлт оруулах зэрэг болно.

Хавсралт

1.Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, хууль тогтоомжийн жагсаалт

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

- Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2012 он
- Солонгос ба Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тогтолцоо:тулгамдсан асуудал ба сорилт /Солонгос-Монголын эрдэм шинжилгээний бага хурал 2014 он
- Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ / Судалгааны тайлан/ Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2018 он
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авлигатай тэмцэх газар, 2018 он
- Тогтвортой хөгжлийн төлөө Авлигатай тэмцэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь:Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага /сургалт, семинарын товч тайлан/ Азийн сан, 2019 он
- Шударга байдал ба олон нийтийн итгэл /Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн/, Авлигатай тэмцэх газар, 2020 он
- Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны төсөл, 2021 он
- Авлигатай тэмцэх гарын авлага, европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, 2016 он

Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль, төрийн мэдээлэл эмхтгэл, 1992,№1
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2016,№7

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017, №23
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2015, №25
- Прокурорын тухай хууль, төрийн мэдээлэл эмхтгэл, 2017, №24
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2006, №35
- Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2021, №5
- Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017, №8
- Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2013, №30
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 1995, №7

2.Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
1.2. Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Нийтийн албан тушаалтан
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн авилгагүй нийгэмд амьдрах боломж нөхцөл нэмэгдэнэ.
1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Авлигын эсрэг конвенци, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын заалтад нийцэж байгаа.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хариуцлагын асуудал тусгагдана.

2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Авилгын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн асуудал тавигдана.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Энэ асуудал холбогдохгүй
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Энэ асуудал холбогдохгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй.

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Одоо байгаа хуульд заасан мэдээлэх тухай ажиллагаа хэвээр хадгалагдана. Иймд нэмэлт зардал гарахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр бий болгох з о х и ц у л а л т байхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон Улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон Улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр бий болохгүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлнө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн асуудлаа ш и й д в э р л ү ү л э х боломж нэмэгдэнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Авлигын гэмт хэргийн нөхцөл байдал нөлөөлнө.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, хуулийн төслийг боловсронгуй болгоход оршино.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”⁹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

⁹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийснээс гадна хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжийг туршсан байдалд дүн шинжилгээ хийлээ.

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур Үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан дараах зохицуулалтаас сонгон авч үр нөлөөг үнэлнэ. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн томьёолол, харилцан хамаарал, логик дарааллыг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийг томьёолж буй аргачлалтай уялдуулж, тодорхойлолтыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх;
2. Бага хэмжээний хахууль авсан, өгсөн, хохирол багатай, бага хэмжээний давуу байдал олгосон хэргүүдэд нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгэлийг хэрэглэх заалт тусгах;
3. Өндөр албан тушаалтан, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, хахууль, давуу байдлын хэмжээ, хохирол ихтэй Авлигын хэрэгт өршөөл, уучлал үзүүлэхгүй байх зохицуулалт тусгах;
4. Авлигын гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг гэмт хэргийн хүнд, ноцтой байдал, түүний улмаас учирсан хохирлын хэмжээ, албан тушаалын байдалтай нь уялдуулан тогтоох зохицуулалтыг оруулах;
5. Хүндрүүлэх нөхцөлгүй авлигын хэрэгт оногдуулах хорих ялын доод хэмжээг өөрчлөх;
6. Улс төрийн болон өндөр албан тушаалтны үйлдсэн, хохирол, хахуулийн хэмжээ ихтэй авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй байх зохицуулалт тусгах;
7. Гэм буруу нь тогтоогдсон нөхцөлд хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, хохирлыг нөхөн төлүүлэх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох;
8. Авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтны хугацаанаас өмнө суллах эсэх зохицуулалтыг тодруулах;

9. Нийтийн албан тушаалтанд давуу байдал бий болгосон, мөн хууль бусаар давуу байдал олж авсан нийтийн албан тушаалтан биш этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгох;
10. Авлигын гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгах;
11. Авлигын гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох талаар судалж, өөрчлөлт оруулах зэрэг болно.

Үр нөлөөг үнэлэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Практикт хэрэгжих боломж;
2. Ойлгомжтой байдал;
3. Зардал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллагын хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь хууль тогтоомжийн тухай хууль, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төсвөөс зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг зардлыг “хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх Хэсгийг тогтоосон байдал

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн дараах зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо. Үүнд:

Нэг. Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид оруулах зохицуулалт:

1. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл буюу гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэсэн зүйлийн 7 дах хэсэгт “авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш найман жил байх”-аар тусгасан байна.
2. Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйл буюу Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал гэсэн зүйлийн 1.9 дэх заалтад “албан тушаалын байдал, албаны эрх нөлөөгөө ашиглаж үйлдсэн” байх үйлдлийг хүндрүүлж авч үзэх зохицуулалт.
3. Эрүүгийн хуулийн 6.7 Дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” зохицуулалт нь “авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн”-д хамаарахгүй байх, 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох” зохицуулалт нь “авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтан”-д хамаарахгүй байх, 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж болох” зохицуулалтад “авлигын гэмт хэрэг үйлдсэн” бол хамаарахгүй байхаар тус тус тусгасан.

Хоёр. Эрүүгийн хуулийн тусгай ангид оруулах зохицуулалт:

1. Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Тайлбар: - энэ хуульд заасан “давуу байдал” гэж Авлигын эсрэг хуулийн 3.1.4-Т заасны дагуу уг хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг ойлгоно.

Энэ хуульд заасан “эрх бүхий этгээд” гэж мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадалгаа гаргах үйлчилгээ үзүүлэх этгээд, байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн болон эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгоно.” гэж тус тус тайлбарласан.

2. Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 22.4 дүгээр зүйл. Хахууль авах, 22.11 дүгээр зүйл. Албан тушаалтны нэр барих гэмт хэргүүдийг шинээр томьёолж өөрчлөн найруулсан.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5 дугаар хэсэг, 3 дугаар зүйлийг тус тус сонгон авлаа.

Дөрөв.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулья.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Практикт хэрэгжих байдал	<p>1/1.10 дугаар зүйлийн 7 дахь хэсэг: “7.Энэ зүйлийн 1.1, 1.2, 1.5-д хамаарах авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш найман жил байна.”</p> <p>2/6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9 дэх заалт: “1.9.албан тушаалын байдал, албаны эрх нөлөөгөө ашиглаж үйлдсэн.”</p> <p>3/6.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг: “6.Энэ зүйлийн 1-3 дахь хэсэг Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүнд хамаарахгүй.”</p> <p>4/6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсэг: “6.Энэ зүйлийн 1 дэх хэсэг авлигын гэмт хэрэг үйлдсэн ялтанд хамаарахгүй.”</p> <p>5/22.1 дүгээр зүйлийн тайлбар: “Тайлбар: - Энэ хуульд заасан “давуу байдал” гэж Авлигын эсрэг хуулийн 3.1.4-т заасны дагуу уг хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг ойлгоно. -Энэ хуульд заасан “эрх бүхий этгээд” гэж мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадалгаа гаргах үйлчилгээ үзүүлэх этгээд, байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн болон эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгоно.”</p> <p>Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, 6.14, 6.15 дугаар зүйл</p>	Практикт хэрэгжих боломжийг судлах

2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах
3	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ. Үүнд:

4.1. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ: (1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5 дугаар хэсэг, 2 дугаар зүйлийн ерөнхий ангид хамаарах хэсэг буюу эрүүгийн хуулийн 7.1 Дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, 6.14, 6.15 Дугаар зүйл)

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 2 дугаар зүйлд тусгасан Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлд “гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх”, “хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох” болон “хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж болох”, “өршөөл, уучлал үзүүлж ялаас чөлөөлөх” зохицуулалт нь авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, ялтан, хуулийн этгээдэд тус тус хамаарахгүй байхаар тусгажээ.

Мөн зүйлийн 1 дэх хэсэгт “авлигын гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш найман жил байх”-аар, албан тушаалын байдал, албаны эрх нөлөөгөө ашиглаж үйлдсэн” байх үйлдлийг хүндрүүлж авч үзэх зохицуулалт тусгасан байна.

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “...Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно” хэмээн заасан болон “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн шударга ёсны зарчмыг мөрдлөг болгон боловсруулсан байх тул практикт хэрэгжих боломжтой гэж үнэлэв.

Харин хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан Эрүүгийн хуулийн 22.1 Дүгээр зүйлийн тайлбар хэсэг буюу “Энэ хуульд заасан “давуу байдал” гэж Авлигын эсрэг хуулийн 3.1.4-т заасны дагуу уг хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн

этгээдэд бий болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг ойлгоно” гэснийг Авлигын эсрэг хуульд 3 дугаар зүйлийн 3.1.4 Дэх хэсэгт заасан давуу байдал гэсэн тодорхойлолттой, “Энэ хуульд заасан “эрх бүхий этгээд” гэж мэргэжил, тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт, магадалгаа гаргах үйлчилгээ үзүүлэх этгээд, байнга болон түр хугацаагаар байгуулагдсан хамтын шийдвэр гаргах чиг үүрэг бүхий хороо, комиссын гишүүн болон эдгээртэй адилтгах ажил, үйлчилгээ эрхэлж байгаа этгээдийг ойлгоно” гэснийг мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалттай тус тус уялдуулснаар тайлбар, тодорхойлолтыг нэг мөр ойлгож практикт хэрэгжих боломжтой байна.

4.2. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад санал өгсөн байгууллагуудын тухайд ойлгомжгүй байгаа зохицуулалтуудыг нэмж найруулсан байна.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Нэг	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.

4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Эшлэл хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн заасан.
8	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
9	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
10	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг дагаж Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байна.
11	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "... Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль энэ хуулийн бүрэлдэхүүн хэсэг болно" гэж заасан тул тусад нь зорилго заагаагүй.
Хоёр	Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
1	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
2	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
3	30.1.3.үг хэллэгийг Монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
4	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
5	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

4.3. “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёог тодорхойлж, тайлбар хийсэн байх бөгөөд энэ нь хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байна гэж үзсэн.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийг Авлигын эсрэг хуульд 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт заасан давуу байдал гэсэн тодорхойлолт, мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалттай уялдуулах шаардлагатай гэж үзлээ.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлага хангасан байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Шаардлагатай хэмжээнд тусгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардуулан тусгаагүй гэж үзсэн.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Шаардлагыг хангасан байна.

10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Татвар хураамж тогтоогоогүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Шаардлагыг хангасан байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон Улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь авлига, хүнд бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Шаардлага хангасан.

Тав.Үр дүн, зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд сонгон авсан практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, уялдаа холбоог шалгах, зардлын шалгуур үзүүлэлтээр хуулийн төсөлд тусгагдсан агуулгаар үр нөлөө гарна гэж үнэлсэн.

Энэхүү үнэлгээний ажлын явцад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж ярилцах, хэлэлцүүлэг зохион байгуулах, албан бичгээр санал авах, дотоодын болон гадаадын улс орны сайн туршлага бүхий хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэхээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон байна.

Хуулийн төсөл нь практикт хэрэгжих боломжтой, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөлд санал авч, ирүүлсэн саналыг тусган боловсруулж зарим зохицуулалтуудыг нэмж найруулсан байна.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг тодорхой тооцсон тул энэхүү үнэлгээний тайланд дүгнэлтийг тусгаагүй болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд хуулийн төслийг Эрүүгийн хуулийн зорилгод нийцүүлж боловсруулсан, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгаагүй байна гэж үзсэн.

Эдгээрийг нэгтгэн дүгнэж үзэхэд хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.

Харин хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийг Авлигын эсрэг хуульд 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт заасан давуу байдал гэсэн тодорхойлолт, мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалттай уялдуулахыг зөвлөмж болгож байна.

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

2021.12.06

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Энэхүү аргачлалд зааснаар хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардлыг, иргэнд үүсэх зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацааг тус тус тооцон гаргана.

Иймд аргачлалд заасны дагуу төрийн байгууллагын болон иргэн, хуулийн этгээдийн аль алинд холбогдох зардлыг тооцоолон гаргахыг зорилоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажиллаа. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;

- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

**Хоёр. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу
Улсын төсөвт үүсэх зардал**

Хуулийн төсөлд ямар нэгэн шинэ ялын төрөл нэмж тусгахгүй учраас хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль дээдлэх ёсны зарчимд нийцсэн, гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинд ахиц дэвшил гарах бөгөөд эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим бодитой хэрэгжинэ.

Гурав. Иргэнд үүсэх зардлын тооцоо

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцохдоо дараах үе шатыг баримтална. Үүнд:

1. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
2. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Гарах зардлын дүнг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: энэ хэсэгт Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг бүрчлэн судалж хуулийн төслөөр иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг тогтоож гарах зардлыг тооцсон.

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

Дөрөв. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу Улсын төсөвт үүсэх зардал

Энэ хэсэгт эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд тодорхой төрлийн үүрэг гүйцэтгэхийг даалгасан буюу шаардсан бол үүний дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах юм.

Ийнхүү үүсэх зардлыг засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 Дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- 1) Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох; ,
- 2) Нэг бүрийн зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах;
- 6) Нэмэлт зардлыг тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Хуулийн төслийг судлан үзэхэд хуулийн этгээдэд шууд үүрэг бий болгосон заалт байхгүй байна. Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

Тав. Дүгнэлт

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагалдан гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 Дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн судлан үзэхэд төсөл нь зардал тээгч гуравдагч этгээдэд зардал үүсгэх зохицуулалт агуулаагүй байна. Иймээс уг хуулийн төсөл нь улсын төсөвт ачаалал үүсгэхгүй. Улсын төсөвт ачаалал үүсгэхгүй тул зардлыг бууруулах талаар санал гаргаагүй болно.

2

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН, ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**



ТАНИЛЦУУЛГА

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн тухай

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, түүнд тусгагдсан эрх зүйн суурь зарчим, үзэл баримтлал, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн холбогдох заалт болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох, шүүхэд хандах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх зэрэг зарчимд нийцүүлж боловсрууллаа.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн Азийн сангийн судалгааны багаас практик хэрэглээнд гарч байгаа зөрчлийг арилгах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн заалтад нийцүүлэх чиглэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тодорхой зөвлөмжүүд өгснийг судалж хуулийн төсөлд тусгалаа.

Мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийцүүлж боловсрууллаа.

Одоогийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас өөрчилж, хуулийн төсөлд тусгасан нэмэлт, өөрчлөлтийг товч дурдвал:

- Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээр 39.1 дүгээр зүйлд нэмэлт оруулж, үүнтэй уялдуулан хуулийн 3.1 дүгээр зүйлд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн харьяалах асуудал дээр нэмэлт орууллаа.
- Хуулийн 4.1 дүгээр зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шаардлагатай гэж үзвэл хэд хэдэн прокурорын бүрэлдэхүүн бүхий хэсэг байгуулж ажиллаж болохоор, 6.3 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээнд мөрдөн шалгах хэсэг байгуулах, хэсгийн ахлагчийг томилох, мөрдөн шалгах хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэж болохоор тус тус тусгалаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

4.1 Болон 6.3 дугаар зүйлд шаардлагатай гэж үзвэл мөрдөн шалгах ажиллагаа явуулах даалгаврыг хэд хэдэн мөрдөгчид өгөх тухай заасан ба 34.7 дугаар зүйлд шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож болохоор зааж ажлын хэсгээр ажиллах үндэслэл хуульд тухайлан тусгагдсан байсныг үндэслэн, судалгааны багийн зөвлөмжид нийцүүлэн нэмсэн болно.

- Хуулийн 8.4 дүгээр зүйлд мэдээлэгчийг гэрч, хохирогчтой адил түвшинд хамгаалах талаар тусгалаа. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 33 дугаар зүйлд мэдээлэл өгсөн этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоондоо нэвтрүүлэх асуудлыг авч үзнэ хэмээн заасан.
- Хуулийн 34.7 дугаар зүйлд төр, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор прокурор иргэний нэхэмжлэл гаргахаар тусгасан боловч иргэний нэхэмжлэгчийн тухай 8.5 дугаар зүйлд тусгаагүй орхигдуулсан байх тул 8.5 дугаар зүйлд энэ тухай 15 дахь хэсэг нэмлээ.
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд уг хуулийн 6.15 дугаар зүйлд авлигын гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн хамтран ажиллах этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохоор заасанд нийцүүлэн 13.3 дугаар зүйлд нэмэлт орууллаа.
- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүх зөвхөн прокурорын саналын хүрээнд шийдэхээр байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалт хялбаршуулсан журам дээр шүүгчид хамаарахгүй байдал үүсгэж байгаа тул 17 дугаар зүйлд прокурорын саналыг харгалзан шийдвэр гаргахаар өөрчиллөө.
- Судалгааны багийн тайланд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдол, мэдээлэл шалгах хугацаа 5 хоног байгаа нь гомдолд дурдагдсан асуудлыг судлах, баримт, мэдээлэл цуглуулахад багадаа байгаа ба хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэрүүдийн агуулгаас үзэхэд 22 хувь нь гэмт хэргийн шинжтэй эсэхийг нь 5 хоногт багтаан шалгах боломж хязгаарлагдмал ээдрээ түвэгтэй мэдээлэл цуглуулах шаардлагатай хэргүүд байна гэжээ.

1963 Оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг 5 хоногийн дотор шалгаж шийдвэрлэхээр тусгасан ба энэхүү 5 хоногийн үндсэн хугацаа 2002 оны хууль болон 2017 оны Эрүүгийн хэрэг

хянан шийдвэрлэх тухай хуульд уламжлагдан 5 хоног хэвээр тусгагдсан. 1963 Оны нийгмийн байдал, гэмт хэргийн гаралтыг одоогийнхтой адилтгах аргагүй тул энэхүү хугацааг өөрчлөхөөр тусгасан болно.

- Авлигатай тэмцэх газраас гаргасан “Салбар хуулиудаар тогтоосон тодорхой албан тушаалтны халдашгүй байдалтай холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд тусгай журмаар зохицуулах” саналыг үндэслэн холбогдох хуулиудын заалтыг судалж үзэхэд төрийн зарим албан тушаалтны халдашгүй байх эрх, эрүүгийн хэрэг үүсгэх нөхцөл, хууль зүйн үндэслэлийг салбарын хуулиудад харилцан адилгүй заасан байна.

Иймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 Дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална” гэж заасныг үндэслэн холбогдох хуулиудын заалтыг нэгтгэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэг бүлэг болгон нэмж тусгалаа.

- 2020 Оны 1 дүгээр сарын 10-ны хуулиар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, мөрдөгч нь байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээлэл, баримт бичгийг прокурорын зөвшөөрөлгүйгээр авч болохоор заасан боловч хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 24.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт холбогдох өөрчлөлтийг оруулаагүйн улмаас практикт зөрчил үүсэж байсныг залруулах зорилгоор зохих өөрчлөлтийг тусгалаа.
- Прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлж, хохирол, хор уршгийг нэхэмжлэх зохицуулалтыг холбогдох хуультай уялдуулах чиглэлээр өгсөн зөвлөмжийн хүрээнд судалж үзэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 8-д, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-д төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл иргэний нэхэмжлэл гаргахаар заасан.

Прокурорын тухай хуулийн 20.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно.” гэж заасан боловч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.1.3-т

эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар, эсхүл ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр орохыг хориглосон байна.

Прокурорын тухай хуулийн дээрх заалтад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний нэхэмжлэл гаргах тухай заагаагүй байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 8-д заасантай нийцэхгүй байна.

Иймээс практик ажиллагаанд саад учруулж буй хууль хоорондын зөрчлийг арилгах зорилгоор Прокурорын тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай дагах хуулийн төсөл боловсруулсан.

Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авах, татгалзах ажиллагааг багаар шийдвэрлэх зөвлөмжийн дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагах хуулийн төсөл боловсрууллаа.

БАТЛАВ.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Тухайн улсын эрүүгийн эрх зүйн тогтолцооны шударга байдал нь хууль зүйн тогтолцоо нь бүхэлдээ шударга эсэхийг үнэлэх шалгуур болдог байна. Орчин цагийн нийтлэг чиг хандлагыг тодорхойлсон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмуудыг хэрэгжүүлэхэд манайд уламжлагдан бүрэлдэн тогтож ирсэн энэ чиглэлийн онол, үзэл баримтлал үүнээс улбаалсан гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, түүнд шударга ял шийтгэл оногдуулахад чиглэсэн тогтолцоо, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын чиг үүргийн хуваарилалтыг өөрчлөн боловсронгуй болгох зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг шинэчлэн, өөрчлөлт оруулсаар байгаа билээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөгдсөн ба тус хуульд өнгөрсөн хугацаанд 7 удаа өөрчлөлт оржээ. Үүнээс ихэнх өөрчлөлт нь шинэчлэн найруулсан болон шинээр батлагдсан бусад хуульд нэр томьёо, тодорхойлолт нийцүүлэх чиглэлээр орсон байна.

Дээрхээс үзэхэд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар холбогдох зарим хуультай харьцуулахад тус хууль нь харьцангуй тогтвортой хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна. Хуульд өөрчлөлт оруулах давтамж, хугацааг Хууль тогтоомжийн тухай хуульд тусгайлан заагаагүй ба хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байдаг. Тухайлбал, хуулийн 24.1-д “Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хуулийг бүхэлд нь эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Авлигагүй засаглал” гэсэн 5.6 дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэжээ.

Монгол Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т:

“4.4.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ” гэж, “4.4.7.Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр заасан.

Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн судалгааны баг “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ” хийж, Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах зөвлөмж гаргасан ба уг ажлын хүрээнд явуулсан судалгааны хүрээнд асуумж судалгаа авах, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа шийдвэрийг судлах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, дотоодын хууль тогтоомж судлах зэрэг ажлыг гүйцэтгэсэн.

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулах талаархи зөвлөмжийг үзэхэд хөөн хэлэлцэх хугацааг тоолох, эрүүгийн хариуцлага оногдуулах хуулийн зохицуулалт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах журамтай холбоотой зарим асуудал нь Авлигын хэргийн шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 болон 13 дугаар зүйлд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан байх талаар заасныг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг тогтоосон тандан судалгааны тайлан гарсан.

2017 Онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох талаар төр засгийн бодлого шийдвэрт тусгасан чиглэл, зорилт болон зохих байгууллагуудын зүгээс хийсэн хуулийн зохицуулалтыг өөрчлөх үндэслэлийг нотлон харуулсан судалгааны үр дүн болон үүссэн асуудлыг зөвхөн хуульд тусгах замаар шийдвэрлэх боломжтойг тогтоосон тандан судалгааны тайлан, хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалт зэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага болж байна.

Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Шаардлагатай өөрчлөлтийн цар хүрээнд тохируулан хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.1-д заасны дагуу “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” төрлийг сонгон хуулийн төслийг боловсруулна. Хуулийн төслийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийцүүлж боловсруулна.

Хуулийн төслийн бүтэц нь зүйл, хэсэг, заалтаас бүрдэнэ. Зүйл, хэсэг, заалт нь дараахь дарааллаар байрлана. Үүнд:

- А/ хуульд нэмэлт оруулах зүйл, хэсэг, заалт;
- Б/ хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад үг өгүүлбэр нэмэх;
- В/ хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах;
- Г/ хуулийн зарим зүйл, хэсэг, заалтын нэр томъёо, үг, өгүүлбэрийг өөрчлөх;
- Д/ хуулийн зарим зүйлээс хасах хэсэг, заалт, үг, өгүүлбэр;
- Е/ хүчингүй болгох зүйл, хэсэг, заалт.

Хуулийн төсөлд дараахь өөрчлөлтийг тусгана:

- Гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шалгах хугацаанд өөрчлөлт оруулах;

- Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэхдээ шүүх нь прокурорын саналыг харгалзан шийдвэрлэдэг байхаар зохицуулах;
- Авлигын хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийддэг байхаар хуульд өөрчлөлт оруулах;
- Салбар хуулиудаар тогтоосон тодорхой албан тушаалтны халдашгүй байдалтай холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн нэг бүлэг болгох;
- Тухайн ажиллагааг нөхөн гүйцээх боломжгүй бол шүүх хуралдааныг хойшлуулж, дутуу ажиллагааг заасан хугацаанд хийж гүйцэтгэхийг прокурорт даалгадаг зохицуулалт тусгах;
- Хохирогч, нэхэмжлэгч тогтоогдоогүй тохиолдолд хохирогч, нэхэмжлэгийн эрхийг хөндлөнгийн, хараат бус этгээдэд шилжүүлж болох заалтыг тусгах;
- Прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлж, хохирол, хор уршгийг нэхэмжлэх зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хуультай уялдуулах;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажилласан этгээдийн эрүүгийн хариуцлагыг хөнгөлөх, чөлөөлөх үндэслэлийг тусгах;
- Хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргийг харгалзан мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон прокурорын байгууллага тус бүртээ чиг үүргийн хүрээнд багаар ажиллаж болох зохицуулалтыг тусгах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдээлэл, баримт бичгийг мөрдөгч бие даан авах боломжтой холбоотой заалтуудыг хооронд нь нийцүүлж, тодорхой болгох;
- Мэдээлэгчийг гэрч, хохирогчтой адил хамгаалах зохицуулалт тусгах.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх Арга хэмжээний санал.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй ба нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй. Хуулийн төслийн зохицуулалт нь гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд бодит үнэнийг тогтоохын тулд асуудлыг тал бүрээс нь нягтлан хянаж шийдвэрлэх зорилгод нийцнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж мөрдөгдсөнөөр авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа боловсронгуй болж, авлигын гэмт хэргийг шийдвэрлэх эрх зүйн орчинг сайжруулах талаар гарсан төр засгийн бодлого, шийдвэр хэрэгжих боломж бүрдэж, олон Улсын хэм хэмжээнд нийцнэ.

**Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр
боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох
хуулийн талаар**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуультай нийцсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан Прокурорын тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль зэрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тус тус боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын... -ны өдөр

Улаанбаатар хот

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь бүлэг, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4.1 дүгээр зүйлийн 2.24 дэх заалт:

“2.24. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэд хэдэн прокурорын бүрэлдэхүүн бүхий хэсэг байгуулж ажиллах;”

2/8.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Энэ хуулийн 30.2 дугаар зүйлийн 1.1-д заасан мэдээлэгчид энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарна.”

3/8.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:

“15. Төр, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргана.”

4/16.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг:

“16. Эрүүгийн хэрэгт хамаарах нотлох баримтыг тухайн хэргийг хянан шийдвэрлэх хүртэл нийтэд ил болгохгүй.”

5/33.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалт:

“1.4. Энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.6-д заасан хүсэлтийг шийдвэрлэхтэй холбогдон хэргийн зүйлчлэлийг өөрчлөх бол”

6/39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:

“9. Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.”

7/Дөчин зургадугаар бүлэг:

"Дөчин зургадугаар бүлэг.Төрийн зарим албан тушаалтанд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

46.1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын гишүүн

1.Улсын Их Хурлын гишүүнийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчилсан, гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бол Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын их хуралд оруулна.

2.Эрх бүхий байгууллага гишүүнийг энэ хуулийн 1 дэх хэсэгт заасны дагуу баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 3 цагийн дотор мэдэгдэнэ.

3.Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэсэн шийдвэрийг Улсын Их Хурал гаргасан бол баривчлагдсан гишүүнийг Улсын Их Хурлын шийдвэр гарснаас хойш нэг цагийн дотор суллана.

4.Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлсэн үндэслэл арилсан талаар эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэгдсэн хуралдаанд Улсын ерөнхий прокурор уншиж танилцуулна.

5..Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

46.2 Дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн

1.Ерөнхий сайдыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, уналгад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

2.Засгийн газрын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Ерөнхий сайдад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр орон, уналга, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно;

46.3 Дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцийн гишүүн

1. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай үндсэн хуулийн цэцэд мэдэгдэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Цэцийн зөвшөөрөлгүйгээр Цэцийн гишүүнийг баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хориглоно.

3. Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг энэ тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэрийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор Цэц хэлэлцэж шийдвэрлэнэ.

46.4 Дүгээр зүйл. Шүүгч

1. Шүүгчийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай баривчилсан бол энэ тухай Сахилгын хороонд 48 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Сахилгын хороо шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг ажлын хоёр өдрийн дотор хуралдаанаараа шийдвэрлэнэ.

46.5 Дугаар зүйл. Прокурор

1. Прокурорыг гэмт хэрэг үйлдэж байхад нь, эсхүл гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хангалттай үндэслэл тогтоогдсон бол энэ тухай Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчид, бусад прокурорын талаар Улсын ерөнхий прокурорт 24 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч, эсхүл улсын ерөнхий прокурор ажлын 10 өдрийн дотор прокурорыг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

3. Прокурорт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахтай холбогдуулан түүний бүрэн эрхийг Улсын ерөнхий прокурор түдгэлзүүлж болно.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр, бусад прокурорыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, тээвэр, холбооны хэрэгсэл, өөрийнх нь мэдэлд байгаа

баримт бичиг, ачаа тээш, бусад эд хөрөнгө, захидал, харилцаа, хувийн нууц, биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

46.6 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын алба хаагч

1. Авлигатай тэмцэх газрын алба хаагчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргын талаар Улсын Их Хуралд, бусад албан хаагчийн талаар Авлигатай тэмцэх газрын даргад 48 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Авлигатай тэмцэх газрын алба хаагч гэмт хэрэгт холбогдсон, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу баривчлагдсан бөгөөд эрх бүхий байгууллагаас түүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай санал тавьсан бол түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Авлигатай тэмцэх газрын дарга шийдвэрлэнэ.

3. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр, бусад алба хаагчийг Авлигатай тэмцэх газрын даргын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

46.7 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагч

1. Цагдаагийн төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд, бусад алба хаагчийг цагдаагийн төв байгууллагын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ биелүүлсэнтэй нь холбогдуулан төрийн эрх бүхий байгууллагаас шалгасан, баривчилсан, цагдан хорьсон, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийсэн бол шууд удирдах даргад нь даруй мэдэгдэнэ.

46.8 дугаар зүйл. Тагнуулын ажилтан

1. Тагнуулын ерөнхий газрын дарга, дэд даргыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол Монгол Улсын Ерөнхий сайдад, бусад ажилтныг тагнуулын ерөнхий газрын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Тагнуулын ерөнхий газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхий сайдын, Тагнуулын ажилтныг тагнуулын ерөнхий газрын даргын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

3. Тагнуулын ажилтан гэрч, хохирогчийн хувиар ажил үүрэгтэй холбоотой нууцад хамаарах асуудлаар мэдүүлэг өгөх тохиолдолд Тагнуулын ерөнхий газрын даргаас зөвшөөрөл авна.

46.9 дүгээр зүйл. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн

1. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байх үед нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Хорооны гишүүнийг сонгуулийн үүрэгт ажилтай нь холбогдуулан баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь нэгжлэг хийхийг хориглоно.

46.10 дугаар зүйл. Монгол банкны ерөнхийлөгч

1. Монгол банкны Ерөнхийлөгчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд Монгол банкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, гэр орон, уналга, албан тасалгаа, биед нь нэгжлэг хийхийг хориглоно.

46.11 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн гишүүн

1. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад буюу хэргийн газар гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

46.12 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагч

1. Монгол Улсын Ерөнхий аудиторыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

2. Монгол Улсын Ерөнхий аудиторт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын санал болгосноор Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд түүнийг албадан саатуулах, цагдан хорих, баривчлах болон шүүхийн журмаар захиргааны

шийтгэл оногдуулах, орон байр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

4.Монгол Улсын Ерөнхий аудиторыг Улсын Их Хурлын зөвшөөрлөөр, төрийн аудитын байгууллагын бусад албан хаагчийг Монгол Улсын Ерөнхий аудиторын зөвшөөрлөөр гаргасан аудитын тайлан, дүгнэлттэй нь холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан гэрчийн мэдүүлэг авч болно.

5.Монгол Улсын Ерөнхий аудитор, төрийн аудитын байгууллагын бусад албан хаагчийг албан үүргийнхээ дагуу гаргасан аудитын тайлан, дүгнэлт болон гүйцэтгэж байгаа аудитын талаар өөрийг нь холбогдуулан эрүүгийн, зөрчлийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж үл болно.”

2 Дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1 Дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шийдвэрлэнэ” гэсний дараа “Хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг анхан шатны журмаар, хянан шийдвэрлэнэ.” Гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “шийдвэрлэнэ” гэсний дараа “Давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” Гэж, 4.1 Дүгээр зүйлийн 2.18 Дугаар заалтын “бол” гэсний дараа “мөрдөн байцаалтын” гэж, 6.3 Дугаар зүйлийн 1.2 Дахь заалтын “даалгах” гэсний дараа “мөрдөн шалгах хэсэг байгуулах, хэсгийн ахлагчийг томилох, мөрдөн шалгах хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах” гэж, 13.3 Дугаар зүйлийн 1.1 Дэх заалтын “хэргийг” гэсний дараа “болон Авлигын гэмт хэргийг” гэж, 22.1 Дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “шинжлэх” гэсний дараа “байгууллага, хувь хүний нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий” гэж тус тус нэмсүгэй.

3 Дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.5 Дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “прокурорын шийдвэрт” гэснийг хассугай.

4 Дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 Дүгээр зүйлийн заалтын дугаар “2.24” Гэснийг “2.25” Гэж, 17.4 Дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “саналын хүрээнд” гэснийг “саналыг харгалзан” гэж, 30.7 Дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “5” гэснийг “10” гэж, 34.7 Дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “эрх ашгийг” гэснийг “ашиг сонирхлыг” гэж, бүлгийн дугаарыг “ДӨЧИН ЗУРГАДУГААР” гэснийг “ДӨЧИН ДОЛДУГААР” гэж тус тус өөрчилсүгэй.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

/Зөвлөх Лодойн Мөнхцэцэг/

2021 оны ... дугаар сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 Дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.1.14 дэх заалт нэмсүгэй:

“29.1.4.Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлж байгаа тохиолдолд энэ зүйлийн 29.1.3 дахь заалт хамаарахгүй”

2 Дугаар зүйл. Энэ хуулийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 Дүгээр зүйл.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

“11.3.Төрийн байгууллага бүр зохих нэгжээс төлөөлөл оролцуулж, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авах, татгалзах эсэхийг хэлэлцэх чиг үүрэг бүхий хамтарсан бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна.”

2 Дугаар зүйл.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “болно” гэсний дараа “Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авахгүй тАТГалзах, буцаах шийдвэрийг албан тушаалтан ганцаарчлан гаргахыг хориглоно.” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “бол” гэсний дараа “энэ хуулийн 11.3-Т заасан багт танилцуулж” гэж нэмсүгэй.

3 Дугаар зүйл.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“4.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллага нь багаар хэлэлцэж, хүлээж авах, татгалзах эсэхийг шийдвэрлэнэ.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан өргөдөл, гомдол гаргагчийг багаар хүлээн авч уулзаж болно.”

4 Дүгээр зүйл.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

5 Дугаар зүйл.Энэ хуулийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын...- ны өдөр

Улаанбаатар хот

Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай

1 Дүгээр зүйл.Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 Дэх хэсгийн “оролцоно” гэсний дараа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргаж, гаргасан нэхэмжлэлийг дэмжиж оролцоно.” Гэж нэмсүгэй.

2 Дугаар зүйл.Энэ хуулийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

Ерөнхий мэдээлэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь нийгмийн хөгжлийн чиг хандлагатай холбоотойгоор шинэчлэн өөрчлөгдөж, процессын эрх зүйн салбарын уламжлалыг хадгалан боловсронгуй болсоор ирсэн. Эрүүгийн байцаан шийтгэх анхны хууль 1926 онд “Шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх хууль”¹⁰ нэртэй батлагдан мөрдөгдөж байсан ба үүнээс хойш эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэд хэдэн шинэчилсэн найруулга батлагдаж, холбогдох нэмэлт, өөрчлөлт орсоор иржээ.

Хуульд өөрчлөлт оруулах давтамж, хугацааг хууль тогтвортой үйлчилж байх зарчмын үүднээс шүүмжлэх хандлага байдаг хэдий ч нийгмийн харилцааны хөгжил, түргэн өөрчлөгдөж буй улс орны нийгэм, эдийн засгийн байдал, нэгдэн орсон олон Улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх явдал, хуулийг сайжруулан хэрэгжүүлэх хэрэгцээ нөлөөлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Авлигагүй засаглал” гэсэн 5.6 дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, **зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат болох 2021-2030 онд** авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлж, **хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан. Тухайлбал**, авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэжээ.

¹⁰ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/, УБ.,2012, 28 дахь тал

Монгол Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т:

“4.4.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ” гэж, “4.4.7.Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр заасан.

Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн судалгааны баг “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ”¹¹ хийж, Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах зөвлөмж гаргасан.

2017 Онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох талаар төр засгийн бодлого шийдвэрт тусгасан чиглэл, зорилт болон зохих байгууллагуудын зүгээс боловсронгуй болгох үндэслэлийг нотлон харуулсан судалгааны үр дүнг судалж үзэхэд энэхүү хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах шаардлага байна.

¹¹ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, УБ, 2021

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын ¹² /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

Нэг.Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

1.Одоогийн даган мөрдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байна. Энэхүү хуульд 2019 онд 4 удаа, 2020 онд 2 удаа, 2021 онд 1 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.

Өнөөдрийг хүртэл уг хууль хэрэгжих хугацаанд Авлигын хэргийг шийдвэрлэсэн байдалд судалгаа хийсний дүнд зарим зохицуулалтыг нарийвчлах, нэмэлт оруулах асуудал үүссэн байна. Тухайлбал, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ хийж, авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хууль, эрх зүйн орчин, байгууллагын чадвар, чадамж, практикт гарч байгаа бэрхшээлтэй асуудлыг тодорхойлох, боловсронгуй болгох, сайжруулахад чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулсан.

Судалгааг Азийн сангийн судалгааны баг дээрх байгууллагуудын хамтран баталсан арга зүйн дагуу 2020 оны 1 сарын 10-наас мөн оны 9 сарын 17-ны хооронд гүйцэтгэжээ.

Судалгааны хүрээнд асуумж судалгаа авах, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, шийдвэр судлах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, дотоодын хууль тогтоомж судлах зэрэг ажлыг гүйцэтгэсэн ба тоон болон чанарын дүн шинжилгээ нь сүүлийн 3 жилийн хугацааг хамарсан бөгөөд 2017-2019, мөн 2020 оны эхний улирлын мэдээлэл, баримтуудыг хамруулжээ. Судалгааны зөвлөмжүүдийг одоогийн эрх зүйн орчин, нийтлэг ойлголт, тогтсон практикийн хүрээнд хязгаарлалгүйгээр онол практикийн хувьд боломжтой гэж үзсэн, хэрэгжүүлж болохуйц бүх саналыг багтаах зарчим баримталсан байна.

¹² Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулах талаархи зөвлөмжийг үзэхэд хөөн хэлэлцэх хугацааг тоолох, эрүүгийн хариуцлага оногдуулах хуулийн зохицуулалт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах журамтай холбоотой зарим асуудал нь Авлигын хэргийн шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлж байна гэжээ. Энэ хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал нь хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр гаргах процесст тавих хяналтыг нэмэгдүүлэх, шүүгчийг авлигын хэрэг шийдвэрлэх чиглэлээр мэргэшүүлэх, түүнчлэн хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эсхүл хэрэгсэхгүй болгох хэргийн тоог цөөрүүлэх талаар процессын зохицуулалтыг өөрчлөн сайжруулах чиглэлээр байна.

Иймд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 3-т заасны дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, уг асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1. Эрүүгийн чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Авлигатай тэмцэх ажлыг сайжруулах талаар гарсан Монгол Улсын Их хурал болон засгийн газрын тогтоол, шийдвэр, “шударга байдал ба олон нийтийн итгэл” сэдвээр 2019 онд болсон хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөний илтгэлүүд, мөн 2019 онд Азийн сангаас Бүгд Найрамдах Солонгос Улсын Хөгжлийн институт, Канад улсын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан “тогтвортой хөгжлийн төлөө авлигатай тэмцэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь: Бүгд Найрамдах Солонгос Улсын сайн туршлага” сэдэвт сургалтын материал, 2020 онд Авлигатай тэмцэх газраас гаргасан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдүгээр үе шатны хэрэгжилтийн тайлан”, 2021 онд Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны төслөөс гаргасан “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан” болон энэхүү асуудлын талаар эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгааны ажил, нийтлэл зэргийг судалж үзсэн болно.

“Транспаренси Интернэшнл” олон улсын төрийн бус байгууллагаас жил болгон боловсруулдаг улс орны төрийн албан дахь Авлигын талаар шинжээч, бизнес эрхлэгчдийн төсөөлөлд үндэслэн гаргадаг Авлигын төсөөллийн индексийн 2020 оны дүнгээр Монгол Улс 2020 онд 35 оноо

авч 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оныхтой ижил оноотой боловч 5 байраар ухарсан үзүүлэлт болжээ.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь нэг талаас гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үр дүнтэй явуулах нөхцөлийг бий болгож, нөгөө талаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болж буй иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зохих баталгааг бүрдүүлж өгдөг.

Мөн хуульд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг эрх хэмжээг тогтоодог ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албадлагын арга хэмжээний төрөл хэрэглэх үндэслэл нөхцөлийг тодорхойлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч, бусад оролцогчдын тухайлбал яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах, хувийн ба захидал харилцааны нууц, орон байр халдашгүй байх, шударга шүүхээр шүүлгэх зэрэг үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг нь баталгаажуулдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн хувьд сөргөөр нөлөөлөх байдлыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэн	Гомдол, мэдээллийг нэр хаяггүйгээр өгөх боломжийг хуульчлаагүйгээс тухайн хэрэгт хувийн сонирхолгүй боловч бусдын эрх ашгийг хамгаалах сэдлээр мэдээлэл өгсөн иргэн зарим тохиолдолд мэдүүлэг өгөхөөс татгалзах, мэдүүлгээсээ буцах, өөрчлөх асуудал гарч байгаа нь мэдээлсэн, гэрчилснээс үүдэн өөрт нь үүсэж болох эрсдлээс айх, болгоомжлох явдлаас болж байна.
2	Хохирогч	Авлигатай тэмцэх газар болон бусад эрх бүхий байгууллагад хохирогчийн өгч байгаа өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах үндсэн хугацаа нь бага байдгаас тэдний өгсөн өргөдөл, гомдлыг хүлээн авахаас татгалзах, эсхүл түүний дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах асуудлыг хувь хүний саналаар шийдэж байгаа нь хохирогчийн зүгээс гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх эрхийг зөрчиж байна.

3	Яллагдагч	Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажилласан яллагдагчийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг хуульд тусгаагүйгээс Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажилласан яллагдагчийн хувьд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөлөх асуудал орхигдож байна.
4	Мөрдөгч, прокурор	Мөрдөгч, прокурор багаар ажиллах зохицуулалт хуульд тодорхой тусгаагүйгээс авлигын гэмт хэргийн ээдрээ түвэгтэй байдлаас болж, хагас дутуу шалгах, хэрэг шүүхээс буцах тохиолдол гарч тэдний ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.
5	Шүүгч	1/ Авлигын хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхдээ шүүх зөвхөн прокурорын саналын хүрээнд, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр шийдэхээр байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэсэн заалт хялбаршуулсан журам дээр шүүгчид хамаарахгүй байдал үүсгэж байна. 2/ Авлигын хэргийг шийдэхэд хөндлөнгийн нөлөөлөл ирэх, энэ нь шүүгчийн сэтгэл зүй, дотоод итгэл үнэмшилд нөлөөлөх магадлалтай. Түүнчлэн, ээдрээ төвөгтэй хэргийг шүүгч дангаар шийдвэрлэх үед мэдлэг, туршлага дутах нөхцөл байдал үүсэх боломжтой байна.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах, хэргийн бодит байдлыг тогтоох, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмууд бүрэн хангагдахгүй байх магадлалтай.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Холбогдох мэдээллийг харьцуулан дүгнэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн явцад шийдвэл зохих асуудал байсаар байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах үзэл санаанд суурилсан орчин үеийн суурь зарчмуудыг хуульчлан суулгасан билээ. Орчин цагийн нийтлэг чиг хандлагыг тодорхойлсон эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны суурь зарчмуудыг хэрэгжүүлэхэд манайд уламжлагдан бүрэлдэн тогтож ирсэн энэ чиглэлийн онол, үзэл баримтлал үүнээс улбаалсан гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, түүнд шударга ял шийтгэл оногдуулахад чиглэсэн тогтолцоо, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын чиг үүргийн хуваарилалтыг өөрчлөн боловсронгуй болгох зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг шинэчлэн, өөрчлөлт оруулсаар байгаа билээ.

Хэдий тийм ч 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, энэ хугацаанд түүнд орсон нэмэлт, өөрчлөлт нь авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэж чадаагүй байна.

Азийн сангийн судалгааны багаас хийсэн тоон судалгааны үзүүлэлтээс харахад Авлигатай тэмцэх газар 2017-2019 оны дунджаар жилд ойролцоогоор 1541 гомдол мэдээлэл хүлээн авчээ. Үүнээс дунджаар 51.3% Буюу 792 гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэж Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс үргэлжлүүлэн шалгажээ. Өөрөөр хэлбэл жилд 749 гомдол, мэдээлэл гэмт хэргийн шинжгүй учир бусад хэлтэст шилжсэн байна.

Хүлээн авсан гомдол, мэдээллийг Авилгатай тэмцэх газрын өргөдөл, гомдлын бүртгэл хариуцсан ажилтан гэмт хэргийн шинжтэй эсэхийг хянаж, санал гаргасны дагуу, Авилгатай тэмцэх газрын дарга танилцсанаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаанд шилжүүлэх эсэхийг шийдэж байна. Өргөдөл, гомдол хүлээн авах, татгалзах ажиллагааг хязгаарлагдмал тооны албан тушаалтнуудын хүрээнд хийж байгаа нь байгууллагын ажилтан, албан хаагчид болон иргэд, олон нийтийн тус байгууллагад итгэх итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Тиймээс олон Улсын сайн туршлагын дагуу гомдол, мэдээллийг хороо эсхүл ижил төстэй механизм ашиглан хянан үзэх ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай. Авилгатай тэмцэх газрын мөрдөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр уг ажиллагааг олон талт оролцоо бүхий хороогоор шийдэж байх саналыг дэвшүүлж байв.

Судалгааны хүрээнд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан мөрдөгчийн 202 саналыг судалж, ажиглагдсан асуудлыг багцлан холбогдох дүгнэлт хийжээ. Эдгээр 202 саналаас татгалзсан үндэслэл тодорхой бичигдсэн 179 саналыг үзэхэд татгалзсан үндэслэлийн 68.7%-ийг гэмт хэргийн шинжгүй, 13.4%-ийг урьд хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй гэсэн шалтгаан эзэлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гомдол, мэдээлэл шалгах үндсэн хугацаа 5 хоног байгаа нь мөрдөн шалгах ажиллагааны чанарт нөлөөлж байж болзошгүй байна. Өөрөөр хэлбэл гомдолд дурдагдсан асуудлыг судлах, холбогдох, баримт, мэдээлэл цуглуулахад энэ хугацаа багадааар байна. Татгалзсан шийдвэрүүдийн агуулгаас үзэхэд ойролцоогоор 22% нь нь гэмт хэргийн

шинжтэй эсэхийг нь 5 хоногт бүрэн шалгах боломж хязгаарлагдмал ээдрээ төвөгтэй, мэдээлэл цуглуулах шаардлагатай хэргүүд байв.

Ийм тохиолдолд мөрдөгч багагүй хэмжээний мэдээлэл цуглуулж, хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр зэргийг судалж байгаа боловч, гэмт хэргийн шинжийг тогтооход шаардлагатай ажиллагааг хангалттай хийж амжихгүй байгаа нь татгалзсан шийдвэрүүдийг судалж үзэхэд харагдаж байна. 2020 Оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр энэ хугацааг шаардлагатай бол 14 хоногоор сунгах боломжтой болсон. Гэвч олон хэргийн хувьд 5 хоног хангалтгүй байгаа нөхцөлд энэ нь сунгалт хийгдэх, мөрдөгч хугацаанд шахагдах нөхцөлийг бий болгож байна.¹³

2017-2019 Оны хугацаанд www.shuukh.mn-д нээлттэй байгаа шийдвэрүүдээс судлахад 248 хүнд холбогдох 119 Авлигын хэргийг шүүхээр шийдвэрлэснээс 95 хэрэгт холбогдох 203 хүнд ял шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн байна.

Дээр дурдсан судалгаанаас үзэхэд сүүлийн 3 жилд шийдсэн Авлигын хэргийн тоог шийдсэн шүүгчийн тоонд хувааж үзэхэд нийслэлийн нэг шүүгч дунджаар 2 Авлигын хэрэг, орон нутгийн нэг шүүгч дунджаар 1.4 Хэрэг шийдсэн байна. Шүүхийн шийдвэрт хийсэн судалгаанаас үзэхэд 3 жилийн хугацаанд нийт 69 шүүгч Авлигын хэрэг шийдсэн бөгөөд үүнээс 72.4% нь зөвхөн 1 хэрэг шийдсэн бол 30% нь 2-3 хэрэг шийдсэн байна. Шүүхийн шийдвэрийг судалж үзэхэд, Авлигын хэрэг цөөн шийдэж байгаа шүүгч нар илүү хүнд ял оногдуулах, харин олон шийддэг шүүгч нар илүү зөөлөн шийдэх хандлага ажиглагдлаа. Хэдийгээр хэргийг программаар хуваарилж байгаа боловч, хэргийн төрөл, ээдрээ төвөгтэй байдал зэргийг харгалзан тодорхой шүүгчид хэрэг хуваарилах практик байна. Тодруулбал, нийслэлд шийдэгдсэн авлигын хэргийн 63%-ийг 15 шүүгч шийдсэн байх бөгөөд нэг шүүгчид дунджаар 4 хэрэг ногдож байна.

Азийн сангийн судалгааны багаас явуулсан өөрийн үнэлгээний судалгаанд оролцогчдын 68.5 Хувь нь (мөрдөгчийн 94.4%, Прокурорын 70%, шүүгчдийн 41.3%) Мөн ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын олонхи нь дагнасан шүүх, эсхүл дагнан шийдвэрлэх мэргэшсэн шүүгчтэй байх нь ач холбогдолтой гэж үзэж байна. Судалгаанаас үзэхэд шийдвэрлэгдсэн Авлигын хэргийн 93%-ийг шүүгч дангаар шийдвэрлэсэн байна. Харин эдгээр хэргийн 7%-ийг өндөр албан тушаалтан холбогдсон, ээдрээ төвөгтэй

¹³ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, УБ,2021, 16-21 дэх тал

хэргүүд эзэлж байна. Авлигын хэргийг шийдэхэд хөндлөнгийн нөлөөлөл ирэх, энэ нь шүүгчийн сэтгэл зүй, дотоод итгэл үнэмшилд нөлөөлж болзошгүй тул авлигын тодорхой хэргийг бүрэлдэхүүнтэй шийддэг байх нь зүйтэй байхаар байна. Түүнчлэн, ээдрээ төвөгтэй хэргийг шүүгч дангаар шийдвэрлэх үед мэдлэг, туршлага дутах нөхцөл байдал бодитой байгаа нь шүүгч нартай хийсэн ярилцлагаас харагдаж байна.¹⁴

Ийнхүү дүгнэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжоо цаашид боловсронгуй болгох, дээр дурдсан чиглэлээр үзэл баримтлалаа тогтоож, хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар тодорхойлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах зорилго нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх, хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан тул Аргачлалын 5.4.4-т заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон болно.

Энэ тохиолдолд асуудлын мөн чанар, цар хүрээг харгалзан үзсэний үндсэн дээр одоо үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.1-д “Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хуулийг бүхэлд нь

¹⁴ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, УБ,2021, 38--42 дахь тал

эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна” гэж заасныг баримталсан болно.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь цаг хугацаа, орон зайн хувьд харилцан хамааралтай хэрэгжих шаардлагатай учраас “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан”-д дурдсан зөвлөмжийн дагуу боловсруулах эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нийцүүлэн боловсруулах шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахтай уялдан Прокурорын байгууллагын тухай, Авлигын эсрэг зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр нэмэлт оруулах хэрэгцээ, шаардлага байна.

Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах нь зүйтэй болно.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөлд ямар нэгэн шинэ байгууллага, нэгж бий болгохоор нэмж тусгахгүй бөгөөд холбогдох байгууллагын дотооддоо зохион байгуулах асуудал үүсэх тул хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй болно.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Авлигын гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг сайжруулах тул шударга үр дүнтэй ажиллагаа нь Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлнэ.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй...” гэж, Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана”, дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй” гэж тус тус заасан тул хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь үндсэн хуулийн зарчимд нийцэж байна.

Энэ чиглэлээр хууль боловсруулахаар сонгосон хувилбар нь олон улсын хэм хэмжээний жишигтэй нийцэж байна. Тухайлбал Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн 11 дүгээр зүйлд гишүүн улс бүр шүүх эрх мэдэл дэх шударга байдлыг бэхжүүлэн авлигаас ангид байлгах талаар үр дүнтэй арга хэмжээ авах үүргийг хүлээлгэж зарим арга хэмжээг нэрлэн зааснаас гадна түүнийг хэрэгжүүлэх техник арга зүйн зөвлөмжид шүүхийг шударга, авлигаас ангид байж чадаж байгаа эсэхийг үнэлэх процедурыг тодорхой тогтоож өгсөн. 2012 онд олон Улсын Авлигатай тэмцэх байгууллагуудын тэргүүнүүд, экспертүүдийн хурлаас батлан гаргасан Авлигатай тэмцэх байгууллагуудын

зарчмын тухай Жакартагийн тунхагт Авлигатай тэмцэх байгууллагаас бусад байгууллагуудтай хамтран ажиллах, өөрийн байгууллага дээр шударга байдлын өндөр хэмжээний стандартыг мөрдүүлэх, олон нийтийн дэмжлэгийг татахын тулд гаднах оролцогч талуудтай байнгын харилцаа холбоотой байж, үйл ажиллагаанд татан оролцуулж байх зэргийг чухалчлан үзсэн байдаг. Эдгээр нь Авлигатай тэмцэх байгууллага зөв зохистой, үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад чухал ач холбогдолтой юм.

Мөн шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй. Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй: үүнд зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн байх зэрэг хүний эрхийн үндсэн хамгаалалтууд нь Иргэний болон улс төрийн эрхийн олон Улсын Пактад тусгагдан батлагдсанаар эдгээр баталгаанууд олон Улсын хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд хуулийн төсөлд тусгаж шийдвэрлэх асуудал нь эдгээрт нийцэж байгаа билээ.

Тав.Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараахь дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон Улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

Зургаа.Олон Улсын болон бусад Улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

Бусад орны Эрүүгийн процессын зохицуулалт, туршлагыг судлах хүрээнд бусад улсын сайн туршлагыг дурдаж байна:

БНСУ-ын эрүүгийн процессын эрх зүйгээр гэмт хэргийн хөнгөн, хүндээс хамааран ялгаатай эрх зүйн процессыг дамжих боломжийг олгосон. Тухайлбал: 200.000 Воноос бага торгууль оногдуулах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд эрүүгийн процессын бүхий л үе шатыг дамжих шаардлагагүй бөгөөд шүүх хуралдаан хийхгүйгээр гэм буруутай этгээдэд ял оногдуулдаг байна. БНСУ-ын Эрүүгийн процессын хуулийн 450 дугаар зүйлд “Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх захирамж гаргуулахаар хүсэлтийг авч үзэхэд уг хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжгүй, эсвэл хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зохимжгүй гэж шүүх үзвэл хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр захирамж гаргаж болно” хэмээн шүүхийн эрх мэдлийг тодорхойлсон. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар Эрүүгийн процессын хуулийнх нь 448-457 дугаар зүйлээр зохицуулсан байна.

БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд ийм процессын 2 төрөл байдаг. Эдгээр нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай, шүүхийн ердийн журмаар шийдвэрлүүлэх тухай хүсэлтээ бичгээр гаргаж болох талаар захирамжид заасан байна. Хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэх тухай хүсэлтээ хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай захирамж гаргасан шүүхэд гаргана. Шүүх хүсэлтийг хүлээн авсан тухайгаа хүсэлт гаргасан этгээдэд нэн даруй мэдэгдэнэ. Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтээсээ анхан шатны шүүх хуралдааны шийдвэр гарахаас өмнө татгалзаж болно. Харин хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжгүй, зохимжгүй гэж шүүх үзвэл хэргийг ердийн журмаар шийдвэрлэх тухай захирамж гаргаснаар хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх тухай захирамж хүчин төгөлдөр бус гэж тооцогдоно. Ингэхдээ хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсний дүнд оногдуулах ял нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дүнд оногдуулж болох хамгийн хүнд ялаас илүү хүнд байж болохгүй. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр нь үндсэндээ яллагдагчийн оролцоог шаарддаг бөгөөд яллагдагч шүүхэд амаар мэдүүлэг өгөх замаар явагддаг нэг ёсны “аман хуралдаан” байдаг бол хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн захирамж нь зөвхөн прокурорын өгсөн бичиг баримтад тулгуурлан хэргийг шийддэг онцлогтой. Дээрх процессын ажиллагаа нь яллагдагч хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлт гаргаагүй бол ердийн журмаар хянан шийдвэрлэх хуралдаанаас гарсан шүүхийн шийдвэртэй ижил эрх зүйн үр дагавартай./ Заавал биелэгдэх эрх зүйн хүчин чадалтай/ байна.

- Малайз Улс Авлигын эсрэг хуульд /1997/ хувийн болон төрийн байгууллагын авлига, хээл хахууль өгөх, авлига өгөхийг завдах, албан тушаалаа урвуулан ашиглах, агент, зуучлагчаар дамжуулан авлига өгөх, төрийн худалдан авалт хийхэд авлига өгөх, сонгуулийн авлига зэрэг гэмт хэрэг, тэдгээрт оногдуулах ял шийтгэлийг тусгасан болно. Энэ хуулиар олгогдсон мөрдөн байцаалтын бүрэн эрхэд хуульчдаас мэдээлэл өгөхийг шаардах, харилцаа холбоог таслан зогсоох, аяллын баримт бичгийг хураан авах зэрэг нь шалгагдаж буй сэжигтнүүдийг гадаадад дүрвэхээс урьдчилан сэргийлэх явдал юм. Гэмт хэргийн зүйл болох нь нотлогдсон эд хөрөнгийг хураах заалт оруулсан болно. Энэхүү хууль нь малайзын иргэн, байнгын оршин суугчдад тус улсаас гадуур үйлдэгдсэн гэмт хэрэгт хамааралтай юм. Мөн Малайз улс нь авлигын хэргийн шүүх хурлыг 12 сарын хугацаанд багтаан хийж дуусгаж байх шүүхийн стандартыг батлан хэрэгжүүлж байна.¹⁵

Долоо. Зөвлөмж

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулах шаардлагатай асуудлыг тусгахын тулд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах хувилбар хангагдахаар байна.

Тус хуулийн төсөлд дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

- Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол хүлээн авах, татгалзах үйл ажиллагааг багаар шийдвэрлэдэг болох. Өргөдөл, гомдол, гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж болох талаар судалж, зохицуулах;
- Тус хуульд заасан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах үндсэн хугацаа нь Авлигын болон ээдрээ төвөгтэй бусад гэмт хэрэгт илүү урт байхаар нэмэлт зохицуулалт тусгах;
- Авлигын гэмт хэргийг нотлох ажиллагааны онцлогийг харгалзан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд тус тус хийгдэх ажиллагааг тодорхой, давхардалгүй болгох;
- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах үндэслэлийг тодруулж заах;

¹⁵ <https://www.u4.no/publications/international-good-practice-in-anti-corruption-legislation>

- Авлигын хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ шүүх зөвхөн прокурорын саналын хүрээнд, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр шийдэхээр байгааг шүүх прокурорын саналыг харгалзан шийдвэрлэдэг байхаар өөрчлөх;
- Нөлөө бүхий албан тушаалтан үйлдсэн, ээдрээ төвөгтэй, олон холбогдогчтой Авлигын хэргийг бүрэлдэхүүнтэй шийддэг байх зохицуулалтыг тусгах;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хүсэлт, гомдол гаргах үндэслэл, нөхцөлийг тодорхой болгох. Тухайлбал, мөрдөгч, прокурор, шүүхээс гарах явцын болон эцсийн шийдвэрт гомдол, хүсэлт гаргах дээд хязгаарыг тогтоох;
- Мөрдөгч, прокурорын шийдвэрийг дээд шатанд хянахдаа уг шийдвэрийг гаргахад зөвлөлддөг буюу шууд хяналт тавих прокуророос өөр буюу дээд шатны прокурорын газрын прокурор хянаж шийдвэрлэдэг байх асуудлыг судалж хуульчлах;
- Хохирогч, нэхэмжлэгч тогтоогдоогүй, мөн нэргүй гомдол, мэдээлэлд хамаарах хохирогчийн эрхийг хөндлөнгийн, хараат бус этгээдэд шилжүүлж болох заалтыг хуульд тусгах;
- Прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлж, хохирол, хор уршгийг нэхэмжлэх зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажилласан этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг судалж тусгах;
- Хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргийг харгалзан мөрдөгч, прокурор багаар ажиллах зохицуулалтыг тусгах;
- Эрүүгийн хэрэгт холбогдох мэдээлэл, нотлох баримтыг тухайн хэрэг шүүхээр эцэслэн шийдэгдэх хүртэл мөрдөн шалгах байгууллага, прокурор, шүүхээс олон нийтэд ил болгохгүй байх зохицуулалтыг тодорхой болгох;
- Шүүгчийг хамгаалах зорилгоор шүүхэд эрүүгийн хэрэг шилжин ирснээс яллагдагчийг шүүхэд шилжүүлэх хүртэлх хугацаанд хэргийг хүлээн авсан шүүгчийн нэрийг нууцлах зэрэг болно.

Хавсралт

1. Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага, хууль тогтоомжийн жагсаалт

Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага:

- Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал /1911-2009 он/, хууль зүйн үндэсний хүрээлэн, 2012 он
- Солонгос ба Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тогтолцоо:тулгамдсан асуудал ба сорилт /Солонгос-Монголын эрдэм шинжилгээний бага хурал/ 2014 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ /Судалгааны тайлан / Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2018 он
- Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь /Судалгааны тайлан/, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2017 он
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Судалгааны тайлан/, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2018 он
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авлигатай тэмцэх газар, 2018 он
- Тогтвортой хөгжлийн төлөө Авлигатай тэмцэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь:Бүгд Найрамдах Солонгос улсын сайн туршлага / сургалт, семинарын товч тайлан/ Азийн сан, 2019 он
- Шударга байдал ба олон нийтийн итгэл /хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн/, Авлигатай тэмцэх газар, 2020 он
- Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны төсөл, 2021 он
- Авлигатай тэмцэх гарын авлага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, 2016 он

Хууль тогтоомжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 1992, №1
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2016, №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017, №23
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2015, №25
- Прокурорын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017, №24
- Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2006, №35
- Шүүхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2021, №5
- Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2017, №8
- Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 2013, №30
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, 1995, №7

2.Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон Улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
1.2. Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн процесст цөөнхийн оролцоо боломж гэсэн ойлголт байхгүй.
1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Гэрч, хохирогчийн өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх шаардлагыг хангана. Яллагдагчийн эрхээ эдлэх боломж бүрдэнэ.
1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон Улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Авлигын эсрэг конвенци, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон Улсын пактын заалтад нийцэж байгаа.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагын асуудал Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдана.

Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч болох шүүгч, прокурор, мөрдөгчийн эрх үүрэгтэй холбоотой зохицуулалт орно.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Дээр дурдсан албан тушаалтнууд эмзэг байдалтай гэх тодорхойлолтод хамаарахгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэгжүүлэгч, оролцогчийн хүлээх үүргийг тодорхойлсон.
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй.

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Одоо байгаа хуульд заасан мэдээлэх тухай ажиллагаа хэвээр хадгалагдана. Иймд нэмэлт зардал гарахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр бий болгох зохицуулалт байхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон Улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон Улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр бий болохгүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлнө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн асуудлаа шийдвэрлүүлэх боломж нэмэгдэнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоон, шударгаар ял оногдуулах ажиллагаа сайжирна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7. Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, хуулийн төслийг боловсронгуй болгоход оршино.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹⁶-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ үндсэн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалт нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийснээс гадна хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжийг туршсан байдалд дүн шинжилгээ хийлээ.

¹⁶ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур Үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан дараах зохицуулалтаас сонгон авч үр нөлөөг үнэлнэ. Үүнд:

1) Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах хугацаанд оруулах өөрчлөлт;

2) Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэхдээ шүүх нь прокурорын саналыг харгалзан шийдвэрлэдэг байхаар зохицуулах;

3) Авлигын хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийддэг байх өөрчлөлт;

4) Салбар хуулиудаар тогтоосон тодорхой албан тушаалтны халдашгүй байдалтай холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн нэг бүлэг болгох;

5) Тухайн ажиллагааг нөхөн гүйцээх боломжгүй бол шүүх хуралдааныг хойшлуулж, дутуу ажиллагааг заасан хугацаанд хийж гүйцэтгэхийг прокурорт даалгах зохицуулалт;

6) Хохирогч, нэхэмжлэгч тогтоогдоогүй тохиолдолд хохирогч, нэхэмжлэгийн эрхийг хөндлөнгийн, хараат бус этгээдэд шилжүүлэх;

7) Прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлж, хохирол, хор уршгийг нэхэмжлэх зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хуультай уялдуулах;

8) Авлигын гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажилласан этгээдийн эрүүгийн хариуцлагыг хөнгөлөх, чөлөөлөх үндэслэл;

9) Хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэргийг харгалзан мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон прокурорын байгууллага тус бүртээ чиг үүргийн хүрээнд багаар ажиллаж болох зохицуулалт;

10) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдээлэл, баримт бичгийг мөрдөгч бие даан авах боломжтой холбоотой заалтуудыг хооронд нь нийцүүлж, тодорхой болгох;

11) Мэдээлэгчийг гэрч, хохирогчтой адил хамгаалах зохицуулалт.

Үр нөлөөг үнэлэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1) Практикт хэрэгжих боломж;
- 2) Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- 3) Ойлгомжтой байдал;
- 4) Зардал;
- 5) Харилцан уялдаа зэрэг болно.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллагын хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй бол хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төсвөөс зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг зардлыг “хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн дараах зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо. Үүнд:

- Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээр 39.1 дүгээр зүйлд нэмэлт оруулж, үүнтэй уялдуулан хуулийн 3.1 дүгээр зүйлд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн харьяалах асуудал дээр оруулахаар тусгасан нэмэлт.
- Хуулийн 4.1 дүгээр зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шаардлагатай гэж үзвэл хэд хэдэн прокурорын бүрэлдэхүүнтэй бүлэг байгуулж ажиллах, 6.3 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээнд мөрдөн шалгах хэсэг байгуулах, хэсгийн ахлагчийг томилох, мөрдөн шалгах хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх зохицуулалт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 Болон 6.3 дугаар зүйлд шаардлагатай гэж үзвэл мөрдөн шалгах ажиллагаа явуулах даалгаврыг хэд хэдэн мөрдөгчид өгөх тухай заасан ба 34.7 дугаар зүйлд шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож болох заалт.
- Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 33 дугаар зүйлд мэдээлэл өгсөн этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоондоо нэвтрүүлэх асуудлыг авч үзнэ хэмээн заасанд нийцүүлэх талаар.
- Хуулийн 34.7 дугаар зүйлд төр, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор прокурор иргэний нэхэмжлэл гаргахаар тусгасан боловч иргэний нэхэмжлэгчийн тухай 8.5 дугаар зүйлд тусгаагүй орхигдуулсан байх тул 8.5 дугаар зүйлд энэ тухай 15 дахь хэсэг нэмэх.
- Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд уг хуулийн 6.15 дугаар зүйлд авлигын гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн хамтран ажиллах этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохоор заасанд 13.3 дугаар зүйлийг нийцүүлэх.

- Монгол Улсын үндсэн хуулийн “шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж заасантай хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай 17 дугаар зүйлийг нийцүүлэх.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдол, мэдээлэл шалгах хугацаа 5 хоног байгаа нь гомдолд дурдагдсан асуудлыг судлах, баримт, мэдээлэл цуглуулахад багадааар байгааг өөрчлөх.

Төрийн зарим албан тушаалтны халдашгүй байх эрх, эрүүгийн хэрэг үүсгэх нөхцөл, хууль зүйн үндэслэлийг салбарын хуулиудад харилцан адилгүй заасныг нэгтгэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн бүлэг болгох.

- 2020 Оны 1 дүгээр сарын 10-ны хуулиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, мөрдөгч нь байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээлэл, баримт бичгийг прокурорын зөвшөөрөлгүйгээр авч болохоор заасан боловч хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 24.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт холбогдох өөрчлөлтийг оруулаагүйн улмаас практикт зөрчил үүсэж байсныг залруулах.
- Прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлж, хохирол, хор уршгийг нэхэмжлэх зохицуулалтыг холбогдох хуультай уялдуулах.
- Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авах, татгалзах ажиллагааг багаар шийдвэрлэх талаарх зохицуулалт.

Үүнээс хуулийн төслийн дараах зохицуулалтыг тус тус сонгон авлаа.
Үүнд:

1) Төрийг төлөөлөх прокурорын эрх хэмжээний талаарх зохицуулалтыг тусгасан 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлд заасан хуулийн 34.7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт оруулах өөрчлөлт, прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл;

2) Гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах ажиллагааг багаар шийдвэрлэх, мөрдөгчийн багаар ажиллах, прокурор, яллагчийн багаар ажиллах талаарх зохицуулалтыг тусгасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 6.3 дугаар зүйл, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

3) Төрийн зарим албан тушаалтны халдашгүй байх эрхийг хангах талаарх зохицуулалтыг тусгасан 1 дүгээр зүйлийн 8 дах хэсэг;

4) Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоосон 39.1, 3.1, 40.5 дугаар зүйл.

Дөрөв.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Практикт хэрэгжих байдал	<p>8.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэг:</p> <p>“15.Төр, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргана.”</p> <p>34.7 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:</p> <p>8.Төр, нийтийн эрх—ашгийг ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргах, гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй.</p> <p>Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг: “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргаж, гаргасан нэхэмжлэлийг дэмжиж оролцоно.” гэж нэмэх.</p> <p>4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:</p> <p>2.24.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэд хэдэн прокурорын бүрэлдэхүүн бүхий хэсэг байгуулж ажиллах;</p> <p>6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:</p> <p>мөрдөн шалгах хэсэг байгуулах, хэсгийн ахлагчийг томилох, мөрдөн шалгах хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах;</p> <p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.</p>	Практикт хэрэгжих боломжийг судлах

2	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	<p>Дөчин зургаадугаар бүлэг. Төрийн зарим албан тушаалтанд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа</p> <p>46.1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын гишүүн 46.2 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн 46.3 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцийн гишүүн 46.4 дүгээр зүйл. Шүүгч 46.5 дугаар зүйл. Прокурор 46.6 дугаар зүйл. Авлигатай тэмцэх газрын алба хаагч 46.7 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагч 46.8 дугаар зүйл. Тагнуулын ажилтан 46.9 дүгээр зүйл. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн 46.10 дугаар зүйл. Монгол банкны ерөнхийлөгч 46.11 дүгээр зүйл. Төрийн албаны зөвлөлийн гишүүн 46.12 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагч</p> <p>3.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг:</p> <p>2. Хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг анхан шатны журмаар, хянан шийдвэрлэнэ.</p> <p>3. Давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.</p> <p>39.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг:</p> <p>9. Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд энэ хуулийн ҮII хэсгийн холбогдох зүйлийг баримтална.</p> <p>40.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:</p> <p>6. Энэ хуулийн 39.1 дүгээр зүйлийн 9-д заасны дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэнэ. Энэ тохиолдолд энэ хуулийн Гучин есдүгээр бүлгийн холбогдох зүйлийг баримтална”</p>	
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах

4	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
5	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ. Үүнд:

4.1. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ: (Төрийг төлөөлөх прокурорын эрх хэмжээний талаарх зохицуулалтыг тусгасан 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн 15 дэх заалт, 34.7 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт оруулах өөрчлөлт, Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл, Гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах ажиллагааг багаар шийдвэрлэх, мөрдөгчийн багаар ажиллах, прокурор, яллагчийн багаар ажиллах талаарх зохицуулалтыг тусгасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 6.3 дугаар зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлд төр, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор прокурор иргэний нэхэмжлэл гаргахаар тусгасан боловч иргэний нэхэмжлэгчийн тухай 8.5 дугаар зүйлд тусгаагүй орхигдуулсан байх тул 8.5 дугаар зүйлд 15 дахь хэсгийг нэмж “төр, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргана” гэж тусгажээ.

Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “Төр, нийтийн гэсний дараа “эрх ашгийг” гэснийг “ашиг сонирхлыг” хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргах, гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй” гэж өөрчлөн тусгасан байна.

Эдгээр зохицуулалттай уялдуулан Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “20.1.Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг

сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэсний дараа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргаж, гаргасан нэхэмжлэлийг дэмжиж оролцоно.” Гэж нэмэхээр төсөлд тусгажээ. Эдгээр зохицуулалт нь практикт хэрэгжих бүрэн боломжтой гэж үзэв.

Судалгааны дүгнэлтээр зөвлөмж болгосон авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах ажиллагааг багаар шийдвэрлэх, мөрдөгчийн багаар ажиллах, прокурор, яллагчийн багаар ажиллах талаарх зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа эдлэх эрхийн жагсаалтад “2.24.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэд хэдэн прокурорын бүрэлдэхүүн бүхий хэсэг байгуулж ажиллах;” гэж, мөн хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эдлэх эрхийн жагсаалтад “мөрдөн шалгах хэсэг байгуулах, хэсгийн ахлагчийг томилох, мөрдөн шалгах хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх, татан буулгах” гэж тус тус нэмж тусгасан байна.

Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэхэд багаар ажиллах зохицуулалт орж байгаатай холбогдуулах Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Дурдсан хуулийн 11, 12 дугаар зүйлд оруулахаар тусгасан нэмэлт, өөрчлөлтүүд нь зөвхөн Авлигын гэмт хэргийн талаар бус иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх нийтлэг журмыг шинэчлэн тогтоохоор байгаа нь практикт хэрэгжих боломжийг бууруулж байна.

Иймд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Төрийн байгууллага бүр зохих нэгжээс төлөөлөл оролцуулж, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авах, татгалзах эсэхийг хэлэлцэх чиг үүрэг бүхий хамтарсан бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна” гэснийг “болно” гэж өөрчлөх, 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт нэмэх “иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээж авахгүй татгалзах, буцаах шийдвэрийг албан тушаалтан ганцаарчлан гаргахыг хориглоно.” Гэснийг хасах, 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг “4.Энэ зүйлийн

2, 3 дахь хэсэгт зааснаар бүртгэсэн өргөдөл, гомдлыг тухайн байгууллага нь багаар хэлэлцэж, хүлээж авах, татгалзах эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн зохицуулалтыг “хуульд заасан бол” гэж өөрчлөн энэ талаарх зохицуулалтаа Авлигын эсрэг хуульд тусгасан тохиолдолд хуулийн төслийг боловсруулж байгаа зорилгодоо хүрэх, практикт хэрэгжих боломжтой гэж үзэхээр байна.

4.2. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Салбар хуулиудаар тогтоосон тодорхой албан тушаалтны халдашгүй байдалтай холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд тусгай журмаар зохицуулах талаар холбогдох хуулиудын заалтыг судалж үзээд төрийн зарим албан тушаалтны халдашгүй байх эрх, эрүүгийн хэрэг үүсгэх нөхцөл, хууль зүйн үндэслэлийг салбарын хуулиудад харилцан адилгүй заасныг тандан судалгааны үр дүнгээр тогтоосон байна.

Иймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална” гэж заасантай нийцүүлж холбогдох хуулиудын заалтыг нэгтгэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэг бүлэг болгон нэмж тусгажээ.

Үүнд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүгч, Прокурор, Авлигатай тэмцэх газрын алба хаагч, Цагдаагийн алба хаагч, Тагнуулын ажилтан, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Монгол банкны ерөнхийлөгч, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тодорхой хэмжээний халдашгүй байдлыг хуулиар тогтоосон байсныг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах замаар хууль хоорондын уялдааг хангах зохицуулалт хийжээ. Энэ нь практикт хэрэгжээд явж байгаа тул цаашид ч хүлээн зөвшөөрөгдөх бүрэн боломжтой байна гэж үзлээ.

Шүүхийн тухай хуулийн 25 болон 29 дүгээр зүйлд давж заалдах шатны шүүх хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан хэлэлцэхээр, тухайн хэргийг хяналтын шатны шүүх давж заалдах журмаар хянан хэлэлцэхээр заасан. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1 Дүгээр зүйлд давж заалдах шатны шүүх хуулиар харьяалуулсан эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх, хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн анхан

шатны журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэхээр заасан бөгөөд 39.1 дүгээр зүйл, 40.5 дугаар зүйлд давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх, давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдсэн авлигын гэмт хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэхээр заасан нь аж ахуйн байгууллагад хүндрэл үүсгэхгүй байх тул хүлээн зөвшөөрөгдөх боломжтой байна.

4.3. "Ойлгомжтой байдлыг судлах" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад санал өгсөн байгууллагуудын тухайд ойлгомжгүй байгаа зохицуулалтуудыг нэмж найруулсан байна.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Нэг	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон Улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН, ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД

6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Эшлэл хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн заасан.
8	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
9	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
10	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг дагаж Прокурорын тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагах хуулийн төсөл боловсруулсан байна.
11	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино." гэж заасан тул тусад нь зорилго заагаагүй.
Хоёр	Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
1	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
2	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.

3	30.1.3.үг хэллэгийг Монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
4	30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
5	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

4.4. “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо нь хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна гэж үзсэн.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Шаардлага хангасан байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлага хангасан байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Шаардлагатай хэмжээнд тусгасан.

8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Давхардуулан тусгаагүй гэж үзсэн.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Шаардлагыг хангасан байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Татвар хураамж тогтоогоогүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Шаардлагыг хангасан байна.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон Улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөл нь авлига, хүнд бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Шаардлага хангасан.

Тав.Үр дүн, зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд сонгон авсан практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, уялдаа холбоог шалгах, зардлын шалгуур үзүүлэлтээр хуулийн төсөлд тусгагдсан агуулгаар үр нөлөө гарна гэж үнэлсэн.

Энэхүү үнэлгээний ажлын явцад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй уулзаж ярилцах, хэлэлцүүлэг зохион байгуулах, албан бичгээр санал авах, дотоодын болон гадаадын улс орны сайн туршлага бүхий хуультай харьцуулах, давхардал хийдлийг илрүүлэхээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулсан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэхээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг

уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон байна.

Хуулийн төсөл нь практикт хэрэгжих боломжтой, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөлд санал авч, ирүүлсэн саналыг тусган боловсруулж зарим зохицуулалтуудыг нэмж найруулсан байна.

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг тодорхой тооцсон тул энэхүү үнэлгээний тайланд дүгнэлтийг тусгаагүй болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд хуулийн төслийг Эрүүгийн хуулийн зорилтод нийцүүлж боловсруулсан, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалтыг тусгаагүй байна гэж үзсэн.

Эдгээрийг нэгтгэн дүгнэж үзэхэд хуулийн төслийг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.

Харин хуулийн төслийн 5 дугаар зүйлд тусгасан Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийг Авлигын эсрэг хуульд 3 дугаар зүйлийн 3.1.4 Дэх хэсэгт заасан давуу байдал гэсэн тодорхойлолт, мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалттай уялдуулахыг зөвлөмж болгож байна.

Харин иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг Авлигын эсрэг хуульд тусгасан тохиолдолд хуулийн төслийг боловсруулж байгаа зорилгодоо хүрэх, практикт хэрэгжих боломжтой гэж зөвлөмж болголоо.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

2021.12.06

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Энэхүү аргачлалд зааснаар хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардлыг, иргэнд үүсэх зардлыг тооцохдоо хууль тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацааг тус тус тооцон гаргана.

Иймд аргачлалд заасны дагуу төрийн байгууллагын болон иргэн, хуулийн этгээдийн аль альд холбогдох зардлыг тооцоолон гаргахыг зорилоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажиллаа. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;

- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хоёр. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Хуулийн төсөлд ямар нэгэн шинэ ялын төрөл нэмж тусгахгүй учраас хуулийн төсөл батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль дээдлэх ёсны зарчимд нийцсэн, гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинд ахиц дэвшил гарах бөгөөд эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим бодитой хэрэгжинэ.

Гурав. Иргэнд үүсэх зардлын тооцоо

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцохдоо дараах үе шатыг баримтална. Үүнд:

6. Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
7. Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
8. Тоон үзүүлэлтийг тооцох;
9. Гарах зардлын дүнг нэгтгэн тооцох;
10. Хувилбарыг нягтлах.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Энэ хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэг бүрчлэн судалж хуулийн төслөөр иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг тогтоож гарах зардлыг тооцсон.

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

**Дөрөв. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага
буюу улсын төсөвт үүсэх зардал**

Энэ хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд тодорхой төрлийн үүрэг гүйцэтгэхийг даалгасан буюу шаардсан бол үүний дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргах юм.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- 1) Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох; ,
- 2) Нэг бүрийн зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах;
- 6) Нэмэлт зардлыг тооцох.

Нэгдүгээр үе шатны хүрээнд: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Хуулийн төслийг судлан үзэхэд хуулийн этгээдэд шууд үүрэг бий болгосон заалт байхгүй байна. Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

Тав. Дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагалдан гарах зардлын тооцоог хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн судлан үзэхэд төсөл нь зардал тээгч гуравдагч этгээдэд зардал үүсгэх зохицуулалт агуулаагүй байна. Иймээс уг хуулийн төсөл нь Улсын төсөвт ачаалал үүсгэхгүй. Улсын төсөвт ачаалал үүсгэхгүй тул зардлыг бууруулах талаар санал гаргаагүй болно.

3

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**



ТАНИЛЦУУЛГА

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Авлигын эсрэг хуулийг 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталж, 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байгаа бөгөөд энэ хугацаанд тус хуульд 17 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “авлигагүй засаглал” гэсэн 5.6 дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, **зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат болох 2021-2030 онд** “авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин”-ыг төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлсон байна.

Монгол Улсын засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр заасан.

Үүний дагуу АТГ, УЕПГ, ШЕЗ-өөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хийсэн “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ” судалгааны дүн, хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, Авлигын эсрэг хуульд заасан зарим нэр томъёоны тайлбар, агуулгыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх; авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, хаах болон мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа үндэслэлийн ялгаатай байдал, мөрдөн шалгах ажиллагааны чанар үр дүнд дүн шинжилгээ хийх зөвлөл, хороо, комисс ажиллуулах шаардлагатай гэж дүгнэсэн.

Ийм хууль санаачлагчийн зүгээс 1) Авлигатай тэмцэх газарт олон нийтийн оролцоотой, орон тооны бус мэргэжлийн зөвлөл бий болгож Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хэрэг бүртгэлт,

мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг сайжруулах механизмыг бүрдүүлэх, 2) Авлигын эсрэг хуульд заасан зарим нэр томъёоны тайлбар, агуулгыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх; гэсэн хоёр багц асуудлыг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл нь 7 зүйлтэй бөгөөд 1, 2 болон 6 дугаар зүйлд Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх зорилгоор хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалтад төрийн үйлчилгээний албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаалтныг, үндсэн хуулийн цэц, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн; төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл тэдгээрийн оролцоотой, хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөгч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, хараат бус гишүүн, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороонд төрийг төлөөлөх гишүүн; тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүн; төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд аудит хийх аудитор; Улс төрийн намын тухай хуулийн¹⁷ 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт заасан этгээд буюу намын удирдлага, намын санхүүгийн албаны дарга, ерөнхий менежер, түүнтэй адилтгах албан тушаалтан; эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шинжилгээний байгууллагаас гадуур шинжээчээр, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор томилогдсон шинжээчийг нэмэх тухай тус тус тусгасан.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлд Авлигатай тэмцэх газарт орон тооны бус мэргэжлийн хороо байгуулах, түүний ажиллах журам, хэлэлцэх асуудал, зөвлөлийн бүрэлдэхүүнд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн гишүүнийг оруулах, тухайн гишүүний эрх, үүргийн талаар тусгасан бөгөөд авлигын гэмт хэргийн талаарх мэдээлэл өгсөн хуулийн этгээд, иргэний (шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрхийн хамгаалах) мэдээллийг нууцлах талаар тусгалаа.

Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “ашиг хонжоо” гэсэн нэр томъёог хууль хэрэглэгч нарт ойлгомжтой нэг мөр болгох зорилгоор, “давуу байдал” гэсэн нэр томъёог Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэн тайлбарласан зохицуулалтыг төслийн 4 ба 5 дугаар зүйлд тусгав.

¹⁷ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “оролцогч улс бүр ... Нийтийн албан тушаалтан нь чиг үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил, хөрөнгө оруулалт, хөрөнгө, том хэмжээний бэлэг буюу ашиг орлого зэргийнхээ талаар зохих эрх бүхий байгууллагад мэдүүлж байх арга хэмжээ, тогтолцоог тогтоох...” Гэж заасан.

Иймд Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт АТГ-ын албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж дүн шинжилгээ хийх чиг үүргийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах үүргийг мөн АТГ хүлээх нь зүйтэй байх тул Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо” гэснийг хасахаар хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгасан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

БАТЛАВ.

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3-д “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлнэ”, арван Есдүгээр зүйлийн 1-д “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам” хэмээх Гуравдугаар хэсгийн 3.3.2.2-д “Авлигатай хийх тэмцлийг үндэсний хэмжээнд өрнүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагын идэвхтэй оролцоог хангана. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, авлигыг үл тэвчих үзлийг нийгэмд төлөвшүүлнэ” гэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Авлигагүй засаглал” гэсэн 5.6 дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат болох 2021-2030 онд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан.

Тухайлбал, “авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх,

Авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-Т “Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно” гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр заасан.

“Транспаренси интернэшнл” олон Улсын байгууллагаас жил болгон боловсруулдаг улс орны төрийн албан дахь Авлигын төсөөллийн индексийн 2020 оны дүнг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дэлхий нийтэд зарласан. Индексийн дүнгээр Монгол Улс 2020 онд 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх оныхоос 5 байраар ухарсан үзүүлэлт болж байна.

Авлигын эсрэг хуулийг 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталж 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байгаа бөгөөд энэ хугацаанд тус хуульд 17 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Өнгөрсөн хугацаанд хуулийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар хийсэн судалгааны ажлаас тодорхой сэдвээр өргөн хүрээг хамарсан, хамгийн сүүлийн үеийн судалгааны ажил нь АТГ, УЕПГ, ШЕЗ-өөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хийсэн “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ” судалгаа юм.

Монгол Улсад авлигатай тэмцэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх хүрээнд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн дэвшүүлсэн эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмжийн дагуу Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, зохицуулалтын үр дүнтэй хувилбарыг тодорхойлох зорилгоор судалгаа хийсэн.

Энэхүү судалгааны хүрээнд асуумж судалгаа авах, статистик мэдээнд дүн шинжилгээ хийх, шийдвэр судлах, ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх зэрэг ажлыг гүйцэтгэсэн ба тоон болон чанарын дүн шинжилгээ нь сүүлийн 3 жилийн хугацааг хамарсан байна.

Судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмжөөс үзэхэд Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, мөрдөн шалгах ажиллагааны чанарт хяналт тавих механизмыг бүрдүүлэх, үүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гомдол, мэдээллийг шалгах хугацааг уян хатан болгох, Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулга, томьёололд нийцүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж үзжээ.

Түүнчлэн, эдгээр тулгамдсан асуудлыг Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх талаар зөвлөмж гаргажээ. Тухайлбал, Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах болон хэрэг хаах, татгалзах асуудлыг багаар шийдвэрлэх, Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулга, томьёололд нийцүүлэх талаар дурджээ.

Авлигатай тэмцэх газар 2017-2019 оны дунджаар жилд ойролцоогоор 1541 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 792 гомдол, мэдээллийг ЭХХШТХ-ийн дагуу гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгах ажиллагаанд шилжүүлж, 749 гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжгүй гэж шийдвэрлэжээ. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгаад 68.7 Хувийг гэмт хэргийн шинжгүй, 13.4 Хувийг урьд хэрэгсэхгүй болгосон шийдвэр хүчинтэй шалтгаанаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжгүй гэж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл нь ихэвчлэн хардлагын шинжтэй, харьяаллын бус асуудал байсан бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэрт дүн шинжилгээ хийхэд шалгах ажиллагаа хангалтгүй, нотлох баримт хангалтгүй, шийдвэрийн үндэслэл өөрөө эргэлзээтэй байдал 53.7 Хувийг эзэлжээ.

Гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах ажиллагааг хязгаарлагдмал хүрээнд гүйцэтгэж байгаа нь иргэд, олон нийт АТГ-т итгэх итгэлд сөргөөр нөлөөлөх, ирүүлсэн гомдол, мэдээлэл нь харьяаллын бус, хардлагын шинжтэй байгаа нь иргэд, олон нийтийн Авлигын гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах шаардлага байгааг харуулж байна.

Гурван жилийн дунджаар 2400 орчим гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэж шалгах ажиллагаа явуулснаас нийт 1306 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээжээ. Хэрэг бүртгэлт явуулсан хэргээс

прокурор 723-ийг нь хааж шийдвэрлэсэн бөгөөд гарсан шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд үүний 54 хувьд нь шалгах ажиллагаа хангалтгүй, нотлох баримт хангалтгүй, 14 хувийн шийдвэрийн үндэслэл нь эргэлзээтэй байдлаар хаагджээ.

Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо жил тутам 18-22 хувиар нэмэгдсэн боловч шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо адил хэмжээнд нэмэгдээгүй байна.

Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 55 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалт явуулсны 28-ыг хэрэгсэхгүй болгосон прокурорын тогтоолын үндэслэх хэсэгт дүн шинжилгээ хийхэд шийдвэр гаргахад ач холбогдол бүхий ажиллагааг хангалттай хийгээгүй, шийдвэр гаргахад дангаар ашиглахад хангалтгүй, ач холбогдол багатай нотлох баримтыг үндэслэсэн байна.

Судалгаанаас үзэхэд хуульд заасан гомдол, мэдээллийг шалгах хугацаа богино байгаа нь АТГ-ын үйл ажиллагааны чанарт нөлөөлж байгаагаас гадна гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, эсхүл хаах санал бол мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийн үндэслэл хооронд ялгаа гарахгүй, нотлох баримт, гэрчийн мэдүүлгийг тоочих байдлаар бичиж, тэдгээрт дүн шинжилгээ хийж оюун дүгнэлт, шалтгаант холбоог тодорхойлохгүй байгаа нь шийдвэрийг үндэслэл муутай, бүрэн бус гэж дүгнэх үндэслэл болж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 15 дугаар зүйлийн (б) хэсэгт шударга бусаар давуу тал олж авахын тулд нийтийн албаны тушаалтанд давуу байдал амлах, санал болгох, бий болгохыг гэмт хэрэгт тооцохоор боловч хууль хэрэглэж байгаа албан тушаалтнууд “өөртөө, бусдад давуу байдал бий болгосон” гэж аль алинд нь зэрэг давуу байдал бий болгосон байх, эсхүл давуу байдал бий болгосноос заавал эдийн ашиг хонжоо олж үр өгөөжийг нь хүртсэн байхыг шаардах зэргээр тайлбарласан, хариу давуу байдал олж авч үр өгөөжийг нь хүртсэн нийтийн албан тушаалтан хариуцлага хүлээхгүй байх зэрэг практикт тулгарч байгаа асуудал судалгаагаар илэрсэн. Түүнчлэн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 дугаар зүйлийн (а) хэсэгт заасан нийтийн албан тушаалтан гэдэгт нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа бусад хүнийг хамааруулна гэж заасан боловч Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд¹⁸ заасан “хуулийн үйлчлэлд хамаарах этгээд”-ийн жагсаалтаар нийтийн албан тушаалтны хүрээг хязгаарласан байна.

¹⁸ Авлигын эсрэг хууль. //Төрийн мэдээлэл. 2006 он. №35

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 болон 13 дугаар зүйлд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан байх талаар заасныг үндэслэн Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг тогтоосон тандан судалгааны тайлан гарсан.

Авлигын гэмт хэрэгтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэлийг тодорхойлсон холбогдох судалгааны үр дүнгээс үзэхэд үүссэн асуудлыг хуульд тусгах замаар шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байх тул хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй үзлээ.

Хоёр. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, хуулийн төслийн ерөнхий бүтэц

Шаардлагатай өөрчлөлтийн цар хүрээг харгалзан хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5.1-д заасны дагуу “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” төрлийг сонгон хуулийн төслийг боловсруулна. Хуулийн төслийн бүтэц зүйл, хэсгээс бүрдэнэ.

Хуулийн төсөлд дараах нэмэлт, өөрчлөлтийг тусгана:

1) Авлигын эсрэг хуульд заасан “нийтийн албан тушаалтан”, “давуу байдал” гэсэн нэр томъёоны тайлбар, агуулгыг болон УИХ-ын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянах зохицуулалтыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх;

2) Авлигатай тэмцэх газарт 24 цагаар гомдол, мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ хийх олон нийтийн оролцоотой, орон тооны бус мэргэжлийн хороо бий болгох;

3) Тус хорооны эрх хэмжээнд дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх талаар тусгах. Үүнд:

- Гомдол, мэдээллийг судалж хэлэлцэх;
- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах үндэслэлийн талаар дүн шинжилгээ хийх;
- Мөрдөн байцаалт явуулсан хэргийг прокурор, шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг сайжруулах талаар мөрдөгч нарт зөвлөмж өгч ажиллах.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн батлагдсаны дараа хэрэгжүүлэх явцад төсвөөс нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль дээдлэх ёсны зарчимд нийцсэн, гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчинд ахиц дэвшил гарах эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй нийцүүлэн шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

/Зөвлөх Дангаагийн Эрдэнэбаатар/

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. дэх заалтын “тусгай” гэсний дараа “үйлчилгээний” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт дор дурдсан заалт нэмсүгэй:

“4.1.10. Үндсэн хуулийн цэц, шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн сахилгын хороо, санхүүгийн зохицуулах хороо, үндэсний статистикийн хороо, сонгуулийн ерөнхий хороо, хүний эрхийн үндэсний комиссын дарга, гишүүн;

4.1.11. Төрийн болон орон нутгийн өмчит, эсхүл тэдгээрийн оролцоотой, хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчийн төлөөлөгч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга, хараат бус гишүүн, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороонд төрийг төлөөлөх гишүүн;

4.1.12. Тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүн;

4.1.13. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд аудит хийх аудитор;

4.1.14. Улс төрийн намын тухай хуулийн¹⁹ 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт заасан этгээд;”

3 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан хэсэг нэмсүгэй:

¹⁹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2005 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

“9.3. Авлигатай тэмцэх газарт орон тооны бус мэргэжлийн хороо (цаашид “хороо” гэх) ажиллана. Хороо нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж хамтын шийдвэрээр зөвлөмж гаргана:

9.3.1. Авлигын гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, татгалзах талаар;

9.3.2. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах мөрдөгчийн санал;

9.3.3. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр Авлигын гэмт хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнгийн талаар.

9.4. Энэ хуулийн 9.3.1-д заасан асуудлыг хэлэлцэхэд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн нэг гишүүн хорооны гишүүний эрх хэмжээг хэрэгжүүлж оролцож болно.

9.5. Авлигын гэмт хэргийн талаарх мэдээлэл өгсөн хуулийн этгээд, иргэний талаарх мэдээллийг нууцална.

9.6. Хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Авлигатай тэмцэх газрын дарга батална.”

4 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “өөрт нь болон” гэснийг “өөрт нь эсхүл” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.4. “Давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-Т заасан этгээд, эсхүл хүн, хуулийн этгээдийн аль нэг, эсхүл тэдгээрийн хувийн ашиг сонирхлыг хангахад нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;”

6 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.2. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр шинжилгээний байгууллагаас гадуур шинжээчээр, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор томилогдсон шинжээч;”

7 дугаар зүйл. Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо” гэснийг хассугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛС ДАХЬ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨСӨЛ
ТА-9662 МОН

4

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**



Товчилсон үгийн жагсаалт

ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
УБ	Улаанбаатар
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДХИС	Дотоод хэргийн их сургууль

Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт №1	Асуудлыг зохицуулах хувилбаруудын эерэг ба сөрөг талын харьцуулалт
Хүснэгт №2	Зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт
Зураг №1	Сингапурын Авлигын гэмт хэргийг мөрдөх товчооны гомдол, мэдээллийг хянан үйл явцын зураглал

Хавсралтын жагсаалт

Хүснэгт №1	Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
Хүснэгт №2	Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
Хүснэгт №3	Нийгэмд үзүүлэх үр нөлөө
Хүснэгт №4	Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
Хүснэгт №5	Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

АГУУЛГА

Удиртгал	137
Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал	139
1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал	140
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон байдал	142
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл	143
Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал	144
Гурав. Асуудлыг зохицуулах хувилбар, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал	144
Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал	147
4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	147
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	147
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	147
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	147
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон Улсын гэрээ бусад хуультай нийцэж байгаа байдал	148
Тав. Зохицуулалтуудын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт	148
Зургаа. Олон Улсын болон бусад Улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал	149
6.1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын зарим зохицуулалттай харьцуулсан байдал	149
6.2. Гадаадын зарим улсын хуулийн зохицуулалттай харьцуулсан байдал	151

Долоо. Зөвлөмж	155
Эх сурвалжийн жагсаалт	156
Хавсралт	158

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Авлигагүй засаглал” гэсэн 5.6 дахь зорилтод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар зааж, **зорилтыг хэрэгжүүлэх 1 дүгээр үе шат болох 2021-2030 онд** авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлэх үе хэмээн тодорхойлж, **хэрэгжүүлэх үйл ажиллагааг заасан.**

Тухайлбал, авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, Авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.1-т “төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно” гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “авлига, албан тушаалын гэмт хэргийн шийдвэрлэлт, шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, үр дүнг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах болон хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ашиглах” арга хэмжээг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр заасан.

Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн судалгааны баг “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ”²⁰ хийж, Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмж гаргасан.

²⁰ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банк, УБ, 2021

ХБНГУ-ын Берлин хотод төвтэй “Транспаренси Интернэшнл” олон Улсын байгууллагаас жил болгон боловсруулдаг улс орны төрийн албан дахь авлигын төсөөллийн индексийн 2020 оны дүнг 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дэлхий нийтэд зарласан. Индексийн дүнгээр Монгол Улс 2020 онд 180 улс орноос 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх оныхоос 5 байраар ухарсан үзүүлэлт болж байна. “Транспэрэнси Интернэшнл” олон Улсын байгууллагаас Авлигатай тэмцэх байгууллага болон хяналт тавих эрх бүхий байгууллагыг хангалттай санхүүгийн нөөц бололцоогоор хангаж, бие даасан, хараат бус байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх бололцоог хангахыг зөвлөсөн байна²¹.

Монгол улсад Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх хүрээнд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн дэвшүүлсэн эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмжийн дагуу Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, зохицуулалтын үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгох зорилгоор судалгааг хийв.

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааг дараах үе шаттайгаар зохион байгууллаа. Үүнд:

1. Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх эрх зүйн орчин, байгууллагын чадвар, чадамж, практик дахь тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх;

2. Тухайн асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;

3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулах;

4. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах;

5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулах,

6. Тухайн зохицуулалтын талаарх олон Улсын болон бусад Улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;

7. Судалгааны үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулах.

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааг засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан

²¹ <https://www.transparency.org/en/press/2020>

хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу хийж гүйцэтгэв.

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Авлигын эсрэг хуулийг 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталж 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөнөөс хойш 17 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Авлигатай тэмцэх газар, Улсын Ерөнхий прокурорын газар, шүүхийн ерөнхий зөвлөлөөс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Азийн сангийн судалгааны баг “Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээ”²²-г 2017-2019 оны хугацааг хамруулан хийж, Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмж гаргасан.

Тухайлбал, Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах шийдвэрийг хянах тогтолцоог АТГ-ын бүтцэд бүрдүүлэх замаар олон нийтийн Авлигын хэргийн талаарх ойлголт, олон нийтийн зүгээс тус байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэлийг тус тус нэмэгдүүлэх, мөрдөгчийн ачааллыг бууруулснаар Авлигатай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзжээ.

Түүнчлэн Авлигын гэмт хэрэг, энэ төрлийн гэмт хэргийн онцлог, субъектийг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод²³ заасан агуулга, томъёололтой нийцүүлэх, тайлбарлах шаардлага байгааг судалгааны үр дүнд тодорхойлсон байна.

Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх эрх зүйн орчин, байгууллагын чадвар, чадамж, практик дахь тулгамдсан асуудлыг тодорхойлж, түүнд дүн шинжилгээ хийх судалгаанд Авлигатай тэмцэх газар, Авлигын хэрэгт хяналт тавьдаг прокурор, шүүгчтэй уулзаж ярилцах, тэдгээрийн дунд санал асуулга явуулах, судалгаа авах, эдгээр байгууллага болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс статистик мэдээ авах, өмнө нь энэ талаар хийсэн судалгааны материалыг үзэх, хэлэлцүүлэг хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

²² Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банк, УБ, 2021

²³ <https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269> татсан: 2021-09-16

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Авлигатай тэмцэх газар 2017-2019 оны дунджаар жилд ойролцоогоор 1541 гомдол, мэдээлэл хүлээн авснаас 792 гомдол, мэдээллийг ЭХХШТХ-ийн дагуу гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгах ажиллагаанд шилжүүлж, 749 гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжгүй гэж шийдвэрлэжээ. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгаад 68.7 Хувийг гэмт хэргийн шинжгүй, 13.4 Хувийг урьд хэрэгсэхгүй болгосон шийдвэр хүчинтэй шалтгаанаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжгүй гэж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл нь ихэвчлэн хардлагын шинжтэй, харьяаллын бус асуудал байсан бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан шийдвэрт дүн шинжилгээ хийхэд шалгах ажиллагаа хангалтгүй, нотлох баримт хангалтгүй, шийдвэрийн үндэслэл өөрөө эргэлзээтэй байдал 53.7 Хувийг эзэлжээ.

Гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах ажиллагааг хязгаарлагдмал хүрээнд гүйцэтгэж байгаа нь иргэд, олон нийт АТГ-т итгэх итгэлд сөргөөр нөлөөлөх, ирүүлсэн гомдол, мэдээлэл нь харьяаллын бус, хардлагын шинжтэй байгаа нь иргэд, олон нийтийн Авлигын гэмт хэргийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах шаардлага байгааг харуулж байна.

Гурван жилийн дунджаар 2400 орчим гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй гэж үзэж шалгах ажиллагаа явуулснаас нийт 1306 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээжээ. Хэрэг бүртгэлт явуулсан хэргээс прокурор 723-ийг нь хааж шийдвэрлэсэн бөгөөд гарсан шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд үүний 54 хувьд нь шалгах ажиллагаа хангалтгүй, нотлох баримт хангалтгүй, 14 хувийн шийдвэрийн үндэслэл нь эргэлзээтэй байдлаар хаагджээ.

Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо жил тутам 18-22 хувиар нэмэгдсэн боловч шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн тоо адил хэмжээнд нэмэгдээгүй байна.

Хэрэг бүртгэлт явуулсан хэргийн 55 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалт явуулсны 28-ыг хэрэгсэхгүй болгосон прокурорын тогтоолын үндэслэх хэсэгт дүн шинжилгээ хийхэд шийдвэр гаргахад ач холбогдол бүхий ажиллагааг хангалттай хийгээгүй, шийдвэр гаргахад дангаар ашиглахад хангалтгүй, ач холбогдол багатай нотлох баримтыг үндэслэсэн байна.

Судалгаанаас үзэхэд хуульд заасан гомдол, мэдээллийг шалгах хугацаа богино байгаа нь АТГ-ын үйл ажиллагааны чанарт нөлөөлж байгаагаас гадна гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, эсхүл хаах санал бол мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэрийн үндэслэл хооронд ялгаа гарахгүй, нотлох баримт, гэрчийн мэдүүлгийг тоочих байдлаар бичиж, тэдгээрт дүн шинжилгээ хийж оюун дүгнэлт, шалтгаант холбоог тодорхойлохгүй байгаа нь шийдвэрийг үндэслэл муутай, бүрэн бус гэж дүгнэх үндэслэл болж байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 15 дугаар зүйлийн (б) хэсэгт шударга бусаар давуу тал олж авахын тулд нийтийн албаны тушаалтанд давуу байдал амлах, санал болгох, бий болгохыг гэмт хэрэгт тооцохоор боловч хууль хэрэглэж байгаа албан тушаалтнууд “өөртөө, бусдад давуу байдал бий болгосон” гэж аль алинд нь зэрэг давуу байдал бий болгосон байх, эсхүл давуу байдал бий болгосноос заавал эдийн ашиг хонжоо олж үр өгөөжийг нь хүртсэн байхыг шаардах зэргээр тайлбарласан, хариу давуу байдал олж авч үр өгөөжийг нь хүртсэн нийтийн албан тушаалтан хариуцлага хүлээхгүй байх зэрэг практикт тулгарч байгаа асуудал судалгаагаар илэрсэн. Түүнчлэн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 дугаар зүйлийн (а) хэсэгт заасан нийтийн албан тушаалтан гэдэгт нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа бусад хүнийг хамааруулна гэж заасан боловч Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд²⁴ заасан “хуулийн үйлчлэлд хамаарах этгээд”-ийн жагсаалтаар нийтийн албан тушаалтны хүрээг хязгаарласан байна. Өөрөөр хэлбэл, олон Улсын гэрээ конвенцтой үндэсний эрх зүйн хэм хэмжээг нийцүүлэх шаардлага байна.

Авлигын хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх эрх зүйн орчин, байгууллагын чадвар, чадамж, практик дахь тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж дараах дүгнэлтийг хийв. Үүнд:

Нэг. Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, мөрдөн шалгах ажиллагааны чанарт хяналт тавих механизмыг бүрдүүлэх, үүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гомдол, мэдээллийг шалгах хугацааг уян хатан болгох зохицуулалтыг Авлигын эсрэг хуульд тусгах;

Хоёр. Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулга, томъёололд нийцүүлэх.

²⁴ Авлигын эсрэг хууль. //Төрийн мэдээлэл. 2006 он. №35

Гурав. Гомдол, мэдээллийг шалгах хугацааны талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан²⁵.

Тулгамдаж байгаа асуудлын цар хүрээнд иргэн, хуулийн этгээд, АТГ, мөрдөгч, прокурор, АТГ-ын олон нийтийн зөвлөл, түүний гишүүд болон Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол багтана гэж үзсэн.

Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 8, 9 дүгээр зүйлд энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн Авлигын талаар мэдээллийг, иргэн, хуулийн этгээд Авлигын асуудлаар өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгөх талаар зохицуулсан. Судалгаагаар тогтоогдож байгаа хангалттай хугацаанд шалгахгүйгээр гомдол, мэдээллийг хаах, эсхүл хангалттай үндэслэл бүхий дүгнэлт хийж хууль ёсны шийдвэр гаргахгүй байгаагаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байна.

Тулгамдаж байгаа асуудлыг зохицуулах хувилбарыг дэвшүүлж шийдвэрлүүлснээс гаргасан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн чанарт ахиц гарах, гомдол, мэдээллийн бодит байдал, тоо хэмжээнд нөлөөлнө.

Авлигатай тэмцэх газар болон бусад эрх бүхий байгууллагад хохирогчийн өгч байгаа өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах үндсэн хугацаа нь бага байдгаас тэдний өгсөн өргөдөл, гомдлыг хүлээн авахаас татгалзах, эсхүл түүний дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах асуудлыг хувь хүний саналаар шийдэж байгаа нь хохирогчийн зүгээс гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх эрхийг зөрчиж байна.

²⁵ Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992 он. №1

Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлд заасан олон нийтийн зөвлөл Авлигатай тэмцэхэд олон нийтийг идэвхтэй оролцуулах, тэдний санал бодлыг хүргэх, Авлигын нөхцөл байдал, Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зөвлөмж өгөх зорилгоо хэрэгжүүлэхэд гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавихад оролцох боломж бий болно.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлд “Иргэн, хуулийн этгээд Авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно. Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ” гэж заасан.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу АТГ-ын өргөдөл, гомдол хүлээн авах үүрэг бүхий ажилтан гомдол, мэдээллийг хүлээн авч АТГ-ын дарга гэмт хэргийн шинжтэй бол мөрдөн шалгах хэлтэст хуваарилснаар мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлд зааснаар 5 хоногийн дотор мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

Мөрдөгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлд заасны дагуу гомдол, мэдээллийг шалгаад хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах бол саналаа прокурорт 72 цагийн дотор, мөрдөгч мөн хуулийн 30.14 дүгээр зүйлд зааснаар хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналаа прокурор (хугацаа заагаагүй)-т тус тус хүргүүлнэ.

Судалгааны үр дүнгээс үзэхэд өргөдөл, гомдол бүртгэх үүрэг бүхий албан хаагч, АТГ-ын дарга болон мөрдөгч тус бүр өргөдөл, гомдлыг гэмт хэргийн шинжтэй эсэхийг, мөрдөгч дангаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гарган шийдвэрлэж байгааг хэт хязгаарлагдмал хүрээнд шийдвэрлэж байна гэж үзэх үндэслэлтэй.

Шийдвэрийг хязгаарлагдмал хүрээнд гаргаж нь шийдвэрийн чанарт нөлөөлөх шалтгаан нөхцөл мөн юм.

Манай улс нэгдсэн үндэстний байгууллагаас 2003 онд баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод Монгол Улсын 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг соёрхон батлах тухай хуулиар нэгдэн орсноор тухайн конвенцыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн.

Өөрөөр хэлбэл, тус конвенцод заасан нэр томъёог нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомжид тусгах үүрэгтэй. Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэрэг нь “давуу байдал бий болгосон”-оор үйлдэгдсэнд тооцохоор заасан боловч хуулийг хэрэгжүүлэгч субъект нь Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан хууль тогтоогчийн тайлбарын дагуу “эдийн болон эдийн бус ашигтай байдал” олж авсан байхыг шаардаж байна.

Түүнчлэн, Авлигын гэмт хэргийн субъект болох “нийтийн албан тушаалтан” гэдэг ойлголтыг нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 4 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан жагсаалтын дагуу ойлгож хэрэгжүүлж байгаа боловч төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан тушаалын жагсаалтаас зөрүүтэй, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод заасан агуулгаас зөрөх зэргээр хуулийг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл учруулж байна.

Эдгээр нь Авлигын эсрэг хуулийн зарим нэр томъёо нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулгатай нийцэхгүй байгаагаас шалтгаалж байна.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавих олон нийтийн оролцоотой механизм бүрдүүлэх, Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулга, томъёололд нийцүүлэх замаар тухайн хуулийг сайжруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангахад оршино.

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулсан байдал

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1 дэх хэсэгт дурдсанаар асуудлыг зохицуулах дараах хувилбарууд байна. Үүнд:

1. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
2. Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
4. Төрөөс санхүүгийн интервенц хийх;
5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
6. Захиргааны шийдвэр гаргах;
7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Дээрх 1-6-д заасан хувилбаруудын агуулгаас харахад эдгээр хувилбаруудын аль нь ч энэхүү тайлангийн Хоёрдугаар бүлэгт тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэх хувилбар болохгүй байна. Учир нь энэхүү асуудал үүсэх болсон шалтгаан, нөхцөл нь одоогийн хууль тогтоомжид тухайн асуудлыг зохицуулсан хэм хэмжээний зөрчилдөөн байгаа явдал болно. Тиймээс зөвхөн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбараар зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна. Энэхүү дүгнэлтэд хүрэхдээ хувилбаруудыг сонгосноор зорилгод хүрэх байдал, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр өгөөжийн харьцаа зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж дүгнэсэн болно (хүснэгт №1 үзнэ үү).

Хүснэгт №1. Асуудлыг зохицуулах хувилбаруудын эерэг ба сөрөг талын харьцуулалт

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	<i>Тэг хувилбар</i>	Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлууд хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар нэмэгдэх магадлалтай.	Үр дүн сөрөг
2	<i>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх</i>	Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлуудыг таниулах боломжтой.	Зардал шаардана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад жижиг хэмжээнд нөлөө үзүүлэх магадлалтай.	Зорьж буй үр дүнд хүрэхгүй.
3	<i>Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх</i>	Эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй.	Зардал шаардана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад үзүүлэх нөлөө бага.	Зорьж буй үр дүнд хүрэхгүй.

4	<i>Төрөөс санхүүгийн интервенц хийх</i>	Зорилгыг хангаж чадахгүй.	Зардал шаардана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад жижиг хэмжээнд үзүүлэх нөлөө бага.	Зорьж буй үр дүнд хүрэхгүй.
5	<i>Захиргааны шийдвэр гаргах</i>	АТГ дотооддоо дүрэм, журмыг баталж тодорхой асуудлыг шийдвэрлэж болох хэдий ч зорилгыг хангаж чадахгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зорьж буй үр дүнд бүрэн хүрч чадахгүй.
6	<i>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах</i>	Тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод бүрэн хүрэх боломжгүй байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн зохицуулалтаас энэхүү тайлангийн нэг, хоёрдугаар бүлэгт тодорхойлсон асуудал, шалтгаан нөхцөл үүссэн гэж үзэхээр байх тул зөвхөн “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” буюу аргачлалын 5.1.7-д заасан хувилбараар зорилгодоо хүрэх боломжтой нь харагдаж байна.

Иймд аргачлалын 5 дугаар зүйлийн 5.4-т заасны “5.4.1.Тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол; 5.4.3.Монгол Улсын олон Улсын гэрээгээр Монгол улс тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах талаар тусгайлан үүрэг хүлээсэн бол; гэж заасныг тус тус үндэслэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгов.

1. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах.

2. Хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогоос хамааран хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй бөгөөд АТГ-ын төсөвт тодорхой төрлийн зардал үүсэж болзошгүй.

3. Хуулийн төслийг дагалдан гарах байгууллагын төсвийн зардал нь хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад үр өгөөж нь илүү буюу зардал байж болохуйц хэмжээнд байна.

Дөрөв. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал

Хууль тогтоомжийн **хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу** зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал, хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавих олон нийтийн оролцоотой механизм бүрдүүлэх, Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулга, томъёололд нийцүүлснээр Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан хүний эрхийг хангахад хуулийн төсөл эерэг нөлөө үзүүлнэ (хавсралт №1).

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эрх зүйн зохицуулалтын хувьд эдийн засагт ачаалал үүсгэхгүй, эдийн засгийн таатай орчин үүсэхэд эерэг нөлөө үзүүлнэ. (Хавсралт №2).

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавих олон нийтийн шууд оролцоо нэмэгдэнэ. Мөн эрх зүйн хэм хэмжээг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж хууль дээдлэх ёсны зарчмыг хангана. (Хавсралт №3).

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавих олон нийтийн оролцоотой механизм бүрдүүлэх, Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-

ын конвенцын агуулга, томьёололд нийцүүлснээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй. (Хавсралт №4)

4.5. Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын олон Улсын гэрээ бусад хуультай нийцэж байгаа байдал

Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавих олон нийтийн оролцоотой механизм бүрдүүлэх, Авлигын эсрэг хуулийн зарим хэм хэмжээг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын агуулга, томьёололд нийцүүлснээр Монгол Улсын үндсэн хуулийн хууль дээдлэх ёсны зарчмыг хангаж Авлигын эсрэг НҮБ-ын конвенцтой нийцнэ. (Хавсралт №5)

Тав. Зохицуулалтуудын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, үүссэн асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх дүгнэлт гарсан ба хуулийн төслийн бүтэц, агуулгыг хүснэгт №2-аар харуулж, зохицуулалтын хувилбаруудыг харьцуулав.

Хүснэгт №2. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт

Асуудал	Сонгосон зохицуулалтын хувилбар	Хуулиар зохицуулах нь эерэг үү, сөрөг үү?	Бусад зохицуулалтын хувилбарын эерэг ба сөрөг тал
1-р зүйл. Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт			
“Давуу тал” – энэ нэр томъёог хуульчид янз бүрээр тайлбарлаж хэрэглэсэн, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод заасан агуулгатай нийцээгүй.	Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод зааснаар ойлгож хэрэглэх	Хууль хэрэглэх субъектүүд хуулиа нэг мөр ойлгож хэрэгжүүлснээр нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.	Хуульд тодорхойлж тайлбарласан тул түүнийг сайжруулах хувилбар нь оновчтой.
2-р зүйл. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйл			
Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд буюу Авлигын гэмт хэргийн субъектийг хязгаарласан зохицуулалт үйлчилж байна.	Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод зааснаар ойлгож хэрэглэх	Хууль хэрэглэх субъектүүд хуулиа нэг мөр ойлгож хэрэгжүүлснээр нийгэмд эерэг нөлөө үзүүлнэ.	Хуульд тодорхойлж тайлбарласан тул түүнийг сайжруулах хувилбар нь оновчтой.

3-р зүйл. Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг			
Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт хяналт тавих олон нийтийн оролцоотой механизм бүрдүүлэх	Авлигатай тэмцэх газрын бүтцэд олон нийтийн оролцоотой орон тооны бус хороо байгуулах	Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, хаах санал, шийдвэрийн чанарт эерэг нөлөө үзүүлнэ	Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлд заасан олон нийтийн зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулж уялдааг хангана.

Зургаа. Олон Улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал

6.1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын²⁶ зарим зохицуулалттай харьцуулсан байдал

6.1.1. Нийтийн албан тушаалтны талаар

НҮБ-ын ерөнхий ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний 58/4 дүгээр тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг Монгол Улсын Их Хурал 2005 оны 10 дугаар сарын 27-нд соёрхон баталж, конвенцыг соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг 2006 оны 1 дүгээр сарын 11-нд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар хүргүүлж, улмаар конвенц нь манай улсын хувьд 2006 оны 2 дугаар сарын 10-аас эхлэн хүчин төгөлдөр үйлчилсэн.

Монгол Улсын үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол улс олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 3 дахь хэсэгт Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан.

Авлигын эсрэг конвенцод нэгдэн орсон оролцогч аливаа улс орон конвенцын зорилт, агуулгыг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 2 дугаар зүйлийн (а)-д нийтийн албан тушаалтан гэсэн нэр томъёог дараах агуулгаар тодорхойлсон байна: үүнд:

(I) оролцогч Улсын хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны буюу шүүхийн албан тушаалд томилогдон буюу сонгогдон, байнга буюу түр хугацаагаар,

²⁶ <https://www.iaac.mn/old/pdf/nub/UNCAC.pdf>. Татсан: 2021-09-15

цалинтай буюу цалингүйгээр ажилладаг аливаа хүнийг албан тушаалын зэрэглэлээс нь үл хамааран;

(II) оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид тодорхойлсны дагуу бөгөөд тухайн оролцогч Улсын эрх зүйн холбогдох салбарт хэрэглэж байгаагийн дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг, түүний дотор нийтийн байгууллага буюу Улсын үйлдвэрийн газарт зориулж нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа бусад хүнийг;

(III) оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон аливаа бусад хүнийг;

(IV) оролцогч улсын дотоодын хууль тогтоомжид тодорхойлсны дагуу бөгөөд тухайн оролцогч Улсын эрх зүйн холбогдох салбарт хэрэглэж байгаагийн дагуу нийтийн чиг үүрэг гүйцэтгэдэг буюу нийтийн үйлчилгээ үзүүлдэг аливаа хүнийг;

Тэгвэл Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний явцад нийтийн албан тушаалтны ангилалд зарим албан тушаалтнууд хамаарахгүй байх шалтгаанаар хэрэг хэрэгсэхгүй болсон нь тогтоогдож байна. Тухайлбал, албан тушаалын шийдвэр гаргах эрх мэдэлгүй боловч тусгай мэдлэг, мэргэжил, ур чадварын хүрээнд чиг үүрэг хэрэгжүүлэх, дүгнэлт гаргадаг этгээд, мөн хамтын шийдвэр гаргах хороо, комиссын гишүүний хувьд нийтийн албан тушаалтанд хамаарахгүй байх, эргэлзээ үүсэх, өөрөөр тайлбарлаж эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нөхцөл бүрдсэн байна²⁷.

Мөн 2017 онд шинэчлэн баталсан төрийн албаны тухай хуулийн²⁸ 10-14 дүгээр зүйлд заасан төрийн албан тушаалын жагсаалт болон Авлигын эсрэг хуульд заасан хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн жагсаалтыг нэг мөр болгох шаардлагатай. Тухайлбал, төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлд төрийн үйлчилгээний албан тушаалыг 14.1.1.төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал; 14.1.2.Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал; 14.1.3.яам, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал хамаарахаар заасан байхад Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад зөвхөн

²⁷ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банк, УБ, 2021

²⁸ Төрийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2018 он. №01

удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч гэж хязгаарласан байна.

6.1.2. “Давуу байдал” нэр томъёоны талаар

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын Гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах гэсэн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс бүр санаатайгаар үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна” гээд тус хэсгийн (b) заалтад “нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа аливаа үйлдэл эсхүл эс үйлдэл хийх зорилгоор өөртөө эсхүл өөр хувь хүн, хуулийн этгээдэд зориулж зүй бус давуу байдал олгохыг шууд буюу шууд бусаар шаардах эсхүл ийм давуу байдлыг хүлээж авах” гэж заасан байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын “Конвенцын хамрах хүрээ” гэсэн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэхүү конвенцыг хэрэгжүүлэх зорилгод, энэхүү конвенцод заасан гэмт хэрэг нь энд өөрөөр заагаагүй бол эцсийн дүндээ нийтийн эд хөрөнгөд хохирол буюу гэм хор учруулсан байх албагүй” гэж заасан.

Өөрөөр хэлбэл, нийтийн албан тушаалтан давуу байдал олгох, эсхүл өөртөө давуу байдал бий болгосон үйлдэл, эс үйлдэхүй нь хохирол шаардахгүйгээр гэмт хэрэг байхаар конвенцод зааж өгсөн ба оролцогч улсууд ийм үйлдлийг гэмт хэрэг гэж дотоодын хуульд тусгах үүргээ шударгаар сахин биелүүлэх ёстой билээ.

Манай Улсын эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт Авлигын гэмт хэргийг тодорхойлохдоо давуу байдал бий болгосноор үйлдэл төгсөж гэмт хэрэг байхаар тогтоосон боловч Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 Дэх заалтад нийтийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар “хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдал” олгосон байхаар хуульчилжээ.

6.2. Гадаадын зарим Улсын хуулийн зохицуулалттай харьцуулсан байдал

Авлигын эсрэг тэмцэх хараат бус бие даасан байгууллага байгуулах замаар Авлигатай тэмцэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх гэсэн хандлага олон улсад түгээмэл байх бөгөөд Хонконгийн Авлигатай тэмцэх хараат бус комиссыг загвар болгох, Сингапур улсын авлигатай тэмцсэн амжилтыг сайн туршлага болгон авч үзэх нь дийлэнх байдаг.

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлангаас үзэхэд Авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах ажиллагааг хязгаарлагдмал тооны албан тушаалтнуудын хүрээнд хийж байгаа нь байгууллагын ажилтан, албан хаагчид болон иргэд олон нийтийн АТГ-ын итгэх итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Тиймээс олон Улсын сайн туршлагын дагуу гомдол мэдээллийг хороо, эсхүл ижил төстэй механизм ашиглан хянан үзэх ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Мөн дүн шинжилгээний үеэр АТГ-ын мөрдөгч нараас Авлигын гэмт хэргийн гомдол, мэдээлэл хүлээн авах, хянах ажиллагааг олон талт оролцоо бүхий хороогоор шийдэж байх саналыг дэвшүүлсэн байна²⁹.

Хонконгийн Авлигатай тэмцэх газрын систем: ирүүлсэн бүх гомдол, мэдээллийг 24 цагаар ажилладаг төв судлан үзэж, тэдгээрийн талаарх нэгтгэсэн мэдээллийг ажлын өдрийн өглөө 9 цаг гэхэд АТГ-ын үйл ажиллагааны хэлтсийн удирдлагын хуралд (бүх 7 хэлтсийн ажилтнууд ордог) хүргүүлдэг. Үйл ажиллагааны хэлтсийн даргын удирдан явуулдаг энэхүү хурлаар ирүүлсэн гомдол, мэдээллийг нэг бүрчлэн хэлэлцэж тухайн гомдол, мэдээлэл нь гэмт хэргийн шинжтэй эсэхийг тогтоон, цаашид үргэлжлүүлэн шалгах эсэхийг шийддэг. Гэвч хурлаас гарсан шийдвэр нь эцсийн шийдвэр биш бөгөөд мөрдөн байцаалтад шилжүүлэхгүйгээр шийдсэн хэргүүдийг Монгол Улсын АТГ-ын олон нийтийн зөвлөлтэй ижил төстэй хяналтын чиг үүрэг бүхий үйл ажиллагааны хяналтын хороонд хүргүүлэн үйл ажиллагааны хэлтсийн гаргасан шийдвэрийг баталгаажуулдаг. Хэрэв ирүүлсэн хэргүүдэд мөрдөн байцаалт явуулахыг үйл ажиллагааны хяналтын хорооноос шаардвал АТГ нь мөрдөн байцаалтын үйл ажиллагааг эхлүүлдэг. Энэ нь хяналт, тэнцлийг хангасан систем бөгөөд мөрдөн байцаалт явуулах шаардлагатай гомдол, мэдээллийг хэтрүүлэн үнэлэхгүй эсхүл эрх мэдлээ хэтрүүлэн мөрдөн шалгахаас татгалзах явдлыг бууруулдаг.

АТГ-ын гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгах системд олон нийтийн итгэх итгэл болон эргэн олон нийтэд тайлагнаж байх явдлыг сайжруулахын тулд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн гомдол, мэдээллийг зөвхөн нэг ажилтан шалган шийдэж, дараагийн шатанд шилжүүлж байх бус харин ирүүлсэн бүх гомдол, мэдээллийг бүртгэн, АТГ-ын даргын ахалдаг тусгай баг судлан шалгаж байх. Жилд дунджаар 1500 орчим гомдол, мэдээлэл хүлээн авч буй тул энэхүү баг нь өдөрт ойролцоогоор 4 гомдол, мэдээлэл шалгах тул хэт ачаалалд орохгүй, боломжит байдлаар ажиллах боломжтой юм. Ирүүлсэн гомдол, мэдээллээс хэрэг бүртгэлт,

²⁹ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банк, УБ, 2021. 17 дах тал.

мөрдөн байцаалтын хэрэг нээх шаардлагатай хэмээн үзсэн тохиолдлыг олон нийтийн зөвлөлийн харьяа хороонд шилжүүлэн давхар судлуулж байх нь зүйтэй³⁰.


БНСУ-ын Авлигын гэмт хэргийн талаарх, гомдол, мэдээллийг Авлигын эсрэг, хүний эрхийн хороо хянан үзээд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгадаг байна.

Сингапур Улсын авлигаас урьдчилан сэргийлэх тухай 1960 оны хуулийн³¹ дагуу Авлигатай гэмт хэргийг мөрдөх товчооны бүтцэд захирлын зөвлөлийн гишүүдээс бүрдсэн гомдол, мэдээллийн үнэлгээний хороо (complaints evaluation committee) ажиллах бөгөөд түүнийг товчооны захирал ахалдаг байна.

Тус хороо нь гомдол, мэдээллийг судалж товчооны харьяаллынх эсэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хангалттай мэдээлэл агуулсан эсэхийг тодорхойлж хүлээн авч мөрдөн шалгахаар шийдвэрлэсэн бол мөрдөн байцаалтын ажиллагаанд шилжүүлнэ.

Мөрдөн байцаалт явуулснаар төрийн албан хаагч гэмт хэрэг үйлдсэн нотлогдоогүй боловч сахилга, ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол тухай байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ³² (зураг №1 үзнэ үү).

Зураг №1. Сингапурын Авлигын гэмт хэргийг мөрдөх товчооны гомдол, мэдээллийг хянан үйл явцын зураглал



³⁰ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банк, УБ, 2021. 14 дүгээр хавсралтын 4 дэх тал.

³¹ <https://sso.agc.gov.sg/Act/PCA1960#pr3>- retrieved 2021-09-16

³² <https://www.cpiib.gov.sg/about-corruption/prevention-and-education/management-of-corruption-complaints/> retrieved 2021-09-16

Мөн гомдол, мэдээллийг тусгай дугаарын утсаар, цахим хуудсаар, цахим шуудангаар, бичгээр, факсаар 24 цагийн турш хүлээн авдаг байна.

Монгол Улсын Авлигын эсрэг хуулийн 9 дүгээр зүйлд өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх талаар зохицуулсан. Тус зүйлийн 9.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээд Авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно”, 9.2 дахь хэсэгт “Авлигатай тэмцэх газар нь өргөдөл, гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ” гэж заасан.

Манай Улсын хувьд Авлигатай тэмцэх газарт гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаж шийдвэрлэх үйл явц нь дараах үе шаттай. Үүнд:

- 1) Гомдол, мэдээллийг хүлээн авах (хүлээн авахаас татгалзах);
- 2) Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх (хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах);
- 3) Эрүүгийн хэрэг үүсгэх (хэрэг бүртгэлтийн хэргийг хаах);

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний үр дүнг үндэслэн гомдол, мэдээллийг хүлээн авах, татгалзах үйл ажиллагааг багаар шийдвэрлэдэг болох³³, хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгохын өмнө бие даасан, хараат бус хороо шийдвэрийг хянадаг тогтолцоог хуулийн байгууллагын бүтцэд бүрдүүлэх, энэ боломжийг бүрдүүлэх өөрчлөлтийг Авлигын эсрэг хууль, ЭХХШТХ-д оруулах³⁴ зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

Ийм тогтолцоог бий болгохдоо олон Улсын болон гадаад Улсын эрх зүйн зохицуулалтын сайн туршлагыг авч эрх зүйн рецепци хийх буюу нутагшуулах боломж байна.

Гадаад улс орны их, дээд сургуулийн үйл ажиллагааг зохицуулж байгаа арга, хууль, эрх зүйн байдлыг харьцуулан авч үзэх хүрээнд олон улсад сайн туршлага, загвар болж байгаа Хонконг, Сингапур улсын авлигатай тэмцэх байгууллагад авлигын гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан хэлэлцэж шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч судалж үзсэн болно.

1. Авлигын эсрэг хуульд заасан “нийтийн албан тушаалтан”, “давуу байдал” гэсэн нэр томъёоны тайлбар, агуулгыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх;

³³ Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайлан, Азийн хөгжлийн банк, УБ, 2021. 17 дахь тал.

³⁴ Мөн тэнд 28 дахь тал.

2. Авлигын эсрэг хуульд заасан гомдол, мэдээллийг хүлээн авах талаарх зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зохион байгуулалтын бүтцийг бий болгох, гомдол, мэдээллийг судалж хэлэлцэн шийдвэрлэх олон нийтийн оролцоотой, орон тооны бус зөвлөл бий болгох талаар хуулийн төсөл боловсруулах;

3. Өөрийн Улсын эрх зүйн тогтолцооны онцлогт нийцүүлэн хэрэг бүртгэлтийн хэргийг хаах талаар санал гаргаж прокурорт шилжүүлэхийн өмнө дээр дурдсан зөвлөлөөр хэлэлцэх боломжтой байна. Түүнчлэн тус зөвлөлөөс мөрдөн байцаалт явуулсан хэргийг прокурор, шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг сайжруулах талаар мөрдөгч нарт зөвлөмж өгч ажиллахаар зохицуулж болно гэж дүгнэж байна.

Долоо. Зөвлөмж

Авлигын эсрэг хуульд оруулах шаардлагатай асуудлыг тусгах зорилгоор тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах хувилбарыг санал болгож байна. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1) Авлигын эсрэг хуульд заасан “нийтийн албан тушаалтан”, “давуу байдал” гэсэн нэр томъёоны тайлбар, агуулгыг Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод нийцүүлэх;

2) Авлигатай тэмцэх газарт 24 цагаар гомдол, мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ хийх асуудал;

3) Авлигатай тэмцэх газарт олон нийтийн оролцоотой, орон тооны бус зөвлөл бий болгох;

4) Тус зөвлөлийн эрх хэмжээнд дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх талаар тусгах. Үүнд:

- Гомдол, мэдээллийг судалж хэлэлцэн шийдвэрлэх
- Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах талаар санал гаргаж прокурорт шилжүүлэхийн өмнө дээр дурдсан зөвлөлөөр хэлэлцэх;
- Мөрдөн байцаалт явуулсан хэргийг прокурор, шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг сайжруулах талаар мөрдөгч нарт зөвлөмж өгч ажиллах.

Эх сурвалжийн жагсаалт

Эрх зүйн акт

1. Монгол Улсын үндсэн хууль // төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 он. № 1.
2. Хууль тогтоомжийн тухай хууль // төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015 Он. № 25.
3. Авлигын эсрэг хууль //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2006 он. № 35.
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2012 он. №8
5. Засгийн газрын аргачлал батлах тухай 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал
6. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц
7. Шүүхийн шинжилгээний тухай хууль //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2010 он. №2
8. Эрүүгийн хууль //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016 он. №7
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль //төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №23
10. Компанийн тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2011 он. №42
11. Төрийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018 он. №1

Мэдээлэл, судалгаа, гарын авлага, илтгэл, өгүүлэл

1. Эрдэнэбат А. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн уялдаа холбоо, харьцуулалт, маг.Ажил., ДХИС. 2012
2. Өлзийбаяр В. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны удирдлага. Удирдлагын академи., 2008
3. Авлигын толь., Непко, УБ. 2008

4. Батжав Л нар. Монгол улс дахь хээл хахуулийн гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал., Авлигын эсрэг үндэсний сан. УБ. 2006
5. Батзориг Б нар., Авлига, албан тушаалын гэмт хэрэг. УБ. 2014
6. Жереми поуп., Авлигын эсрэг сурвалж бичиг. Транспаренси интернейшнэл. УБ. 2003
7. Бат Ц., How corruption works болон бусад. УБ. 2014

Цахим хуудас

1. <https://legalinfo.mn/>
2. <https://www.iaac.mn/>

Хавсралт №1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1.1 Ялгаварлан гадуурхахыг хориглох	Тийм	Үгүй	
	1.1.2 Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсэх эсэх	Тийм	Үгүй	
	1.1.3 Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон Улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	
	А. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	АТГ-ын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих нөхцөл бүрдэнэ.
	1.2.2. Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Гомдол, мэдээлэл гаргасан иргэний ашиг сонирхолыг хамгаална.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон хүний эрхийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдэнэ.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон Улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй		

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд нийцсэн байна.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Баталгаа бүрдэнэ.

Хавсралт №2. Эдийн засагт үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнанасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй,	Нэмэлт зардал үүсэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Оюуны өмчийн эрхийг хөндсөн зохицуулалт бий болгохгүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн дагуу зарим чиг үүрэг нэмэгдэх боловч дотоод зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон Улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон Улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

Хавсралт №3. Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Үйл ажиллагааны явцад шинээр ажлын байр үүсэж болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Авлигатай тэмцэх ажлын чанар, стандартад эерэг нөлөө үзүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	АТГ-аас үзүүлэх үйлчилгээ сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Авлигын гэмт хэрэг илрүүлэх, нотлох ажиллагааны чанарт эерэг өөрчлөлт гарна.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	

Хавсралт №4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

5

**ТӨР, НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ПРОКУРОР
ТӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**



“ПРОКУРОРЫН ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТӨР, НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ” СЭДЭВТ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН, ЗӨВЛӨМЖ

Судалгаа боловсруулж, зөвлөмж гаргасан:

Жаргалсайханы Оюунтунгалаг /LL.D./

1. Одоогийн нөхцөл байдлын талаарх ерөнхий дүгнэлт

Төрийг төлөөлөх прокурорын үндсэн чиг үүрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс хяналт тавих, яллах дүгнэлт үйлдэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр прокурорын хяналтыг хэрэгжүүлэх зэрэг уламжлалт ойлголтын хүрээнд тодорхойлогдсоор ирсэн.

1990-Ээд оныг хүртэлх социалист эрх зүйн тогтолцоог хөгжүүлж, төр нийгмийн бүхий л харилцаанд голлох үүрэгтэй чиглүүлэгч байх утгаараа прокурорын “ерөнхий хяналт” гэсэн агуулгаар тодорхойлогдож эрүүгийн хэргээр хязгаарлалгүй иргэний хэрэгт эсэргүүцэл бичих зэргээр оролцдог байсан. 1992 Онд зах зээлийн, чөлөөт эдийн засгийн хэв маяг бүхий нийгмийн тогтолцооны эрх зүйн үндэс болох үндсэн хуулийг баталж, үүнтэй холбоотойгоор төрийн бүрэн эрх, иргэний нийгмийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хангах чиглэлээр эрх зүйн шинэтгэл хийж Монгол улсад 800 гаруй хууль тогтоомжийг батлаад байна.

Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд прокурорын чиг үүрэг, оролцоо, эрх хэмжээний асуудал болон нарийвчилсан процессыг эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудаар, үндсэн чиг үүрэг, зохион байгуулалтын асуудлыг прокурорын тухай хуулиар шинэчлэн зохицуулсаар ирсэн.

Эдийн засгийн харилцаанд төрийн оролцоог хязгаарлах, зах зээлийн өрсөлдөөн, иргэний нийгэм, иргэний хүсэл зоригийн чөлөөт байдлыг хангахад хуулийн тогтолцоо үйлчлэх тухай үндсэн хуулийн үзэл санааг бусад хуулиудаар бэхжүүлэхэд эрх зүйн шинэтгэлийн нэг гол зорилго чиглэгдэнэ. Үүнээс хойш иргэний эрх зүйн харилцаа, иргэний хэрэг, маргаан хянан шийдвэрлэх асуудалд төрийн оролцоог багасгах, хэргийн оролцогч талуудын диспозитив зарчимд үндэслэсэн мэтгэлцээнээр хэргийг шийдвэрлэх дэлхий нийтийн чиг хандлагыг баримтлах чиглэлээр хууль

тогтоомжийг өөрчилсний нэг гол хэсэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийг 2002 онд өөрчлөн найруулж баталсан явдал юм.

Уг хууль батлагдсанаас хойш иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцохтой холбоотой заалтад хэд хэдэн удаа өөрчлөлт орсон байдаг. Энэхүү хуулийн дагуу прокурор нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн оролцогч биш боловч шаардлагатай тохиолдолд оролцож болохоор зохицуулсан байна³⁵. Тухайлбал, төрийн нэрийн өмнөөс оролцох, төрийн болон нийтийн эрх ашгийг төлөөлөн оролцох гэсэн агуулгатай.

Иргэний эрх зүйн харилцаа нь “төр”-ийн эрх ашгаас илүүтэй хувь этгээд хоорондын ашиг сонирхлоо хамгаалсан мэтгэлцээнд суурилсан ажиллагаа гэдгийг харуулж байна. Энэ утга санаа иргэний эрх зүйн харилцааны гол зохицуулалт болохын зэрэгцээ, бусад хуулиудын суурь болох³⁶ Иргэний хууль, түүнд нийцүүлэн гаргасан иргэний эрх зүйн харилцааны нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудад төр болон түүнийг төлөөлөх этгээдийн нэг болох прокурорыг иргэний эрх зүйн харилцааны оролцогч болох талаас нь хуульчлаагүй. Тухайлбал, иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 Дэх хэсэгт иргэний эрх зүйн харилцааны үндсэн оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байхаар, 7.3 Дахь хэсэгт төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцохоор тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, төр нь иргэний эрх зүйн харилцаанд “төр”-ийн үндсэн чиг үүрэг, эрх мэдлийн хүрээнд бус хуулийн этгээдийн нэгэн адил оролцох талаар тодруулан заасан.

Дэлхийн ихэнх улс орнуудад иргэний эрх зүйн харилцаанд төрийн оролцоог хязгаарлах, үүнийг дагаад иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төр, түүнийг төлөөлөх прокурорын оролцоо шаардлагагүй байх чиг хандлага тогтсон байна. Гэсэн хэдий ч иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн болон нийтийн эрх ашиг хөндөгдөх, хамгаалагдах шаардлага үүсэхийг бүрэн үгүйсгээгүй тул дэлхийн улс орнууд өөр өөрийн эрх зүйн тогтолцоо, процессын онцлогтойгоор прокурорын оролцоо, эрх хэмжээг тодорхойлох чиг хандлага тогтсон байна³⁷.

³⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл

³⁶ Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 “Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”, 3 дугаар зүйлийн 3.3 “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.”

³⁷ What is Changing in Prosecution?: Report of a Workshop (2001)

Монгол Улсын хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлээр тодорхойлсны дагуу прокурор иргэний хэрэгт оролцоход дээрх үзэл баримтлалын зөрүүтэй байдал, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогоос шалтгаалан хүндрэл, тодорхой бус байдал үүсдэгийг шүүгч, прокурорын зүгээс тодорхойлж, асуудал хөндөх болсон. Тухайлбал, Улсын Ерөнхий прокурорын газраас 2020 онд прокурорын бичсэн нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл, шийдвэрлэлтийн байдлын талаар хийсэн судалгаанд прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс татгалзахдаа нэхэмжлэл гаргах эрхгүй, төрийн байгууллагын хүсэлт байхгүй, прокурорт итгэмжлэл олгогдоогүй зэрэг үндэслэлүүд түгээмэл байгааг тодорхойлсон байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар “төрийн” болон “нийтийн эрх ашиг” гэдгийг тухайлан тодорхойлоогүй, прокурорын оролцох тохиолдол, нэхэмжлэл гаргах үндэслэлийг нарийвчлан зохицуулаагүй. Үндсэндээ Улсын Дээд шүүхээс 2002 онд гаргасан 263 дугаар тогтоолын хүрээнд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлан хэрэглэж байна. Прокурорын хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, нэхэмжлэл гаргах журмыг “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”-ын хүрээнд тодорхойлж байна.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам тогтоосон хууль нь нийтийн эрх зүйн хэм хэмжээ тогтоодог бөгөөд үүнийг зөвлөмж болон аргачилсан заавар зэрэг тухайн байгууллагын практик, арга зүйн чиглэл, зөвлөмжилсөн актаар нөхөн зохицуулах нь учир дутагдалтай бөгөөд хууль хэрэглээний хувьд заавал биелэгдэх үр дагавар үүсгэдэггүй.

Иймд прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүрээ, эрх хэмжээний асуудлыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Монгол Улсын хувьд прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хязгаарлагдмал оролцооны эрх зүйн үндсийг тодорхой болгоход иргэний эрх зүйн чөлөөт байдлын зарчим, төр, нийтийн эрх ашгийг төлөөлөх асуудлыг хэрхэн зөв зохистой, тэнцвэртэй тусгах асуудлыг судлан, санал дэвшүүлэх шаардлагатай байна.

Иймд судалгааг 1/ үндэсний хууль тогтоомж, 2/ практик хэрэглээ, 3/ гадаад улс орнуудын туршлага гэсэн гурван үндсэн хэсгээр хийж “Судалгааны тайлан” боловсруулж цаашид хууль тогтоомжид оруулах өөрчлөлт болон бусад асуудлаар зөвлөмж дэвшүүллээ.

2. СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Үндэсний хууль тогтоомж, хууль хэрэглээний талаар

1.1. Хууль тогтоомжийн талаар

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд иргэний хэрэгт прокурор оролцох үндэслэлийг Прокурорын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд тодорхойлсон. Иймд эдгээр хуулиудын зохицуулалтыг судлан шинжлэх хэрэгтэй. Үүнээс гадна төр, нийтийн ашиг сонирхолтой холбоотой нэхэмжлэл, хохиролд хамааралтай тодорхой хуулиудыг судлан үзэв. Үүнд, Төсвийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, байгаль орчныг хамгаалах хууль, Авлигын тухай хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, иргэний хууль, захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны ерөнхий хууль, ойн тухай хууль, амьтны тухай хууль, өрийн удирдлагын тухай хууль, төрийн аудитын тухай хууль, төрийн хяналт шалгалтын тухай хууль зэрэг хууль тогтоомжууд дахь төр, нийтийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой зохицуулалтуудыг судлан, шинжилгээ хийв.

Нийтийн эрх зүйн субъект, түүний дотор эрүүгийн шүүн таслах ажиллагааны гол оролцогч болох прокурорын үйл ажиллагааны арга, хэлбэр хуульчлагдсан хэм хэмжээгээр тодорхойлогдох нь төрийн эрх мэдэл хүний эрхээр хязгаарлагдах үндсэн суурь зарчим билээ.

Иймд дээр дурьдсан хуулиудын хүрээнд төрийн, нийтийн эрх ашиг болон иргэний хэргийн оролцогчийн тэгш эрхийн зарчмыг хангахад дараахь хууль тогтоомжийн агуулгыг судлан дүгнэлт санал дэвшүүллээ.
/Хавсралт 1/

А/ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Бидний мэдэж байгаачлан өргөн эрх мэдэл, үйл ажиллагааны хүрээ бүхий прокурорын шүүн таслах ажиллагаанд оролцох оролцоо хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан нийгмийн чиг баримжаанд шилжсэн үеэс зохих хэмжээнд буурч, түүний дотор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд /цаашид “иргэний процесс” гэх/ хязгаарлагдмал болсон.³⁸ Тухайлбал, 2002 оны иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд прокурорын оролцооны талаар “бусдын эрх ашгийг төлөөлөн хэрэг

³⁸ УДШ-ийн 2002 оны 263 дугаар тогтоол

хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох” онцгой тохиолдлыг зохицуулсан зөвхөн нэг заалттай болсон.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн агуулга:

“31.1.Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно. /Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

31.2.Бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу оролцож болно.

31.3.Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос, эсхүл гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй.

Хуулийн дээрх заалтын талаар “иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” УДШ-ийн 2002 оны 263 дугаар тогтоолын 7-д дараахь байдлаар тодорхойлжээ.

“... 31 Дүгээр зүйл. Энэ заалтын "прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх" үндэслэлд Монгол Улсын их хурал, засгийн газар нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн өмчийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор зэрэг асуудлаар үндсэн хууль болон бусад хуулиар тодорхойлсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, иргэний эрх зүйн харилцаанд оролцох явцад маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд уул асуудлыг хариуцах төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй, тийм этгээд бий боловч тэрээр нэхэмжлэл гаргахаас татгалзсан, эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй /эрх нь дуусгавар болсон, эрхийг түдгэлзүүлсэн, зогсоосон зэрэг/ байхыг ойлгоно.”

Энэхүү тайлбарт зааснаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд маргаантай эрх зүйн харилцаанд

оролцох асуудлыг тодорхойлсон байна. Үүнд “хүрээлэн байгаа орчныг хамгаалах”, “байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх”, “төрийн өмчийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах”, “төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор гаргуулах”-тай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төрийг төлөөлөн оролцох боломжтой гэж үзсэн байна. Ийнхүү оролцох тохиолдлыг “төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд байхгүй”, эсхүл “нэхэмжлэл гаргахаас татгалзсан, эсхүл нэхэмжлэл гаргах боломжгүй /эрх нь дуусгавар болсон, эрхийг түдгэлзүүлсэн, зогсоосон зэрэг/” зэрэг гурван зүйлээр тодорхойлжээ.

Дээрх тайлбараас үзэхэд төрийн ашиг сонирхлыг Монгол Улсын Их Хурал, засгийн газар зэрэг төрийн байгууллагууд өөр өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд хамгаалж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох бөгөөд ийм байгууллага байхгүй, нэхэмжлэл гаргахгүй байгаа тохиолдолд прокурор оролцохоор тодорхойлсон гэж үзэхээр байна. Мөн төрийн ашиг сонирхол гэдэгт байгаль орчин, төрийн өмчийн хөрөнгө, нөхөн төлбөрийн гэсэн асуудлууд хамаарахаар практик тогтсон гэж үзэхээр байна. Иргэний хэрэгт прокурор оролцсон талаар хийсэн судалгаанаас ч энэ чиг хандлага харагдаж байна. /Дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ./

Иргэний процесс нь үндсэндээ иргэний эрх зүйн харилцааны тэгш эрхтэй оролцогчдын хооронд үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлэх ажиллагаа болохын хувьд оролцогчдын эрх зүйн байдлын хувьд тэгш байх, хүсэл зоригийн чөлөөт байдал, хөндлөнгөөс үл оролцох зэрэг суурь зарчмуудад үндэслэгддэг. Энэхүү сууриараа диспозитив шинжтэй процесст “төр”, “нийтийн” эрх ашгийг төлөөлөн прокурор оролцох үндэслэл тодорхой, хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагатай юм. Иймд уг асуудлыг Улсын дээд шүүхээс гаргасан дээрх тайлбарын хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэх нь хангалтгүй төдийгүй хэрэглээний нэг мөр байдлыг алдагдуулах, тодорхой бус байдал үүсгэх эрсдэлтэй.

Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт зааснаар иргэний эрх зүйн харилцааны үндсэн оролцогч иргэн, хуулийн этгээд байх бөгөөд “төр” уг харилцааны үндсэн оролцогч бус, харин эдгээртэй адил эрх зүйн байдалтайгаар тодорхой харилцаанд оролцож болох агуулгыг тодорхойлсон. Иргэний эрх зүйн харилцааны оролцогч өөрийн эрх, ашиг сонирхлыг шүүхийн журмаар хамгаалуулахаар нэхэмжлэл гаргах, нэхэмжлэлээ дэмжих, татгалзах зэрэг эрхээ чөлөөтэй, гагцхүү өөрийн хүсэл зоригоо хэрэгжүүлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар хэргийн оролцогчийн эрхийг өөрөө бие даан хэрэгжүүлэх боломж

гэсэн агуулгаар хуульчилсан. Субъектив эрх, ашиг сонирхлын маргааныг иргэний хэрэг гэж үзнэ.

Харин бусдын эрх, ашиг сонирхлын үүднээс иргэний хэрэг үүсгүүлэхээр нэхэмжлэл гаргах нь зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд хэрэглэх онцгой эрхэд хамаарна. Иргэний эрх зүйн онол талаас нь авч үзвэл иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл нь үндсэн дүрмээс гажсан буюу онцлог зохицуулалт юм.

Тодруулбал, прокурор болон бусдын эрхийг хамгаалж нэхэмжлэл гаргах эрх олгогдсон этгээдийн оролцох үндэслэлийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлсон байна. Уг хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 31 Дүгээр зүйлийн 31.1, 31.2 Дахь хэсэгт заасан агуулгыг холбож, системчлэн үзвэл бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж буй оролцогч буюу өөрийнх нь субъектив эрхийн зөрчилтэй хамааралгүйгээр оролцох агуулгатай.

Хуулийн 31.1 дэх хэсэгт “прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж хэд хэдэн нөхцөлийг тогтоосон байна. Үүнд прокурор нь “төрийн”, “нийтийн ашиг сонирхол” зөрчигдсөн гэх хоёр хүрээнд төрийн байгууллагын хүсэлтээр эсхүл өөрийн санаачилгаар гэсэн хоёр ерөнхий тохиолдлыг хуульчилсан байна.

Төрийн байгууллагын хүсэлтээр оролцох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулаагүй хэдий ч практикт харьцангуй хэвшиж тогтсон байх бөгөөд прокурорын байгууллагын үйл ажиллагааны дотоод акт болох “прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”-ын хүрээнд зохицуулагдаж байна. Төрийн ашиг сонирхлыг засгийн газар, түүний харьяа агентлаг, төрийн байгууллагууд тус бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамгаалах, төлөөлөх нь үндсэн хууль болон бусад хуулийн хүрээгээр тодорхойлогдоно. Энэ нь төрийн байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд тухайн байгууллагын итгэмжлэлтэйгээр шууд нэхэмжлэл гаргах, эсхүл гуравдагч этгээдээр оролцох байдлаар хэрэгжиж байна.

Дээрх тодорхой бус байдлыг бүрэн арилгаагүй тул “нэхэмжлэгч”, “хариуцагч” болох төрийн байгууллагыг шууд төлөөлөн оролцох, эсхүл “гуравдагч этгээд”-ийн хувиар бие даан оролцож болох эсэхийг тодорхой болгох хэрэгтэй байна.

Уг заалтын хүрээнд дараагийн нэг асуудал бол “өөрийн санаачилгаар” оролцох үндэслэлийг тодруулах шаардлагатай байна. Эдийн засаг, иргэний эрх зүйн харилцаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг эрхлэн хариуцах төрийн байгууллага байгаа тохиолдолд прокурор өөрийн санаачилгаар оролцох нь эрх хэмжээг хэт өргөжүүлсэн асуудал болох тул үүнийг тодорхой болгох хэрэгтэй. Нийтийн эрх ашиг гэдэгт төрийн ашиг сонирхол багтах, энэ нь төрийн байгууллагын алины ч эрхлэх асуудалд хамаарахгүй байгаа тохиолдлыг хамрах байдлаар тодорхойлох хэрэгтэй байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд бусад этгээдүүдийг төлөөлж оролцохыг хориглосон зохицуулалттай зөрчилдөж болзошгүй.

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчийн эрх, үүргийг эдлэхээр заасан нь тодорхой байх боловч зарим заалттай зөрчилдөөн /коллизи/ үүсгэж болзошгүй юм. Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5.3-т шүүгч, прокурор, мөрдөгч нарыг “бусдыг” төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг хориглосон байдаг. Уг заалт нь прокурор иргэнийхээ хувьд, түүнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход хамаарахгүй.

Гол асуудал нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний эрх зүйн харилцааны тодорхой оролцогчдын хоорондын “ашиг сонирхол”-ын маргааныг шийдвэрлэхэд зориулагдсан хууль учир хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцдог шүүгч, прокурор, мөрдөгч нарын оролцоог төлөөллөөр дамжуулан хязгаарласан байдаг. Иймд хуулийн энэ хэсгийг тодруулснаар “нэхэмжлэгч”, “хариуцагч” болон төрийн байгууллагыг төлөөлөн оролцох боломжтой болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд зөвхөн прокурор төдийгүй бусад этгээдийн эрх ашгийг хамгаалж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох этгээдүүдийн оролцоог хангасан байдаг. Хуулийн уг заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг дагаж гарсан хууль тогтоомжийн хүрээнд өөрчилсөн байх бөгөөд прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхигүй байр сууринаас оролцдог байсныг идэвхтэй байдалд шилжүүлэх хандлагатай болж байгааг өмнө дурьдсан.

Хэргийн оролцогчид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан журмын дагуу эдлэх эрх, хүлээх үүргээ тэгш байдлын зарчмын хүрээнд хэрэгжүүлнэ. Иймд прокурор нь нэхэмжлэл, тайлбар гаргах төдийгүй нотлох баримт бүрдүүлэх, үнэлэх ажиллагаанд хэргийн оролцогчидтой адил тэгш эрхтэй оролцоно.

Энэхүү тэгш байдлын зарчмыг алдагдуулсан шинжтэй агуулга “төрийн нэрийн өмнөөс” гэсэн байдлаар томъёолсон байна. Прокурор эрүүгийн хэрэгт төрийн нэрийн өмнөөс яллах, хяналт тавих эрхтэй боловч иргэний хэрэгт хэргийн бусад оролцогчийн адил эрх, үүрэг хүлээх тул энэ нэр томъёог өөрчлөх, “төрийг төлөөлөн” гэсэн агуулгаар тодорхойлох хэрэгтэй юм.

Хэргийн оролцогчийн субъектив эрхийн хүрээнд тодорхойлогддог эвлэрэн хэлэлцэх эрхийг прокурорт адил тэгш олгох нь төдийлөн зохимжтой бус бөгөөд зарим улс оронд энэ эрхийг хуулиар олгохгүй байх, эсхүл хэргийн оролцогчийн эрхээс эвлэрэн хэлэлцэх эрхгүй болохыг тодорхой заасан байдаг.

Б/ прокурорын тухай хууль

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд өөрчлөгдөн батлагдсан Прокурорын тухай хуульд прокурорын иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох чиг үүргийг тухайлан зааж, 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийг дагаж өөрчлөлт орсон хуулиудын хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд прокурорын оролцооны талаарх өмнөх заалтыг тодотгон хуульчилж, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөхөөр болсон.

Одоо мөрдөгдөж буй хуулийн хүрээнд прокурор иргэний процесст оролцсон асуудлаар тодорхой практик судалгаа хийгдэж, үүсэж буй хүндрэлтэй нөхцөл байдлуудын талаар тоо, мэдээлэл гаргасан байна.³⁹ Судалгааны хүрээнд төр, нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх талаар асуудал үүсэж, нэхэмжлэлийг хүлээн авах асуудал нэг мөр шийдвэрлэгдэхгүй байгааг тодорхойлсон байна.

³⁹ 2018-12-27-2019-12-25-ны Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн болон нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн үндэслэлээр оролцсон талаарх судалгааны дүнгийн талаарх мэдээлэл /2021.04.26, Улсын Ерөнхий Прокурорын газрын Шүүхэд төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алба /

Прокурорын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т “захиргааны болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж, 20 дугаар зүйлд “төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах” агуулгыг тодорхойлсон байна. Энэхүү оролцооны эрх зүйн үндэслэлийг Прокурорын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад ерөнхий байдлаар зохицуулсан байх боловч оролцооны арга, хэлбэр зэргийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай. Прокурор эрүүгийн хэрэгт “төрийн нэрийн өмнөөс” яллах чиг үүрэгтэй оролцдогтой адил биш, өөр зорилготой. Тодруулбал, прокурор иргэний хэрэгт төрд учирсан хохирол барагдуулах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зэрэг чиг үүргийн хүрээнд оролцох тул “төрийг төлөөлөн” гэсэн агуулгаар тодруулан өөрчлөх хэрэгтэй байна.

Прокурорын тухай хуульд прокурорын үйл ажиллагаа нь “хуулийг нэг мөр хэрэглэх байдлыг хангах”-д чиглэсэн байхаар тодорхойлжээ. Тодруулбал, уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “прокурор үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хуулийг баримталж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг хангана” гэж заасан.

Хуулийн энэхүү заалтын хүрээнд прокурорын үйл ажиллагаа, чиг үүргийг авч үзэхдээ Шүүхийн тухай хуульд заасан хяналтын шатны шүүхийн чиг үүрэгт хамаарах “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах”-аас нарийн зааглан ялгах шаардлага үүсэх юм. Хуульчдын хувьд уг хуулийн системчлэлийн хүрээнд ойлгомжтой мэт байх боловч иргэдийн хувьд төөрөгдөл үүсгэж болзошгүй. Өөрөөр хэлбэл, зарим улс орнуудын /БНХАУ зэрэг/ нэгэн адил эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль нэг мөр мөрдөгдөж байгаа эсэхийг иргэний хэрэгт хангах агуулгаар ойлгож, хэрэглэх эрсдэлтэй.

Манай Улсын хувьд зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “прокурорын хяналт”-ын төрлийг бий болгосноор захиргааны шинжтэй зөрчил шийдвэрлэх ажиллагаанд хүртэл прокурорын оролцоо хүрээгээ тэлсэн байгааг анхаарах нь зүйтэй. Энэхүү хяналтын чиг үүрэг иргэний хэрэгт оролцох оролцоонд хамаарахгүй болохыг тодорхой болгох шаардлагатай.

Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 Дэх хэсэгт “төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл, тайлбар гаргах” тухай зохицуулалт нь “Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр” гэсэн дөрөвдүгээр бүлэгт орсон байна. Зөрчлийн болон эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий прокурор

иргэний хэрэгт нэхэмжлэл, тайлбар гаргах хэлбэрээр хяналт тавих асуудлыг тодорхой болгох шаардлага байна. Үүнийг прокурорын хяналтын уламжлалт ойлголтоос ялган өөрөөр томъёолох шаардлагатай.

Мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “прокурорын нэхэмжлэл, тайлбар, гомдол нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлага хангасан байх” гэж хуульчилсан байх боловч оролцох оролцоог нарийвчлах хэрэгтэй. Тодруулбал, төрийн болон нийтийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн гэж үзэж байгааг нэхэмжлэлдээ тодорхойлсон байх зэрэг болно.

Прокурор “төрийн” болон “нийтийн” ашиг сонирхлыг төлөөлөх эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах нарийвчилсан журам нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль байна. Тухайлбал, Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох үндэслэлийг “төрийн байгууллагын хүсэлтээр эсхүл өөрийн санаачилгаар” оролцох талаар, мөн зүйлийн 20.4 дэх хэсэгт “итгэмжлэлгүйгээр” оролцох эрх зүйн үндэслэлийг тодорхойлжээ.

Төрийн байгууллагын хүсэлтээр прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь шинэ зохицуулалт биш бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу оролцсоор ирсэн. Гэвч төрийн байгууллагын зүгээс ямар тохиолдолд прокурорыг оролцуулах шаардлагатай гэж үзэх талаар нарийвчилсан зохицуулалт⁴⁰ байхгүйн улмаас прокурор төрийн байгууллага болон иргэд хоорондын түрээсийн гэрээний зэрэг иргэний эрх зүйн маргаанд “төрийн” гэж үзэх ямар эрх, ашиг сонирхлыг хамгаалж байгаа нь тодорхой бус байх тохиолдол гарч байсан.

Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн хүрээнд хөндөгдөж буй дараагийн асуудал бол “өөрийн санаачилгаар” нийтийн эрх ашгийг хамгаалан оролцох талаар мөн л нарийвчилсан зохицуулалт аль ч хуульд байхгүй байна. Нийтийн эрх ашгийг төлөөлөн прокуророос өөр субъект, тухайлбал, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд “байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох” талаар заасан байдаг. Эдгээр хуулийн дагуу нийтийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий байгууллага оролцсон тохиолдолд прокурор гуравдагч этгээдийн хувиар оролцох эсэхийг тодорхой болгох хэрэгтэй байна.

⁴⁰ УДШ-ийн 2002 оны 263 дугаар тогтоолын 7-д прокурорын оролцож болох хэргийн төрөл тохиолдлыг тодорхойлсон

Ийм тохиолдол түгээмэл гараагүй боловч нийтийн эрх ашгийг төлөөлөн гаргаж буй нэхэмжлэлийн агуулга буюу хариуцагчаас шаардаж буй мөнгөн хөрөнгийг хэнээс, хэнд гарган олгох зэрэг нь тодорхой бус, уг нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл, түүнд хамаарах иргэний эрх зүйн маргаан тодорхой бус болох тохиолдол гарч байсан. Иймд нэхэмжлэлийн төрөл, түүний хууль зүйн үр дагаврыг тухайлан тодорхойлох шаардлагатай юм.

Иргэний процессын төлөөллийн асуудлыг иргэний эрх зүйн хэлцэлд төлөөлөх ерөнхий зохицуулалтын хүрээнд тодорхойлдог⁴¹ бөгөөд иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэгт заасан төлөөлөл нь хувь этгээдийн эрх ашгийг төлөөлөх хэлцэл хийхэд хамаардаг.

Харин прокурорын төлөөллийг “хуулийн” дагуу буюу “итгэмжлэлгүйгээр төлөөлөх” гэсэнтэй дүйцүүлэн Прокурорын тухай хуульд заасан боловч иргэний эрх зүйн төлөөлөл биш юм. Үүнээс үзвэл, нэгдүгээрт, прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт заасан агуулга зөвхөн “нийтийн” болон “төрийн” эрх ашгийг төлөөлөх гэдгийг тодруулан илэрхийлсэн болохоос иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийг “хуулийн дагуу” төлөөлөх төлөөлөл биш юм.

Монгол улсад чиг үүргээ хэрэгжүүлж буй бүх прокурорууд нийтийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэн, бие даан итгэмжлэлгүйгээр оролцох эрхтэй гэж ойлговол Прокурорын байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл байдалтай хэрхэн уялдах нь тодорхой бус байх тул нарийвчилсан зохицуулалт шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор шүүхээс иргэний хэрэг үүсгэх ажиллагаанд багагүй хүндрэл үүсэж байгаа нь прокурорын байгууллагаас хийсэн судалгаанаас харагдаж байна⁴².

Прокурорын тухай хуулийн 21 дүгээр зүйлд прокурор “шүүхийн шийдвэрт гомдол гаргах”, түүнийгээ “буцаан татах”, “нэхэмжлэл, тайлбар, хүсэлт, гомдол гаргах” зэрэг эрхийг эдлэхээр заасан бөгөөд энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай зөрчилдөхөөргүй, адил утгаар хэрэгжих учиртай. Тухайлбал, прокурор иргэний процессын талуудын тэгш эрхийн зарчмын хүрээнд хэргийн оролцогчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээж оролцоно. Өөрөөр хэлбэл, прокурорын нотлох баримт бүрдүүлэх, тайлбар, татгалзал гаргах асуудал нь иргэний хэрэг шүүхэд хянан

⁴¹ Иргэний хуулийн 62 дугаар зүйл

⁴² 2018-12-27-2019-12-25-ны Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн болон нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн үндэслэлээр оролцсон талаарх судалгааны дүнгийн мэдээлэл /2021.04.26, Улсын Ерөнхий Прокурорын газрын Шүүхэд төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алба /

шийдвэрлэх тухай хуульд заасан журмын хүрээнд бусад оролцогчтой нэгэн адил байна.

Гэтэл прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй” гэж заажээ. Тодруулбал, нотлох баримт бүрдүүлэхтэй холбоотой прокурорын эдлэх эрхийг тусгайлан тодорхойлсон байна.

Энэ нь иргэний хэргийн оролцогчдын нотлох баримт цуглуулах тэгш эрхийн зарчимтай⁴³ зөрчилдөж болзошгүй юм. Жишээлбэл, нөгөө талаас болон бусад этгээдээс нотлох баримт шаардан гаргуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагааг хэргийн оролцогч өөрөө бие даан хэрэгжүүлэх боломжгүй, шүүхийн туслалцаатайгаар бүрдүүлдэг.

Иймд хуулийн энэхүү заалтын хүрээнд эрхээ эдлэхдээ хэргийн оролцогчийн нотлох баримт бүрдүүлэх эрхийг тодорхойлсон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 38 дугаар зүйлтэй прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийг уялдуулан хэрэглэх шаардлагатай. Харин Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэж тодотгон хуульчилсан боловч адил, тэгш эрхтэй гэдгийг тодруулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нотлох баримт бүрдүүлэх хүрээнд бусад оролцогчоос давуу эрх эдлэхгүй болно.

В/ нийтийн болон төрийн ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй бусад хууль

Төсвийн тухай хууль

Төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт, хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх хохирол нь нийтийн буюу төрийн эрх ашигт хамааралтай. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 Дэх хэсэгт “төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг

⁴³ Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2015, х.17

байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” Гэж заасан. Энэ заалт нь хохирол үүсгэхгүй байхад чиглэсэн **“ex-ante”** арга хэмжээ байна.

Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарах талаар төсвийн тухай хуульд заажээ.⁴⁴ Үүнээс үүсэх хариуцлагыг хэн хүлээх асуудал, энэхүү үүрэг тодорхой хуульчлагдаагүй, зөвхөн аудитын эрхлэх хүрээг тусгасан байна.

Өөрөөр хэлбэл, **“ex-post”** арга хэмжээ тодорхой бус байна. Төсвийн тухай хуулийг зөрчсөнөөс төрд учирсан хохирлыг арилгуулах нэхэмжлэл гаргах эрхийн талаар зохицуулалт байхгүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн талаар

Төрийн өмчийн эд хөрөнгөд хохирол учрах, төрийн өмчтэй хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан эрх хэмжээгээ хэтрүүлсний улмаас төрийн буюу нийтийн эрх ашиг сонирхолд хор уршиг учруулах тохиолдол зэргийг хуулиар зохицуулсан. Тодруулбал, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлээр төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын эд хөрөнгийн эрх, үүргийг тодорхойлж, 5 дахь заалтад “Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.” Гэж заасан.⁴⁵ Мөн зүйлийн 8 дахь заалтад “маргаантай асуудлаар үйлдвэрийн газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах” эрхийг, мөн хуулийн 31 дүгээр зүйлд төрийн өмчийн эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах журмыг тодорхойлж, 5 дахь заалтад “осол, гэмтэл гарсан шалтгааныг тогтоож, хэрэв тодорхой этгээдийн буруугаас уг осол, гэмтэл гарсан бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг арилгуулах” гэж тогтоожээ.

Уг хуулийн 73 дугаар зүйлд эд хөрөнгийн тооллого явуулах журмыг тодорхойлж, 4 дэх заалтад “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг

⁴⁴ Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг

⁴⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг

хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ” гэсэн ерөнхий байдлаар тодорхойлсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн хянан шалгах хороо, Сангийн яам болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ.” Гэж заасан. Өөрөөр хэлбэл, төрийн хяналт шалгалт хийх эрхтэй этгээдийг нэрлэн заасан байх боловч хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хохирлыг барагдуулахаар нэхэмжлэл гаргах талаар зохицуулалт байхгүй байна.

Өөрөөр хэлбэл, төрийн эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн тодорхой зохицуулалт шаардлагатай байна. Эдгээр эрх, үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдолд үүнээс үүсэх хохирлыг хариуцах, эсхүл шүүхэд маргаантай асуудлаар нэхэмжлэл гаргах асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна.

Байгаль орчинд учруулсан хохирлын талаар

Байгаль орчныг хамгаалах хуулийн 49 дүгээр зүйлээр байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг тодорхойлсон бөгөөд 1 дэх хэсэгт “иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан байгаль орчин, уур амьсгалын санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг байгаль орчин, уур амьсгалын сангаас буцаан олгоно” гэж, 8 дахь хэсэгт “Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.” гэж заасан. Энэ нь захиргааны байгууллагын хүрээнд хохирлын тодорхой хэмжээг арилгуулах боломжтой байна.

Дээрхээс гадна мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий

байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” замаар байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох талаар заасан. Энэ хүрээнд төрийн бус байгууллагаас нэхэмжлэл гаргах тохиолдолд хохирлыг “хэн”-д гаргуулан олгох нь тодорхой бус байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсан тохиолдол гарсан. Энэ тохиолдолд Засгийн газрын тусгай сангаар дамжуулан төсөвт оруулах байдлаар өөрчлөлт оруулах, үүнтэй холбоотой прокурор оролцох шаардлага үүсэж болох юм.

Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлээр төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах журмыг тодорхойлохдоо 25.1.1-д “ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” тодорхойлсон байх бөгөөд энэ тохиолдолд хохирлын нөхөн төлбөрийг шилжүүлэх газар нь тодорхой байна.

Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлээр амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тодорхойлж, 37.1 дэх хэсэгт “Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж заасан бөгөөд уг нэхэмжлэлийг гаргах этгээд тодорхой бус байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, төсөвт учруулсан хохирлын талаар

Авлигын эсрэг хуулийн 34.1-д “Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль бус аливаа шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.” гэж заасан. Авлигын гэмт хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг арилгуулахаар иргэний болон захиргааны шүүхэд хандах эрхтэй этгээд тодорхой бус байна. Одоогийн практикт прокурор нэхэмжлэл гаргаж байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлд өрийн удирдлагын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон бөгөөд 45.4 дэх хэсэгт “Зөрчлийн хэлбэр, хүлээлгэх хариуцлагаас үл хамааран энэ хуулийг зөрчсөний улмаас төрд хохирол учруулсан буруутай этгээд уг хохирлыг төлж барагдуулна” гэж заасан. Нэхэмжлэл гаргах этгээд тодорхой бус байна.

Төрийн аудитын тухай хуулийн 36 дугаар зүйлээр төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх журмыг тогтоож 36.1-д “Төрийн аудитын байгууллага тухайн жилд Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүр үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршуулна” гэж заажээ. Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг нэхэмжлэх эрхийн асуудлыг тодорхойлоогүй.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4, 60.3.5-д заасны дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, “зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах”-д зарцуулахыг хориглоно гэж заасан. Үүнээс үүссэн хохирлыг барагдуулах, эдгээр хэлцлийн хүчин төгөлдөр байдлын талаар тухайн байгууллага маргахгүй тохиолдолд төрд учруулсан хохирлыг нэхэмжлэх этгээдийг заагаагүй байна.

Нийтийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бусад хууль тогтоомжийн талаар

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл, 52 дугаар зүйл, 10 дугаар зүйлүүдэд хяналт шалгалт хийх нийтлэг журам, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх журам, мэргэжлийн хяналтын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг тодорхойлохдоо нийтийн эрх ашигт хохирол учруулсан байх нөхцөлийг тодорхойлсон байна. Үүнтэй холбоотойгоор авах зөрчлийн арга хэмжээг тодорхойлсон бөгөөд хохирол нөхөн төлүүлэх асуудал тодорхой бус байна.

Зөрчлийн болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

Аливаа хүн, хуулийн этгээд нийтийн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний улмаас төрийн болон нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдол байдаг. Жишээлбэл, Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд “Ойн тухай хууль зөрчих”, 10.19 дүгээр зүйлд “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль зөрчих”, 11.2 дугаар зүйлд “Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих”, 11.19 дүгээр зүйлд “Татварын хууль зөрчих”, 11.1 дүгээр зүйлд “Аудитын тухай хууль зөрчих” зэрэг зөрчлүүдийг зохицуулсан байна. Хуулийн хэм хэмжээг зөрчсөн хүн, хуулийн этгээдийг зөрчлийн тухай хуульд зааснаар торгох нийтлэг зохицуулалттай.

Харин уг зөрчлийн улмаас төр, нийтийн эрх ашиг хөндөгдсөн бол хохирлыг хэрхэн арилгуулах талаар зохицуулалт тодорхой бус байна.

Шийтгэлийг хөнгөрүүлэх хүрээнд “хохирол барагдуулах” гэх нөхцлийн хүрээнд хэрэгжиж байна.

Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуульд дээрх хуулиудад заасан үүргээ биелүүлээгүй, хуулийн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг шалгах эрх бүхий субъектийг тодорхойлсон. Жишээлбэл, мэргэжлийн хяналтын Улсын байцаагч, татварын Улсын байцаагч, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч зэрэг субъектүүд зөрчлийг шалган шийдвэрлэж, холбогдох санкцыг ногдуулах талаар хуульчилсан байна.

1.2. Хууль хэрэглээний практикийн талаарх судалгаа

Одоогийн практикийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь прокурорын оролцооны талаарх а/ Улсын Ерөнхий Прокурорын газраас хийсэн судалгааг эх сурвалж болгох боломжтой байгаагаас гадна б/ прокурорын оролцсон шүүхийн шийдвэр, захирамжуудад шинжилгээ хийж, в/ нийслэлийн дүүргүүдийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нараас асуулгын судалгаа авч дүнг нэгтгэв. /Хавсралт 2/

а/ Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албанаас 2020 онд улсын хэмжээнд прокурорын бичсэн нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл, шийдвэрлэлтийн байдлыг судалжээ. Уг судалгаанаас үзэхэд 2020 онд прокуророос нийт 283 нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. Тодруулбал, зээлийн төлбөр гаргуулахаар 142, шимтгэл өр төлүүлэхээр 2, эрүүгийн болон зөрчлийн улмаас төрд учирсан гэм хорын хохирол нөхөн төлүүлэхээр 82, төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халснаас төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаас гаргуулахаар 23, аудитын хяналт шалгалтаар тогтоосон зөрчлийг арилгуулахаар 13, бусад 21 /ажил гүйцэтгэх гэрээ, газрын төлбөр, түрээсийн гэрээ, хөдөлмөрийн маргаан, хариуцагчийг эрэн сурвалжлах гэх мэт/ маргаантай холбоотой нэхэмжлэл гаргажээ.

Дээрх нэхэмжлэлийн 52 буюу 18.4 Хувийг шүүхэд төрийг төлөөлөх ажил хариуцсан прокурорууд, 64 буюу 22.6 Хувийг итгэмжлэлгүйгээр оролцох эрхтэй тухайн нэгжийн ерөнхий прокурор, үлдсэн 167 буюу 59 хувийг бусад прокурорууд гаргасан байна.

Нэг төрлийн маргаанд хэд хэдэн нэхэмжлэл бичихдээ прокурорууд нэг нэгээсээ хуулбарласан хэлбэртэй, зээлийн төлбөр гаргуулах нэхэмжлэлд зээлийн гэрээний хугацаанд төлсөн болон төлөгдөөгүй зээл, хүү, алданги зэргийг тусад нь тооцоолж тусгаагүй, мөн зээлийн хүү, алданги тооцохгүй тусгай сангийн зээлийг дэлгэрэнгүй бичдэггүй зэрэг нийтлэг алдаа гаргасан байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүх прокурорын гаргасан нэхэмжлэлээс 101 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 104 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 12 нэхэмжлэлийг бүхэлд хангаж, 6 нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж, 36 нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 3 хэргийг түдгэлзүүлж, ажиллагаанд 21 хэргийн үлдэгдэлтэй байгаа талаар дурьджээ.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэхдээ дараах үндэслэлүүдийг заажээ. Үүнд, нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан /65.1.5/ Үндэслэлээр 69, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийн заалтыг хангаагүй /65.1.6/ Үндэслэлээр 7, хариуцагчийн хаяг тодорхойгүй /65.1.9/ Үндэслэлээр 4, хариуцагч нас барсан /65.1.10/ Үндэслэлээр 2, нэхэмжлэлд тусгавал зохих зүйлийг тусгаагүй буюу бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй /65.1.11/ Үндэслэлээр 9, хэргийн харьяалал зөрчсөн /65.1.1/ Үндэслэлээр 5, шүүхийн харьяалал зөрчсөн /65.1.2/ Үндэслэлээр 3, шүүхээр баталгаажуулах хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх /65.1.3/ Үндэслэлээр 2 нэхэмжлэлийг шийдвэрлэжээ. Үүнээс нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан /65.1.5/ Үндэслэл 67 хувийг эзэлж, шүүхийн дүгнэлт хийсэн байдал шүүх болон шүүгчээс хамааран өөр өөр байна.

Мөн шүүх нэхэмжлэлийг хүлээн аваад иргэний хэрэг үүсгэсэн боловч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 Дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл тогтоогдож 30 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснээс нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан /65.1.5/ Үндэслэлээр 6, хариуцагчийн хаяг тодорхойгүй /65.1.9/ Үндэслэлээр 15, хариуцагч нас барсан /65.1.10/ Үндэслэлээр 1, шүүхээр баталгаажуулах хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх /65.1.3/ Үндэслэлээр 7, нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа /65.1.8/ Үндэслэлээр 1 тус тус шийдвэрлэжээ.

Шүүх прокурорын гаргасан нэхэмжлэлээс 182 нэхэмжлэл буюу 64.3 Хувьд иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан боловч иргэний хэрэг үүсгэсний дараа 30 нэхэмжлэл буюу 10.6 Хувийг хэргийг хүлээн авахаас татгалзах үндэслэл тогтоогдсон гэж хэрэгсэхгүй болгож, 75 нэхэмжлэл буюу 26.5 Хувийг прокурор нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй гэж дүгнэсэн байна.

Шүүх иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн нийт 104 хэргийн 25 буюу 24 хувийг эвлэрүүлэн зуучлагчид хүсэлт гарган шүүхээр

баталгаажуулсан, 14 буюу 13.5 Хувийг зохигчид эвлэрснийг, 46 буюу 44.2 Хувийг хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснийг, 12 буюу 11.5 Хувийг хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг тус тус баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, 5 буюу 4.8 Хувийг нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаар, 2 буюу 1.9 Хувийг нь нэхэмжлэлийг прокурорт буцаасан.

Судалгааны явцад 21 хэрэг буюу 7.4 Хувь шийдвэрлэгдээгүй, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байна. Үүнээс зээлийн төлбөр гаргуулах 8, гэмт хэрэг, зөрчлийн улмаас төрд учирсан хохирол арилгуулах 11, төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халсан, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тус бүр 1 хэрэгт ажиллагаа хийгдэж байна.

Дээрхээс үзэхэд шүүх прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэхдээ нэхэмжлэл гаргах эрхгүй, төрийн байгууллагын хүсэлт байхгүй, нэхэмжлэлийн шаардлага үндэслэл тодорхойгүй зэрэг түгээмэл үндэслэл заадаг байна. Түүнчлэн, прокурорын нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг боловч хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх тохиолдолд нэлээдгүй байгаа нь хуулийг нэг мөр хэрэглэх боломжгүй байгааг харуулж байна.

б/ Сум дундын болон дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн прокурорын гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 48 захирамж, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 46 захирамж, хэргийг хэрэгсэхгүй болгосон 20 шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Мөн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцсон 90 шүүхийн шийдвэрийг судаллаа.

Прокурорын шүүхэд гаргасан нэхэмжлэлийг маргааны төрлөөр ангилбал, зээлийн төлбөр гаргуулах, байгаль орчинд учруулсан хохирол гаргуулах, эрүүгийн болон зөрчлийн улмаас төрд учирсан гэм хорын хохирол нөхөн төлүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах, нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халснаас төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаас гаргуулах, бусад /хариуцагчийг эрэн сурвалжлуулах/ зэрэг байна.

Дээрх нэхэмжлэлийг гаргахдаа прокурор нь төрийн болон нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэх үндэслэл зааж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 31 Дүгээр зүйл,

прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 41 Дүгээр зүйлийн 41.1 Дэх хэсэгт заасныг баримталжээ.

Анхан шатны шүүхээс прокурорын гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэхдээ “нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх-3”, “нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй”-16, “нэхэмжлэх эрхтэй этгээд шаардах эрхээ шилжүүлсэн эсэх-3”, “төрийн байгууллагын хүсэлтгүй”-1, “нэхэмжлэлийн шаардлага үндэслэл тодорхойгүй”-19, “хэргийн харьяалал зөрчсөн”, хариуцагчийн хаяг тодорхойгүй”-2, “нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй”-7 гэсэн үндэслэлүүд заасан байна.

Мөн прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэсэн боловч “хариуцагч нас барсан”, “хариуцагчийн хаяг тодорхойгүй”, “нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа”, “нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан”, “нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан” гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Зохигчид эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн болон биелүүлсэн гэх үндэслэлээр хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна.

Иргэнээс шүүхэд гаргасан цагаатгалын нөхөн олговор гаргуулах, хууль бусаар эрүүгийн хэрэгт татагдсанаас учирсан хохирол гаргуулах, садан төрлийн холбоо тогтоолгох тухай нэхэмжлэлд төрийн байгууллагын буюу Жижиг, дунд үйлдвэрийн газар, Төрийн албаны зөвлөл, Хүний эрхийн үндэсний комисс болон Нийгмийн даатгалын хэлтсийн гаргасан нэхэмжлэлд шүүх иргэний хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурорыг оролцуулж, хэргийг эцэслэн шийдвэрлэсэн байна.

Шүүх прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэх, хэргийг шийдвэрлэхдээ хуулийг өөр өөрөөр тайлбарласан байна. Тодруулбал, прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх, үүрэг, эрх зүйн байдал тодорхойгүйгээс түүний гаргасан нэхэмжлэлийг олон төрлийн үндэслэл заан хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэж байна. Харин прокурор төрийн байгууллагын хүсэлтээр гуравдагч этгээдээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон тохиолдолд хэргийг эцэслэн шийдвэрлэжээ. Жишээлбэл, цагаатгалын нөхөн олговор, хууль бусаар эрүүгийн хэрэгт шалгагдсаны улмаас хохирол гаргуулах зэрэг нэхэмжлэлтэй хэрэг. Иймээс прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох маргааны төрлийг хуульд тухайлан заах шаардлагатай байгааг илтгэнэ.

в/ Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдээс 8 асуулга бүхий “Прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх зүйн байдлыг тодруулах” зорилгоор асуулгын аргаар судалгаа хийж, уг 56 шүүгчээс асуулгын хариуг цуглуулан, дүгнэлт хийлээ. Энэ хүрээнд дараахь хариултыг өгсөн нь прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохтой холбоотой практик хэрэглээний талаар өмнөх судалгаатай нийцэж байна.

1. Прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс татгалзах үндэслэлийн талаар шүүгчдийн 54.5% нь “нэхэмжлэл гаргах эрхгүй”, 34.5% нь “төрийн байгууллагын хүсэлтгүй”, 5.5% нь “нэхэмжлэлийн шаардлага үндэслэл тодорхойгүй”, үлдсэн 5.5% нь “бусад үндэслэлээр” гэж хариулсан байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход итгэмжлэл шаардлагатай эсэх тухай асуултад 41.8% нь “төрийн байгууллагаас итгэмжлэл авах”, 43.6% нь “прокурорын газраас итгэмжлэл авах шаардлагатай” гэж хариулсан бол 14.5% нь “итгэмжлэлгүйгээр оролцох ёстой” гэж хариулсан.

3. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын эдлэх, эрх үүргийг нарийвчлах шаардлагатай эсэх талаар “тодорхой” гэж 68.5%, “Тодорхой бус” гэж 31.5% нь хариулсан байна.

4. Прокурорын нотлох баримт гаргах, бүрдүүлэхэд оролцож буй байдлын талаар шүүгчдийн 88.5% нь “прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо нотлох баримтыг хэргийн оролцогчийн хуулиар олгосон эрхийн хүрээнд бүрдүүлдэг” гэж хариулсан бол үлдсэн 11.5% нь “өөрөө бүрдүүлдэг” гэжээ.

5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох прокурорын эрх зүйн байдлын талаар шүүгчдийн 96.4% “Тодорхой болгох шаардлагатай” гэж нь үзсэн байна. Эрх зүйн байдлыг тодруулсан асуулгад 14.2% нь “гуравдагч этгээд” гэж, 29% хувь нь “нэхэмжлэгч” гэж, 56.8% нь “төрийг төлөөлөх эрхтэй этгээд”-20 гэж тус тус тодорхойлсон. Мөн төрийн байгууллага нэхэмжлэл гаргасан тохиолдолд “прокурор хамтран нэхэмжлэгчээр оролцох” гэж 41.3%, “Гуравдагч этгээдээр оролцох” гэж 58.7% нь хариулсан байна.

6. Шүүгчдийн 76.4% нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд “төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий прокурор” оролцдог гэжээ.

Дээрх асуулгын дүнгээс үзэхэд прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь “оролцогч”-ын эрх зүйн байдлыг тодруулах буюу ямар тохиолдолд нэхэмжлэгчээр, ямар тохиолдолд гуравдагч этгээдээр оролцохыг тодорхой болгох онолын төдийгүй практик хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Энэ нөхцөл байдлыг тодорхой болгох чиглэлээр прокурорын оролцох иргэний маргааны төрлийг хуулиар тодорхойлох шаардлагатай гэж оролцогчдын 60,7% нь хариулсан байх бөгөөд дараахь маргааны төрлийг нээлттэй асуулгын хүрээнд тодорхойлжээ. Үүнд: төрийн эрх ашиг зөрчигдсөн, төрд учруулсан хохирол төлүүлэх, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудал, гэрээний бус үүрэг, гэм хорын маргаан, эрүүгийн гэмт хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учирсан тохиолдолд, цагаатгалын нөхөн олговор, байгаль орчинд хохирол учруулсантай холбоотой, нийтийн эзэмшлийн хөрөнгөд халдсантай холбоотой, төрийн байгууллага татан буугдсан, эрх залгамжлагч байхгүй хохирлын хувьд, татвар, нийгмийн даатгал, төрөөс олгосон зээлийн гэрээний маргаанд, хөдөлмөрийн маргаан буюу цалин хөлстэй холбоотой маргаан.

Эдгээр төрлөөс зээлийн маргаан, гэрээний бус үүргийн зэрэг төрлийн хувьд хэргийн оролцогч тал нь төр, төрийн байгууллага биш байсан ч иргэний нэхэмжлэлээр хууль бус үйлдлийн шинжтэй асуудлууд хөндөгдөж болзошгүй тохиолдол сүүлийн жилүүдэд түгээмэл гарах болсон. Тухайлбал, хүчин төгөлдөр бус хэлцэл, эсхүл гэрээ, хэлцэлгүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө гаргуулахаар шаардаж буй шаардлагын хүрээнд хууль бус үйлдэл, авилга, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байж болзошгүй тохиолдлууд хэргийн оролцогчдын тайлбар, нотлох баримтуудад дурьдагдсан байх тохиолдол багагүй болсон.

Энэ тохиолдолд шүүх зөвхөн хэргийн оролцогчийн тайлбар, ТАТГалзлын хүрээнд хэргийн нөхцөл байдал хууль хэрэглээг тодорхойлон шийдвэрлэх эрхтэй бөгөөд гэмт хэрэг гарсан байж болзошгүй гэж үзэж хэргийг түдгэлзүүлэх, эрх бүхий байгууллагад мэдээлэл гаргах зэрэг ажиллагааг хөндлөнгийн байх зарчмын үүднээс хийх боломж бага байдаг. Энэ асуудал нь зөвхөн татвар, нийгмийн даатгал, гэрээний бус үүрэг, хөдөлмөрийн болон цалин хөлсний маргаанаар хязгаарлагдахгүй, гэрээтэй холбоотой маргаанд ч ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй асуудал хөндөгддөг. Мөн хэргийн оролцогч тал, түүний дотор төрийн байгууллагын зүгээс идэвхгүй байр суурьтай оролцох, өөрийн эсрэг тайлбар гаргах зэрэг үйлдлүүд гарах бөгөөд хэргийн оролцогч өөрөө чөлөөтэй эрх, үүргийн

хүрээгээ тодорхойлох зарчимд үндэслэн шүүх шийдвэрлэж байгаа боловч нэгэнт иргэний хэргийн маргаан болж шийдвэрлэгдэж дууссаны дараа хууль бус үйлдэл “хууль ёсны” мэт болж халхавчлагдах үр дагавар үүсэж болзошгүй. Иймд иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгчийн зүгээс прокурор оролцуулах шаардлагатай гэж үзсэн бол оролцох нөхцөл байдлыг хуульчлах шаардлагатай байж болох юм.

Иймд дээрх асуулгад тодорхойлон заасан дээрх маргааны төрлийн хүрээг гадаад улс орнуудын туршлагатай харьцуулан үзэж зөвлөмжид зарим хэсгээр тусгах боломжтой байна.

1.3. Үндэсний хууль тогтоомж, хэрэглээний талаар тойм дүгнэлт

Иргэний процессын оролцогчдын тэгш эрхийн зарчмын үүднээс Прокурорын тухай хуульд зааснаар прокурор бусад байгууллага, иргэнээс нотлох баримт гаргуулах асуудал юм. Жишээлбэл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хувьд зөвхөн шүүхийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажиллагааг хэргийн нэг оролцогч болж буй прокурор бие даан хэрэгжүүлэх эсэх нь эргэлзээтэй, эрх зүйн хэм хэмжээний зөрчилдөөн үүсгэж болзошгүй үр дагавартай.

Гадаадын улс орнуудын туршлагаас харахад прокурор нь тухайн салбараар илүү мэргэшсэн этгээд болох учир нотлох баримт бүрдүүлэх, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох зэрэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэжлийн үүднээс давуу байж болох боловч бусад оролцогчидтой адил тэгш эрх, үүрэг хэрэгжүүлэх хандлага байна.

Төрийн болон нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзэх шалгуур тодорхой бус, үүнтэй холбоотойгоор нэхэмжлэл гаргах болсон үндэслэлийг нотлоход хамаарах зүйл тодорхой хуульчлагдаагүйн улмаас прокурорын байгууллагын “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”-ын⁴⁶ хүрээнд зохицуулж байгаа нь хангалттай бус, нийтлэг эрх зүйн хэм хэмжээ болж чадахгүй юм. Учир нь нийтийн, хувийн, төрийн, нийгмийн зэрэг ашиг сонирхлын зааг ялгааг нарийвчлан зааглаж хуульчлаагүй өнөөгийн нөхцөлд хууль хэрэглэгчийн үзэмжээс хамааралтайгаар төрийн, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх асуудал тодорхойлогдож болзошгүй.

Прокурорын оролцоог иргэний процессын диспозитив зарчимтай уялдуулахдаа төрийн болон нийтийн эрх ашгийг төлөөлөх онцлогийг харгалзан зохигчоос хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрх,

⁴⁶ Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаал, 2021.04.09, А/47 “Аргачилсан заавар батлах тухай” “Дөрөвдүгээр бүлэг”

үүргийн зааг ялгааг нарийвчлан тодорхойлох шаардлагатай юм. Жишээлбэл, нэхэмжлэлээс татгалзах, эвлэрэн хэлэлцэх, нэхэмжлэлийг зөвшөөрөх, гомдол гаргах зэргийг тодорхойлох нь зүйтэй.

Мөн иргэний хэргийн хүрээнд нийтийн эрх ашиг зөрчигдөх, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал байгаа гэж үзвэл шүүгчийн санаачилгаар прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг нээх хэрэгцээ байна.

2. ГАДААД УЛС ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТУРШЛАГЫН ТАЛААР

Дээр дурдсан зохицуулалтуудыг нарийвчлах, процессжуулах ажиллагааны хүрээнд хамгийн гол хөндөгдөж буй асуудал болох нийтийн ашиг сонирхлыг хамгаалах прокурорын чиг үүрэг бусад орнуудад хэрхэн хэрэгждэг, прокурорыг иргэний процессын оролцогч байхыг зөвшөөрдөг эсэхтэй холбоотой судалгааны бүтээлүүд болон судлаачдын үзэл бодол, холбогдох хууль тогтоомжийн заалтыг судалж үзлээ.

Гадаад улс орнуудын туршлага судлах чиглэлээр ОХУ-ын хууль, БНХАУ, Казахстан Улсын холбогдох хуулиудыг ижил төстэй пост социалист орны хувьд, Япон, Солонгос зэрэг орны хувьд эрх зүйн тогтолцоо ижил төстэй, манай Улсын эдийн засгийн хөгжлийн хэв загвартай ойролцоо гэж үзсэн болно. АНУ, ХБНГУ-ын хувьд тусгайлсан хуулийн зохицуулалт багатай, германд нийтийн эрх ашгийн төлөөлөгч гэсэн агуулгаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байна. Иймд эдгээр орны хувьд чиг хандлага, судлаачдын байр суурийг судалгааны бүтээлээс судлав.

Дээрх улс орнуудын хууль тогтоомжийн агуулга, давуу болон сул тал, үндэсний тогтолцоонд хэрэгжих боломжтой эсэх талаар системчлэх үүднээс хүснэгтээр лавлагаа болгон судалгаанд хавсаргав. /Хавсралт 3/

ОХУ, АНУ, Япон, ХБНГУ дахь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор хэрхэн оролцдог буюу прокурорын оролцоотой холбоотой судалгаануудыг нэгтгэн үзэхэд “прокурор огт оролцох ёсгүй” гэсэн чиг хандлага харьцангуй суларсан бөгөөд зохих хэмжээгээр оролцдог байна.

А/ ЯПОН

Япон Улсын хувьд дэлхийн II дайны өмнө төрийн захиргааны байгууллагууд иргэний процесст харьцангуй бие даасан байдлаар оролцож байснаас гадна шүүхэд саналаа илэрхийлэх эрхтэй “нийтийн эрх

ашгийг хамгаалах зөвлөл” ажиллаж байсан. Үүнээс хойш 1947 онд АНУ-ын **attorney general** буюу ерөнхий прокурорын газартай төстэй тогтолцоо бий болгож, үүний хүрээнд төрийг шүүхэд төлөөлөх нэгдсэн тогтолцоотой болсон гэж судлаачид үзжээ.⁴⁷

Ийм тогтолцоотой болсноор засгийн газрын байгууллагууд шүүхийн процесст оролцох ачааллыг хөнгөлөх, хууль хэрэглээний практикийг нэг мөр болгох, маргааныг түргэн шуурхай, зүй зохистой шийдвэрлэхэд ахиц гарсан байна. Үүнд засгийн газрын байгууллагуудын процесст оролцоход хууль зүйн мэргэжлийн туслалцааг Хууль зүйн яам⁴⁸ үзүүлэх тул шүүхэд төлөөлөх газартай болж, иргэн, захиргаа, татварын зэрэг маргааны төрлөөр мэргэшсэн хэлтэс, шүүх байрладаг орон нутгийн салбартай байжээ.

Хууль зүйн яаманд харьяалагддаг прокурорууд багаар ажиллах, шүүгч нараас сэлгэн ажиллуулах зэргээр уг тогтолцоог хүний нөөцийг бэхжүүлснээр олон хэрэг, маргаанд үр дүнтэй оролцох боломжтой болсон гэж үздэг. Тухайлбал, 2016 онд 110 прокурор 20 мянга гаруй хэргийг хянан шийдвэрлэхэд оролцжээ.

Төрийн ашиг сонирхолд хамааралтай иргэний болон захиргааны хэрэг хянан шалгах ажиллагаанд прокурор оролцох үндэслэлийг хууль зүйн яам байгуулах тухай хууль⁴⁹, хууль зүйн сайдын эдлэх эрхийн тухай хууль⁵⁰ зэрэг хуулиудаар тодорхойлсон байна. Япон улсад захиргааны хэргийн дагнасан шүүх байхгүй тул иргэний процессын хүрээнд төрийн байгууллагатай холбоотой гомдол, маргаан шийдвэрлэдэг. Тухайлбал, төрийг төлөөлөн шүүхийн процесст оролцох нь бүхэлдээ Хууль зүйн сайд буюу Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул төр, иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцох прокурорыг сайд буюу ерөнхий прокурор томилж, түүний удирдлага, зааврын дагуу ажиллах, мөн өмгөөлөгч хөлслөх хүртэл эрхтэй байдаг.

Дараагийн нэг төрөл нь төр хэргийн оролцогч биш боловч нийтийн эрх ашигт их хэмжээний нөлөө үзүүлж болзошгүй шүүхийн процесст хууль зүйн сайд шүүхийн зөвшөөрөлтэйгөөр санал, байр сууриа илэрхийлэх эрхтэй

⁴⁷ Shigeo Kisa, *Shomu seido ni miru koukyo sei to houchi shugi* 1, 2, 1991[Public nature of and Rule of law in shomu (state attorney) system] *Hokudai hogaku ronshu* (Hokkaido University Law Review) 41(5-6), 361-392 (1) 42(1), 105-174 (2)

⁴⁸ <https://www.moj.go.jp/EN/hisho/soshiki/enkaku.html>

⁴⁹ 法務省設置に関する法律 [Houmushy Secchinikansuru houritsu]

⁵⁰ 法務大臣の権限に関する法律 [Houmu Daijinno Kengenni kansuru houritsu]

байсан нь орчин үед хумигдаж зөвхөн хэргийн оролцогч нь нийтийн эрх зүйн этгээд байгаа үед оролцох болсон.

Засгийн газрын байгууллага иргэний процесст зохигчоор оролцох үед тухайн байгууллага, эсвэл дээд шатны байгууллага нь шүүхэд төлөөлөх этгээдийг томилох, эсвэл өмгөөлөгч хөлслөн ажиллуулах эрхтэй боловч уг этгээдийг Хууль зүйн сайд буюу ерөнхий прокурор чөлөөлөх, өөрийн ажилтан болон өөр өмгөөлөгчийг оронд нь томилж ажиллуулах эрхтэй. Энэ зарчим орон нутгийн засаг захиргааны байгууллага төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэсэн асуудалтай холбоотой маргаан эсхүл тухайн орон нутгийн байгууллага Хууль зүйн сайдад хандан төлөөлөгч томилуулах хүсэлт гаргасан тохиолдолд мөн үйлчилдэг.

Дээрхийг тоймолбол, Япон улсад прокурорын тогтолцоо нь хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаардаг бөгөөд сайд нь Улсын Ерөнхий прокурорын чиг үүргийг гүйцэтгэдэгтэй холбоотой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн болон нийтийн эрх ашиг гэх ойлголтыг нэгдмэл байдлаар авч үздэг.

Дээр дурдсан төрийн болон нийтийн эрх зүйн этгээдийг төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцохоос гадна иргэний эрх зүйн харилцаа, түүний дотор өөрийгөө төлөөлөх чадваргүй буюу эрх зүйн чадамжгүй этгээдийн хууль ёсны төлөөлөгч томилох, иргэнийг сураггүй алга болсонтой холбоотой эд хөрөнгийн хамгаалалт тогтоох, цуцлах зэрэг ажиллагаанд прокурор Гэр бүлийн шүүхэд хүсэлт гаргах замаар оролцох талаар Иргэний хуульд тодорхойлсон байна. Энэ нь дээр дурьдсан нийтийн буюу төрийн эрх ашгийг төлөөлөх гэдгээс тусдаа иргэний эрх зүйн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх, иргэний эрх зүйн чадамж, иргэний эрх зүйн харилцаанд оролцох боломжийн талаар хуульчилсан.

Хэдийгээр прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээрх байдлаар оролцох боломжийг хуулиар нээсэн боловч тогтолцоо, бүтцийн хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлөн оролцох прокурорын үндсэн чиг үүргээс тусдаа болохыг хуульд Хууль зүйн сайд энэ чиглэлийн тусгайлсан нэгжтэй байх талаар тодорхой зааж чиг үүргийг салгасан шинжтэй байна.

Б/ СОЛОНГОС

Иргэний процессын хуулиар эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийнх нь эсрэг нэхэмжлэл гаргасан, эсхүл тухайн этгээд төлөөлөх эрхгүй болсон бол хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаа удааширснаар хохирол үүснэ гэж үзсэн дараах тохиолдолд нэхэмжлэл гаргах эрхтэй⁵¹. Үүнд хэргийн оролцогчийг төлөөлөх этгээд байхгүй, төлөөлөх этгээд байгаа боловч ашиг сонирхлын зөрчил болон мэдлэг туршлагагүйн улмаас төлөөлөх боломжгүй зэрэг тохиолдолд орон нутгийн захиргааны тэргүүн, эсхүл прокурор төлөөлөх эрх бүхий этгээдийг томилуулахаар шүүхэд хандах эрхтэй байна.

Иргэний хуулиар асран хамгаалагч тогтоох, төрөл садангийн холбоо тогтоох, хуулийн этгээдийг татан буулгагч томилох, сураггүй алга болсон, нас барсанд тооцох, эрх зүйн чадамжгүйд тооцох зэрэг хэд хэдэн асуудлуудад прокурорын хүсэлтээр үйл баримтыг тогтоох талаар заажээ⁵².

Түүнчлэн Прокурорын тухай хуулиар прокурорыг нийтийн эрх ашгийн төлөөлөгч болохын хувьд иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төр оролцож байгаа, эсхүл бусад хуулиар эрх олгогдсон тохиолдолд оролцох эрхтэй байна.⁵³

Ийнхүү оролцохдоо өргөн утгаараа нийтэд үйлчлэх гэсэн зарчмыг баримтлан улс төрийн хараат бус байдлаа хадгалан, эрхээ урвуулан ашиглах ёсгүй талаар тодотгон заажээ. Энэхүү нийтийн эрх ашгийн төлөөлөл болохын хувьд Засгийн газар хэргийн оролцогч болж байгаа иргэний хэрэгт шууд өөрөө, эсхүл төрийн албан хаагчийг чиглүүлэн удирдаж оролцдог байна. Үүний учир шалтгааныг прокурор нь төрийн байгууллагын оролцож буй хэрэгт хуулийн шинжээчийн хувьд оролцож чиглэл, заавар өгөх, шууд төлөөлөх эрх хэрэгжүүлдэг гэж судлаачид дүгнэжээ⁵⁴.

Дээрхээс гадна Иргэний хуульд заасан эрх зүйн чадамжгүй насанд хүрсэн этгээдийн асран хамгаалагч тогтоох, сураггүй алга болсон, үүсгэн байгуулагчгүй сангийн хөрөнгийн эрхлэн хамгаалагч тогтоох, хүүхдийн асрамж, тэтгэлэг тогтоох, эцэг, эх байх эрхийг хасах, төрөл садангийн холбоог үгүйсгэх зэрэг онцгой ажиллагааны журамд голлон хамаарах иргэний эрх зүйн асуудлаар прокурор оролцох талаар хуульчилснаараа Японтой төстэй байна.

В/ ОХУ

ОХУ-д прокурорын оролцоог үндсэн хуулиар тодорхойлогдсон хууль ёсыг бэхжүүлэх чиг үүрэгтэй нь холбон хуулиар хамгаалагдсан төрийн

⁵¹ Civil Procedure Code of Korea, art.62

⁵² Civil Act of Korea, Art.4 (1) 5-6

⁵³ Prosecutor's Office Act of Korea

⁵⁴ Lee, Jung-Soo, The Characteristics of the Korean Prosecution system and the Prosecutor's Direct Investigation, https://unafei.or.jp/publications/pdf/RS_No53/No53_13VE_Soo.pdf

болон нийгмийн ашиг сонирхол, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах гэсэн хүрээгээр тодорхойлж, прокурорын байгууллагыг нийтийн болон хувийн ашиг сонирхлыг иргэний шүүн таслах ажиллагаанд хамгаалах үүрэгтэй гэж зарим судлаачид үзжээ⁵⁵. Мөн хууль зүйн үйлчилгээний өндөр өртөгтэй нөхцөлд төлбөрийн чадваргүй иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахын тулд оролцох боломжтой гэж үзсэн.

ОХУ-ын үндсэн хуулийн 129 дүгээр зүйлээр прокурорын байгууллагын чиг үүргийг үндсэн хуулийг даган мөрдөж байгаа, хуулийн хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, мөрдөн шалгах болон бусад чиг үүрэгтэй байх өргөн хүрээгээр тодорхойлсон⁵⁶.

Иргэний процесст прокурорын оролцох оролцооны хувьд 1722 оноос эхлэн авч үзсэн бөгөөд эзэнт гүрний үед харьцангуй идэвхгүй үүрэг оролцоотой байсан.⁵⁷ Зөвлөлтийн үед төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах зорилтын хүрээнд иргэний процесст оролцох оролцоо хүчтэй болж, төрийн болон нийгмийн ашиг сонирхол, иргэний хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзвэл нэхэмжлэл гаргах болон бусад хэлбэрээр иргэний процессын аль ч шатанд оролцох, шүүхийн үндэслэлгүй шийдвэрийн талаар эсэргүүцэл гаргах эрхтэй байсан.

ОХУ-ын үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор прокурор нь иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах, мөн ОХУ, түүний субъект, нутгийн захиргааны ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд хандах боломжтой болсон. Прокурорын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Иргэний болон захиргааны шүүхэд иргэн, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдахаар бол хохирч буй этгээд эрүүл мэнд, нас болон бусад шалтгаанаар шүүхэд өөрийн эрхээ хамгаалан мэтгэлцэх боломжгүй бол, эсхүл хэт олон тооны иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн болон бусад нөхцөл байдлын улмаас нийгмийн онцгой ач холбогдолтой бол прокурор шүүхэд хохирч буй хүмүүсийн ашиг сонирхлын өмнөөс нэхэмжлэл гарган, дэмжиж оролцоно” гэж прокурорын чиг үүргийг тодорхойлсон байна.

Судлаачдын үзэж байгаагаар одоогийн байдлаар прокурорын иргэний шүүн таслах ажиллагаанд оролцох бүрэн эрхийн асуудлаар нэгдмэл

⁵⁵ Жуйков В. М. Принцип диспозитивности в гражданском судопроизводстве // Российская юстиция. 2003. № 7. С. 2-6.

⁵⁶ Конституция РФ ст.129

⁵⁷ Ференц-Сороцкий А.А. Прокурор в гражданском судопроизводстве // Известия высших учебных заведений. Правоведение. 1992. № 4. С. 91 - 95

хандлага тогтоогүй байна.⁵⁸ Иргэний процессын хуулийн 45 дугаар зүйлийн хүрээнд прокурор шүүхэд нэхэмжлэл гарган хандах эрхтэй бөгөөд иргэнийг төлөөлөн нэхэмжлэл гаргах тохиолдолд тухайн иргэн эрх зүйн чадамжгүй, эсхүл эрүүл мэнд, нас, бусад шалтгаанаар өөрөө шүүхэд хандах боломжгүй тохиолдолд ханддаг байна. Түүнчлэн, орон байрнаас нүүн гаргах, ажилд тогтоолгох, гэр бүл, хүүхэд хамгаалал, нийгмийн халамж, хамгаалалтай холбоотой асуудлаар тухайн иргэн хүсэлт гаргавал оролцож болдог байна.

Прокурор нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дүгнэлт гаргах хэлбэрээр оролцох бөгөөд хэргийн оролцогчийн адил эрх, үүрэгтэй байна. Мөн прокурор оролцоноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нэмэгдэх, удаашрал үүсгэхгүй байх үүднээс прокурор шүүхэд ирээгүй нь ажиллагааг явуулахад саад болохгүй байхаар заажээ⁵⁹.

Төр, нийтийн ашиг сонирхол гэдгийг төрийн төдийгүй нийгмийн эмзэг бүлэг, эрх, эрх чөлөөгөө бие даан өөрөө хамгаалах боломжгүй этгээд гэсэн хүрээгээр тодорхойлсон байна.

Г/ КАЗАХСТАН

Прокурор иргэний процесст үндсэн гурван хэлбэрээр оролцдог. Үүнд: 1/ төрийн ашиг сонирхол болон бүлэг, хэсэг /нийтийн/ этгээдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах, 2/ иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад бусад этгээдийн санаачилгаар дүгнэлт гаргах зорилгоор, 3/ шүүхийн шийдвэрийг дахин хянуулахаар эсэргүүцэл гаргах⁶⁰.

Прокурорын хамгаалан оролцох нийтийн эрх, ашиг сонирхол гэдгийг нийтийн орон байр болон бусад нийгмийн хамгааллын хүрээнд хамааруулан тодотгосон байх бөгөөд ашиг сонирхол нь хөндөгдөж буй хүмүүсийн хүсэлт, өргөдөл заавал шаардлагагүй, прокурор бие даан гаргах эрхтэй байдаг байна. Үүнээс гадна эрх зүйн чадамжгүй, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийгөө төлөөлөн оролцох боломжгүй этгээдийн хүсэлтээр прокурор оролцдог байна. Үүнийг төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцооны хүрээ хязгаарлагдмал байдагтай холбоотойгоор прокурор хууль зүйн туслалцааг үзүүлж буй хэлбэр ч гэж тодорхойлсон байна.⁶¹

⁵⁸ Исаенкова О. В., Григорьев А. Н. Участие прокурора в исковом производстве // Арбитражный и гражданский процесс. 2008. № 3. С. 6-10.

⁵⁹ Гражданский процессуальный кодекс РФ, ч3. ст45

⁶⁰ Гражданский процессуальный кодекс РК

⁶¹ К.В.Тулеутаевна, Роль и формы участия в гражданском процессе в контексте нового Гражданского процессуального кодекса.

Төрийн болон нийгмийн ашиг сонирхол хамгаалан оролцох тохиолдолд нэхэмжлэлд тавигдах шаардлагыг нарийвчлан хуульчилсан байх бөгөөд төр, нийгмийн ямар ашиг сонирхол зөрчигдөж байгааг, хэрэглэгдэх хуультай нь хамт заахыг шаарддаг байна.⁶² Иргэний хэрэг үүсгүүлэхээр прокурор хандах хүрээг хуулиар эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлах, олон нийтийн байгууллагын сонгууль, төрийн байгууллагын шийдвэрийн талаар гомдол гаргах, иргэнийг нас барсан, сураггүй алга болсонд тооцох, албадан эмчилгээнд хамруулах, хүүхдийг асрамждаа буцаан авах, уулзуулахыг даалгуулах зэргээр харьцангуй өргөн хүрээнд тодорхойлсон байна.

Мөн шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар эсэргүүцэл бичих эрхтэйгээр оролцдог байна. Эдгээр прокурорын оролцооны хүрээ өргөн байгааг, түүнчлэн хяналтын чиг үүрэгтэйгээр оролцож байгааг судлаачдын зүгээс шүүмжлэлтэй хандаж байна.

Д/ БНХАУ

БНХАУ-ын Иргэний процессын хууль 2017 онд шинэчлэн батлагдсан бөгөөд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих эрхийг хэвээр хадгалан хуульчилжээ.⁶³ Хуулиар эрх олгогдсон этгээд байгаль орчныг бохирдуулах зэргээр нийтийн эрх ашиг зөрчиж буй, мөн олон тооны хэрэглэгчийн эрх ашгийг зөрчиж буй асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй талаар зааж энэ тохиолдолд хүнсний, болон эмийн аюулгүй байдал, байгаль орчин, нөөц баялагт хохирол учруулж байна гэж үзвэл прокурор нэхэмжлэл гаргах, эсхүл нэхэмжлэл гаргасан байгууллагыг батламжлан оролцох эрхтэй байхаар заажээ⁶⁴.

Түүнчлэн, хэргийн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулах асуудалд прокурорын оролцоо чухал үүрэгтэй байна.⁶⁵ БНХАУ-ын хувьд төрийн тогтолцоо талаасаа социалист хэв маягтай хэвээр байгаа тул иргэний хэрэгт прокурор хяналт тавих гэсэн агуулгыг ерөнхий байдлаар тусгасан боловч хэргийн оролцогч гэсэн хэсэгт оролцоогүй, энэхүү хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг нийтийн эрх ашгийг төлөөлөн оролцох, иргэний хэргийн шинээр илэрсэн нөхцөлөөр дахин хянах тохиолдлоор нарийвчлан зохицуулсан гэж үзэхээр байна. Энэ нь прокурорын хяналтын чиг үүрэгтэй илүү холбоотой болохыг харуулж байна.

⁶² ч.3ст.148 ГПК РК

⁶³ Civil Procedure Law of the People's Republic of China, Art.1

⁶⁴ Civil Procedure Law of the People's Republic of China, Art.55

⁶⁵ Civil Procedure Law of the People's Republic of China, Art.185-188

Е/ ХБНГУ

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний процессын тухай хуульд прокурорыг хэргийн бие даасан оролцогч гэж заагаагүй байна. Түүхэн талаасаа нийтийн эрх ашгийг иргэний процесст төлөөлөхөд пруссын болон өмнөд германы гэсэн хоёр үндсэн хэв маяг бүхий оролцоо байсан гэж үзжээ.⁶⁶ Пруссын хэв маягийн хувьд шүүхэд нийтийн эрх ашгийг төлөөлөх байнгын үйл ажиллагаа бүхий бүтэц байхгүй, холбогдох захиргааны байгууллагын төлөөлөгч, эсвэл тухайн салбарын сайд, мужийн захирагчийн тушаалаар прокурор нийтийн эрх ашгийг төлөөлөх эрхтэй байжээ.

Харин Өмнөд Германы хэв маяг бүхий төлөөллийн тогтолцооны жишээ нь Бавар мужийн захиргааны шүүхийн дэргэд нийтийн эрх ашгийг төлөөлөх байнгын бүтэц юм. Захиргааны хэрэгт хариуцагч байхгүй, зөвхөн нэхэмжлэгч тухайн тодорхой шийдвэрийн эсрэг гомдол гаргадаг байсан учир уг бүтцийн хүрээнд томилогдсон ахлах прокурор нийтийн эрх ашиг болон төрийн эрх ашгийг адил гэж үзэж саналаа хэлэх эрхтэй байв.

Дэлхийн II дайны дараа Баварын захиргааны хэргийн шүүх хоёр шаттай болж, прокурор нь нийтийн эрх ашгийг төлөөлөх, муж улсыг шүүхэд төлөөлөх, төрийн албан хаагчийн сахилгын зөрчлийн хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргах зэрэг хэлбэрээр оролцдог байна.

Энэхүү төлөөлөх ажиллагаанд баримтлах журмууд нь зарим онцлогтой хэрэгждэг. Тухайлбал, муж улсын захиргааны байгууллагыг төлөөлөх этгээд нь прокурор байх боловч нийтийн эрх ашгийг захиргааны байгууллага зөрчсөн зэрэг тохиолдолд нэхэмжлэгчид ашигтай үйлдэл хийх үүрэгтэй эсэх асуудал хөндөгддөг. Өөрөөр хэлбэл, төр, төрийн байгууллагын үйл ажиллагаа нийтийн эрх ашигтай зөрчилдөх үед алийг нь төлөөлөх эсэх талаар диллема үүсэж болзошгүй гэж үздэг байна.

Нийтийн эрх ашгийг төлөөлөх прокурор ихэвчлэн захиргааны ажлын туршлагатай, хуульчид тавигдах шаардлага хангасан, зарим тохиолдолд захиргааны хэргийн шүүгчээр ажиллаж байсан хүмүүс байхаас гадна эдгээр прокурорууд дотроос захиргааны хэргийн шүүгчээр томилогдох нь түгээмэл байна. Харин Японоос ялгаатай нь энэ төрлийн прокурорууд нь эрүүгийн хэргээр мэргэшсэн байх шаардлагагүй байна.

⁶⁶ Shigeo Kisa, *Shomu seido ni miru koukyo sei to houchi shugi* 1, 2, 1991[Public nature of and Rule of law in shomu (state attorney) system] *Hokudai hogaku ronshu* (Hokkaido University Law Review) 41(5-6), 361-392 (1) 42(1), 105-174 (2)

Шүүхэд нийтийн эрх ашгийг төлөөлөх шаардлагатай хэрэг гэдэгт гол төлөв орон нутгийн захиргаа, төмөр зам, шуудангийн үйлчилгээтэй холбоотой хэргүүд байх бөгөөд прокурор оролцох эсэхээ өөрөө бие даан шийдвэрлэдэг. Эдгээр прокуроруудыг нийтийн эрх ашгийн төлөөлөгч / *vertreter des oeffentlichen interesses* /, холбооны нийтийн эрх ашгийг төлөөлөх прокурор / *oberbundesanwalt* / зэргээр нэрлэдэг бөгөөд цагаачлалын асуудлаарх хариуцагч, маргаантай бус хэргийн шүүхийн процесс (гэр бүлийн гэх мэт) зэрэгт нийтийн эрх ашгийг төлөөлөх прокуророос гадна (бавари муж зэрэг), захиргааны омбудсмэн, цэргийн омбудсмэн, байгаль орчныг хамгаалах байгууллага, төрийн аудит, санхүүгийн аудит зэрэг субъектуудыг захиргааны шүүхийн процессын хуульд зааснаар⁶⁷ бусдын эрх ашгийг төлөөлөн оролцдог байна.

Холбооны захиргааны шүүхийн дэргэд ажиллах *Oberbundesanwalt* хэмээх холбооны эрх ашгийн төлөөлөгч нь холбооны засгийн газарт захирагдах бөгөөд хүссэн шүүх хуралдаа оролцох, саналаа хэлэх эрхтэй, мэргэжлийн хувьд шүүгчид тавигдах шаардлагыг хангасан этгээд байдаг.

Муж улсууд (*Landes*) өөрийн захиргааны хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн дэргэд нийтийн эрх ашгийн төлөөлөгчийг томилж болох бөгөөд эдгээр нь өөрийн хүслээр аль ч хэргийн оролцогч, зохигчоор оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй бөгөөд нэгэнт оролцсон бол түүний зөвшөөрөлгүйгээр нэхэмжлэл, давж заалдсан гомдлоо бусад этгээд татах эрхгүй байдаг байна.

Холбооны нийтийн эрх ашгийг төлөөлөх прокурор нь “Холбооны захиргааны хэргийн шүүхэд нийтийн эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” чиг үүрэгтэй бөгөөд түүнд “холбооны бүгд найрамдах улсыг төлөөлөх эрхийг олгохгүй” тул холбооны улс буюу түүний захиргааны байгууллагыг төлөөлөх бус, харин шүүх хуралд оролцож нийтийн эрх ашгийн талаар хөндлөнгийн байр сууринаас саналаа хэлэх үндсэн чиг үүрэгтэй.

Түүнчлэн, аль нэг холбооны сайдад захирагдахгүй, гагцхүү холбооны засгийн газрын хуралдаанаар гаргасан шийдвэрт захирагдах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор холбооны яам, агентлаг гэх мэт захиргааны байгууллагыг захиргааны хэргийн шүүхэд ихэвчлэн тухайн байгууллагын ажилтан төлөөлдөг.

⁶⁷ Code of Administrative Court Procedure

Ё/ АНУ

Холбооны прокурорын зарчимд иргэний хэрэгт прокурор орох асуудлыг АНУ-ын эсрэг гаргасан нэхэмжлэл бүхий хэрэг, гэм хор, цагаачлал, хэрэглэгчийн эрх хамгаалах, санхүүгийн маргаан, шийдвэр албадан гүйцэтгэх зэрэг 11 төрлийн маргаанд оролцохоор тодорхойлж, түүнд оролцох прокурор, туслах прокурор зэрэг этгээдийн эрх үүрэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчмыг нарийвчлан тодорхойлсон байна⁶⁸. Мөн муж улсуудын түвшинд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалал /хүний эрх/, дампуурал, дуудлага худалдаа зэрэг асуудлаар оролцох боломжтой. Ийнхүү оролцохдоо шүүгчийн шийдвэрээр оролцох жишиг түгээмэл байна. Энэхүү прокурорын оролцоог нотолгооны үүргийг илүү мэргэшсэн түвшинд гүйцэтгэх чадвартай, нийтийн эрх ашгийг хамгаалах субъект болох талаас нь тайлбарлажээ⁶⁹.

2.2. Гадаад Улсын хууль тогтоомж, туршлагын тойм дүгнэлт

Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход төлөөлөх ашиг сонирхлыг “төрийн”, “нийтийн”, “нийгмийн” гэсэн ялгаатай байдлаар томьёолсон байна.

Дээрх улс орнуудын хууль тогтоомж, тэдгээрийн онолын тайлбаруудыг судалсныг тоймлон авч үзвэл юуны түрүүнд төрийн, эсхүл нийтийн ашиг сонирхол дараах төрлийн хэргүүдэд хөндөгдөх тул прокурор төлөөлөн оролцдог байна⁷⁰. Үүнд:

- Хүүхэд хамгаалал зэрэг “нийгмийн тодорхой хэсэг бүлэг”-т хамаарах хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлууд;
- Гэр бүлийн хүчирхийлэл, иргэний хэргийн оролцогч нь гэмт хэргийн хохирогч болсны улмаас өөрөө бие даан иргэний процесст оролцож эрхээ хамгаалах боломжгүй;
- Төрийн эрх ашиг буюу төрийн байгууллага, төр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдол;
- Хуурамч болон санаатай дампуурал;
- Нийтийн дуудлага худалдааны зөрчил;
- Иргэний хэрэг шийдвэрлэх явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй байж болзошгүй тохиолдол.

⁶⁸ Principles of Federal Prosecution

⁶⁹ Alan Vinegrad, The Role Of The Prosecutor: Serving The Interests Of All The People, 1999

⁷⁰ National Research Council. What's Changing in Prosecution/ Report of a Workshop. Washington, DC/ 2001, The National Academies Press. pp.17-21

Дээрх тохиолдлуудад прокурор иргэний процесст оролцох шаардлагыг онолын хувьд нотолгооны ач холбогдол өндөртэй, мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд нотлох боломж бүрддэг гэж үзжээ. Дээр дурдсан тохиолдлуудаас гадна гэмт хэргийн улмаас үүссэн үр дагавар, хохирлыг нөхөн төлүүлэх, үндэслэлгүй хөрөнгөжилтийг буцаах зэрэг тохиолдолд тухайн салбараар мэргэшсэн этгээд болох прокурор оролцох нь зохистой гэж үзэх хандлага байна.

Дээр дурдсан нийтлэг үндэслэлүүдээс гадна гэм хорын нэхэмжлэлээр хариуцлага ногдуулахтай холбоотой асуудалд прокурорын оролцоо зохих хэмжээнд байж болох талаар судлаачид авч үзжээ. Жишээлбэл, прокурорын хувьд тухайн салбарын асуудлаар илүү мэргэшсэн байдал нь иргэний хэрэг үүсгэх үндэслэл зэргийг тодорхойлоход ач холбогдолтой байх боловч бусад оролцогчдоос давуу эрх эдлэхгүй гэдэг үзэл баримтлал байдаг.

Оролцооны хэлбэрийн хувьд бусад оролцогчийг яллах зорилгогүй байх, прокурорт, прокурорын байгууллагад ямар нэгэн иргэний эрх, үүрэг үүсгэхгүй. Тухайлбал, тодорхой мөнгөн хөрөнгө гаргуулах, даалгуулах зэрэг нэхэмжлэлийн хувьд прокурорын болон прокурорын байгууллагын хувийн буюу субъектив эрхтэй хамааралгүй байх юм.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа буюу хувь этгээдүүдийн хоорондоо, бие биедээ хандан гаргаж буй зөвхөн өөрт хамааралтай эрхийн зөрчлийг сэргээхэд чиглэсэн диспозитив зарчимд үндэслэн явагддаг ажиллагаанд прокурорын оролцоо нь онцгой тохиолдол дүрмийн бус байдаг. Иймд зөвхөн хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэгт оролцох ёстой гэсэн зарчим улс орнуудад нийтлэг байна. Өөрөөр хэлбэл, хуулиар прокурорын оролцож болох хэрэг маргааны төрөл буюу төрийн болон нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэдэгт ямар ямар хэргийн төрөл байхыг нарийвчлан зохицуулах хандлага байна.

Солонгос, Япон, ОХУ-д эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай холбоотой төлөөлөх эрх бүхий этгээдийнх нь эсрэг нэхэмжлэл гаргасан, эсхүл тухай этгээд төлөөлөх эрхгүй болсон зэрэг тохиолдолд прокурор оролцох, асран хамгаалагч тогтоох, төрөл садангийн холбоо тогтоох, хуулийн этгээдийг татан буулгагч томилох, сураггүй алга болсон, нас барсанд тооцох, эрх зүйн чадамжгүйд тооцох зэрэг хэд хэдэн асуудлуудад прокурорын хүсэлтээр үйл баримтыг тогтоох талаар Иргэний хуулиар зохицуулсан байна. Ийнхүү оролцоходоо өргөн утгаараа нийтэд үйлчлэх гэсэн зарчмыг баримталсан байна.

Мөн ОХУ-д прокурорын оролцооны хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нэмэгдэх, удаашрал үүсгэхгүй байх үүднээс прокурор шүүхэд ирээгүй нь ажиллагааг явуулахад саад болохгүй байхаар заасныг анхаарах хэрэгтэй.

БНХАУ-ын хувьд төрийн тогтолцоо талаасаа социалист хэв маягтай хэвээр байгаа тул иргэний хэрэгт прокурор хяналт тавих гэсэн агуулгыг ерөнхий байдлаар тусгасан боловч хэргийн оролцогч гэсэн хэсэгт бус шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хүчингүй болгуулах агуулгатай байхаар хуульчилсан нь аль ч улсад байхгүй жишиг байна.

Япон Улсын Хууль зүйн сайд буюу Ерөнхий прокурорын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул төр, иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцох прокурорыг сайд буюу ерөнхий прокурор томилж, түүний удирдлага, зааврын дагуу ажиллах, мөн өмгөөлөгч хөлслөх хүртэл эрхтэй байдгийг анхаарах. Хэдийгээр прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээрх байдлаар оролцох боломжийг хуулиар нээсэн байгаа боловч тогтолцоо, бүтцийн хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийг төлөөлөн оролцох прокурорын үндсэн чиг үүргээс тусдаа байлгаж буй Японы туршлагыг анхаарах шаардлагатай байж болох юм.

3. ЗӨВЛӨМЖ

Үндэсний болон гадаад улс орнуудын хууль тогтоомж, туршлагад үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль болон бусад хуульд оруулах өөрчлөлтийн талаар дараахь зөвлөмжийг гаргаж байна.

1. Прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүрээ, эрх хэмжээний асуудлыг тодорхой болгох чиглэлээр

а/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон прокурорын тухай хуулийн талаар

Хуулиар прокурорын оролцож болох хэрэг маргааны төрөл буюу төрийн болон нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэдэгт ямар ямар хэргийн төрөл байхыг ерөнхийлөн тодорхойлж, түүнд хамаарах шалгуурыг хуульд нэмж тусгах саналтай.

Япон, Солонгос, ОХУ-д иргэний эрх зүйн чадамж, асрамж, тэтгэлэг зэрэг асуудлаар иргэний эрх ашиг прокуророор төлөөлж болохоор заасан байх боловч Монгол Улсын Иргэний хууль, иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эдгээр асуудал дахь төлөөлөл тодорхой тул прокурорын оролцоо шаардлагагүй гэж үздэг.

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл, Прокурорын тухай хуулийн 17.1.3-т “төрийн нэрийн өмнөөс оролцох” гэснийг “төрийг төлөөлөн оролцох” гэж өөрчлөх,
- “Төрийг төлөөлж оролцох” үндэслэлийг тодорхой хуульчлах. Тухайн асуудлыг харьяалсан төрийн байгууллага байхгүй, эсхүл тухайн байгууллага нь нэхэмжлэл гаргаагүй, нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчилтэй гэх зэргээр оролцох урьдчилсан нөхцөлийг тодруулсан заалт нэмэх. Ингэснээр төрийн байгууллагатай давхцалгүй байх, мөн прокурор оролцох шаардлагатай үед оролцохгүй байх хийдлийг арилгана.
- Нийтийн эрх ашгийг төлөөлөх гэдгийг “хүрээлэн байгаа орчныг хамгаалах”, “байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх”, “төрийн өмчийн зүйлтэй холбоотой маргаан”, “төрөөс төлөх нөхөн төлбөр, олговор гаргуулах” болон хуульд нийтийн эрх ашиг учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан боловч нэхэмжлэл гаргах этгээдийг тодорхойлоогүй тохиолдолд гэж тодруулах,
- Төрийн байгууллага өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа /нэхэмжлэгч, хариуцагч/ боловч прокурор оролцуулах хүсэлтээр орох тохиолдолд гуравдагч этгээдийн хувиар, харин өөрийн санаачилгаар оролцох тохиолдолд нэхэмжлэгчээр оролцох талаар тодорхой заах;
- Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 Дахь хэсэгт “Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй” гэж, 20.3 Дахь хэсэгт “Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэж тодотгон хуульчилсныг зөв тайлбарлан хэрэглэхэд асуудал үүсэхгүй. Гэвч хэргийн бусад оролцогчоос давуу

эрх эдлэхгүй, яллах чиг үүрэг байхгүй талаар бусад Улсын нэгэн адил хуульчлах шаардлагатай байж болох юм. Тодруулбал, прокурор хэргийн оролцогчийн адил эрх эдэлнэ гэж заасан боловч нэхэмжлэл, тайлбар гаргах, нотлох баримт бүрдүүлэх, үнэлэх ажиллагаанд адил тэгш эрхтэй оролцох талаар заах. Энэ нь иргэний хэрэгт яллах зорилгогүй байхыг тодруулах ач холбогдолтой.

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5.3-т заасан хориглолтод 31 дүгээр зүйлд заасан журмын дагуу оролцох тохиолдол хамаарахгүй болохыг тодорхой заах.
- Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт эсхүл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд прокурорын нэхэмжлэлд тавигдах нэмэлт шаардлага оруулах. Тухайлбал, төрийн болон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн оролцох үндэслэлийг тодорхойлох гэж нэмж оруулах. Аргачлалын хүрээнд зохицуулж байгаа нь хангалтгүйгээс гадна процессын журмын хуулиар бус зохицуулах хэрэгтэй.
- Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл, тайлбар гаргах” тухай зохицуулалт нь “Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр” гэсэн дөрөвдүгээр бүлэгт орсон байна. Зөрчлийн болон эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэг бүхий прокурор иргэний нэхэмжлэл, тайлбар гаргах хэлбэрээр ямар үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг тодорхой болгох шаардлага байна. Үүнийг прокурорын хяналтын уламжлалт ойлголтоос ялган өөрөөр томъёолох шаардлагатай байж болох юм.
- Прокурорын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-Д “Прокурор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх арга хэмжээ авна” гэж, 20 дугаар зүйлийн 20.4-т “Прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцоно” гэсэн заалтуудтай холбоотойгоор УЕП-ын баталсан удирдамж, зааварт заасан эрх хэмжээний хүрээнд гэдгийг Прокурорын тухай хуульд тодруулж заах.

2. Нийтийн болон төрийн ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй бусад хуулийн хүрээнд нэхэмжлэл гаргах асуудлыг тодруулан хуульчлах талаар

а/ Төсвийн тухай хуулийг зөрчсөнөөс төрд учирсан хохирлыг арилгуулах нэхэмжлэл гаргах эрхийн талаар зохицуулалт байхгүй байна. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4, 60.3.5-д заасны дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа”, “зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах, зарцуулахыг хориглох”-оор заасан. Үүнээс үүссэн хохирлыг барагдуулах, эдгээр хэлцлийн хүчин төгөлдөр байдлын талаар тухайн байгууллага маргаан үүсгээгүй тохиолдолд төрд учруулсан хохирлыг нэхэмжлэл этгээдийг заагаагүй байна.

б/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4 дэх заалтад “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ” гэсэн ерөнхий байдлаар тодорхойлсон. 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хохирлыг барагдуулахаар нэхэмжлэл гаргах талаар зохицуулалт байхгүй байна. Иймд тодруулан заах.

в/ Байгаль орчныг хамгаалах хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” эрхийг төрийн бус байгууллага эдлэхээр заасан. Энэ хүрээнд төрийн бус байгууллагаас нэхэмжлэл гаргах тохиолдолд хохирлыг “хэн”-д гаргуулан олгох нь тодорхой бус байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсан тохиолдол гарсан.

Энэ тохиолдолд Засгийн газрын тусгай сангаар дамжуулан төсөвт оруулах байдлаар өөрчлөлт оруулах, үүнтэй холбоотой прокурор гуравдагч этгээдээр оролцох шаардлага үүсэж болох юм. Жишээлбэл, Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлээр төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах журмыг тодорхойлохдоо 25.1.1-т “ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм

буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” тодорхойлсон байх бөгөөд энэ тохиолдолд хохирлын нөхөн төлбөрийг шилжүүлэх газар нь тодорхой байна.

г/ Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлээр амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тодорхойлж, 37.1 дэх хэсэгт “Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж заасан бөгөөд уг нэхэмжлэлийг гаргах, төсвийн сангийн талаар тодорхой бус байх тул прокурор төлөөлөхөөр заах.

д/ Авлига, ашиг сонирхлын зөрчил, төсөвт учруулсан хохирлыг барагдуулах талаарх хуулийн заалтыг тодруулах

е/ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл, 52 дугаар зүйл, 10 дугаар зүйлүүдэд хяналт шалгалт хийх нийтлэг журам, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх журам, мэргэжлийн хяналтын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг тодорхойлохдоо нийтийн эрх ашигт хохирол учруулсан байх нөхцөлийг тодорхойлсон байна. Үүнтэй холбоотойгоор авах зөрчлийн арга хэмжээг тодорхойлсон боловч хохирол нөхөн төлүүлэх асуудал тодорхой бус байна.

3. Шүүгчийн санаачилгаар прокурорыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах зохицуулалт нэмэх талаар

Зээлийн маргаан, гэрээний бус үүргийн зэрэг төрлийн хувьд хэргийн оролцогч тал нь төр, төрийн байгууллага биш байсан ч иргэний нэхэмжлэлээр хууль бус үйлдлийн шинжтэй асуудлууд хөндөгдөж болзошгүй тохиолдол сүүлийн жилүүдэд түгээмэл гарах болсон. Тухайлбал, хүчин төгөлдөр бус хэлцэл, эсхүл гэрээ, хэлцэлгүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг үндэслэлгүй хөрөнгөжсөн гэх үндэслэлээр гаргуулахаар шаардаж буй маргаанд хууль бус үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байж болзошгүй тохиолдлууд хэргийн оролцогчдын тайлбар, нотлох баримтуудад дурьдагдсан байх тохиолдол багагүй гарах болсон.

Энэ тохиолдолд шүүх зөвхөн хэргийн оролцогчийн тайлбар, татгалзлын хүрээнд хэргийн нөхцөл байдал иргэний эрх зүйн маргаанд хамааралтай үйл баримтыг тогтоох хууль хэрэглээг тодорхойлж, шийдвэрлэх эрхтэй бөгөөд гэмт хэрэг гаргаж болзошгүй гэж үзэж хэргийг түдгэлзүүлэх, эрх бүхий байгууллагад мэдээлэл гаргах зэрэг ажиллагааг хөндлөнгийн байх зарчмын үүднээс хийх боломж байхгүй.

Мөн хэргийн оролцогч тал, түүний дотор төрийн байгууллагын зүгээс идэвхгүй байр суурьтай оролцох, өөрийн эсрэг тайлбар гаргах зэрэг үйлдлүүд гарах тохиолдол байдаг. Хэргийн оролцогч өөрөө чөлөөтэй эрх, үүргийн хүрээгээ тодорхойлох зарчимд үндэслэн шүүх шийдвэрлэж байна. Үүний улмаас нэгэнт иргэний хэргийн маргаан болж шийдвэрлэгдэж дууссаны дараа хууль бус үйлдэл “хууль ёсны” мэт болж халхавчлагдах үр дагавар үүсэж болзошгүй. Иймд иргэний хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгчийн зүгээс прокурор оролцуулах шаардлагатай гэж үзсэн бол оролцох нөхцөл байдлыг хуульчлах шаардлагатай байж болох юм.

Энэ асуудал нь зөвхөн татвар, нийгмийн даатгал, гэрээний бус үүрэг, хөдөлмөрийн болон цалин хөлсний маргаанаар хязгаарлагдахгүй, гэрээтэй холбоотой маргаанд ч ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй асуудал хөндөгддөг. Энэ тохиолдолд шүүгч өөрийн санаачилгаар прокурор оролцуулах боломжийг нээх.

Хавсралт

ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГАА

д/д	Хуулийн нэр	Заалт	Нэмэлт өөрчлөлтийн санал
1	Прокурорын тухай хууль	17 дугаар зүйл.Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох 17.1.3. захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх.	- “төрийн нэрийн өмнөөс оролцох” гэснийг “төрийг төлөөлөн оролцох” гэж өөрчлөх
		20 дугаар зүйл.Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах 20.1. Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно.	- Байхгүй.
		20.2. Прокурор нь төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа явуулах, иргэн, байгууллага, албан тушаалтнаас холбогдох баримт, мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авах эрхтэй. 20.3. Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.	- Прокурор иргэний хэргийн бусад оролцогчоос давуу эрх эдлэхгүй, яллах чиг үүрэг байхгүй талаар бусад Улсын нэгэн адил хуульчлах шаардлагатай.
		20.4. Прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцоно.	- УЕП-ын баталсан удирдамж, зааварт заасан эрх хэмжээний хүрээнд гэдгийг Прокурорын тухай хуульд тодруулж заах.

2	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	<p>25. Хэргийн оролцогчийн эрх, үүрэг</p> <p>26. Зохигч</p> <p>38. Нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх</p> <p>31 дүгээр зүйл. Прокурор, бусдын эрхийг хамгаалж байгаа этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох</p> <p>31.1. Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно.</p> <p>31.2. Бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу оролцож болно.</p> <p>31.3. Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос, эсхүл гаргасан нэхэмжлэлээсээ тАТГалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй.</p> <p>36 дугаар зүйл.Төлөөлөгчийн бүрэн эрх, төлөөлөн оролцож болохгүй байдал</p> <p>36.5.3. өөрөө иргэнийхээ хувьд түүнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар буюу ажиллаж байгаа байгууллагаа төлөөлөн тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаагаас бусад тохиолдолд шүүгч, прокурор, мөрдөгч.</p>	<p>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд прокурорын нэхэмжлэлд тавигдах нэмэлт шаардлага оруулах.</p> <p>“төрийн нэрийн өмнөөс оролцох” гэснийг “төрийг төлөөлөн оролцох” гэж өөрчлөх</p> <p>36.5.3-т заасан хориглолтод 31 дүгээр зүйлд заасан журмын дагуу оролцох тохиолдол хамаарахгүй болохыг тодорхой заах</p>
---	---	--	---

3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	<p>20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг</p> <p>1.8/. маргаантай асуудлаар үйлдвэрийн газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;</p> <p>5/. Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.</p> <p>31 дүгээр зүйл. Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах</p> <p>5/ осол, гэмтэл гарсан шалтгааныг тогтоож, хэрэв тодорхой этгээдийн буруугаас уг осол, гэмтэл гарсан бол Иргэний хуульд заасан журмаар хохирлыг арилгуулах</p> <p>73 дугаар зүйл. Эд хөрөнгийн тооллого явуулах журам</p> <p>4/ үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ.</p>	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хохирлыг барагдуулахаар нэхэмжлэл гаргах талаар зохицуулалтыг тодруулан заах
---	--	---	---

		<p>41 дүгээр зүйл.Прокурорын нэхэмжлэл, тайлбар, гомдол</p> <p>41.1. Төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл, тайлбар, гомдол гаргана.</p> <p>41.2.Прокурорын нэхэмжлэл, тайлбар, гомдол нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлага хангасан байна.</p>	<ul style="list-style-type: none"> - 41.2-т прокурорын нэхэмжлэлд тавигдах нэмэлт шаардлага оруулах. - Прокурор иргэний нэхэмжлэл, тайлбар гаргах хэлбэрээр ямар үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг тодорхой болгох шаардлагатай.
4	Байгаль орчныг хамгаалах хууль	<p>32 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох</p> <p>32.1. 1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p> <p>49 дүгээр зүйл.Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх</p> <p>1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг Байгаль орчин, уур амьсгалын сангаас буцаан олгоно.</p> <p>8.Нөхөн төлбөрийг ногдуулсан байгаль орчны хяналтын Улсын байцаагч ажлын 14 хоногт багтаан тухайн төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд уг хугацаанд барагдуулаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.</p>	

5	Төрийн аудитын тухай хууль	<p>36 дугаар зүйл.Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн хэрэгжилтийг мэдээлэх</p> <p>36.1. Төрийн аудитын байгууллага тухайн жилд Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүр Үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршуулна.</p>	<p>- Төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг нэхэмжлэх эрхийн асуудлыг тодорхойлох.</p>
6	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	<p>3 дугаар зүйл.Төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хүрээ</p> <p>5 дугаар зүйл.Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам</p> <p>5.3. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ хуулийн 5.2-т заасан удирдамжгүйгээр хийж болно.</p> <p>5² дугаар зүйл.Төлөвлөгөөт бус хяналт шалгалт</p> <p>5².1. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ.</p> <p>10.9. Мэргэжлийн хяналтын Улсын байцаагч дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ</p>	<p>- Хохирол нөхөн төлүүлэх асуудал тодорхой бус байна.</p>

	<p>10.9.9. ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон их хэмжээний хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил ньгэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;</p> <p><i>/Энэ заалтыг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</i></p> <p>10.12.4. ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;</p> <p>10.9.7.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх.</p>	
--	---	--

7	Төсвийн тухай хууль	<p>60.3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:</p> <p>60.3.4.нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;</p> <p>60.3.5.зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;</p> <p>69.3. Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.</p>	<ul style="list-style-type: none"> - Хохирлыг барагдуулах, эдгээр хэлцлийн хүчин төгөлдөр байдлын талаар тухайн байгууллага маргаан үүсгээгүй тохиолдолд төрд учруулсан хохирлыг нэхэмжлэх этгээдийг заах.
8	Өрийн удирдлагын тухай хууль	<p>43 дугаар зүйл.Өрийн удирдлагын хяналт</p> <p>43.3.Өрийн удирдлагын хэрэгжилтэд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу жил бүр дотоод аудит хийнэ.</p> <p>45 дугаар зүйл.Өрийн удирдлагын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>45.2.Өрийн удирдлагын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эсхүл санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч дараах шийтгэлийг ногдуулна:</p> <p>45.4.Зөрчлийн хэлбэр, хүлээлгэх хариуцлагаас үл хамааран энэ хуулийг зөрчсөний улмаас төрд хохирол учруулсан буруутай этгээд уг хохирлыг төлж барагдуулна.</p>	<ul style="list-style-type: none"> - Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг тодруулах.
9	Авлигын эсрэг хууль	<p>34 дүгээр зүйл.Авлигын гэмт хэргийн улмаас учирсан үр дагаврыг арилгах</p> <p>34.1. Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, хууль бус аливаа шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Хохирлыг барагдуулах зохицуулалтыг тодруулах.

10	Ойн тухай хууль	<p>25 дугаар зүйл.Төрийн бус байгууллагыг ойн санг хамгаалахад оролцуулах</p> <p>25.1. Ойн баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу ойг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг явуулж болно:</p> <p>25.1.1. ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;</p>	<p>- Хохирлыг барагдуулах эрхтэй этгээдийг тодорхой болгох.</p>
11	Амьтны тухай хууль	<p>37 дугаар зүйл.Амьтны нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх</p> <p>37.1.Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.</p> <p>37.3.Энэ хуулийн 25.3-т заасан тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан, гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн зүйл ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна.</p> <p>37.4.Ан амьтан агнах эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн, түүнчлэн зөвшөөрөлгүй ан амьтан агнасан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.</p>	<p>- Уг нэхэмжлэлийг гаргах, төсвийн сангийн талаар тодорхой бус байх тул прокурор төлөөлөхөөр заах.</p>

Нийслэлийн дүүргүүдийн иргэний хэргийн анхан шатны Шүүхийн шүүгч нараас авсан асуулгын судалгаа

1. Прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс татгалзахдаа дараахаас алийг нь үндэслэл болгож байна вэ?


55 хариулт



1. Прокурорын гаргасан нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс татгалзах үндэслэлийн талаар шүүгчдийн 54.5% нь “нэхэмжлэл гаргах эрхгүй”, 34.5% нь “төрийн байгууллагын хүсэлтгүй”, 5.5% нь “нэхэмжлэлийн шаардлага үндэслэл тодорхойгүй”, үлдсэн 5.5% нь “бусад үндэслэлээр” гэж хариулсан байна.

2. Прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход итгэмжлэл олгосон байхыг шаарддаг уу

55 хариулт




2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход итгэмжлэл шаардлагатай эсэх тухай асуултад 41.8% нь “төрийн байгууллагаас итгэмжлэл авах”, 43.6% нь “прокурорын газраас итгэмжлэл авах шаардлагатай” гэж хариулсан бол 14.5% нь “итгэмжлэлгүйгээр оролцох ёстой” гэж хариулсан.

3. Прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх үүрэг нь тодорхой байдаг

уу

54 хариулт




3. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын эдлэх, эрх үүргийг нарийвчлах шаардлагатай эсэх талаар “тодорхой” гэж 68.5%, “Тодорхой бус” гэж 31.5% нь хариулсан байна.

4. Прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг хэрхэн

бүрдүүлдэг вэ


52 хариулт



4. Прокурорын нотлох баримт гаргах, бүрдүүлэхэд оролцож буй байдлын талаар шүүгчдийн 88.5% нь “прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо нотлох баримтыг хэргийн оролцогчийн хуулиар олгосон эрхийн хүрээнд бүрдүүлдэг” гэж хариулсан бол үлдсэн 11.5% нь “өөрөө бүрдүүлдэг” гэжээ.

5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох прокурорын эрх зүйн байдлыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байгаа эсэх


55 хариулт



5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох прокурорын эрх зүйн байдлын талаар шүүгчдийн 96.4% “тодорхой болгох шаардлагатай” гэж нь үзсэн байна. Эрх зүйн байдлыг тодруулсан асуулгад 14.2% нь “гуравдагч этгээд” гэж, 29% хувь нь “нэхэмжлэгч” гэж, 56.8% нь “төрийг төлөөлөх эрхтэй этгээд”-20 гэж тус тус тодорхойлсон.

6. Төрийн байгууллага хамтран ажиллах агуулгатай хүсэлт гаргасан тохиолдолд

46 хариулт




6.Мөн төрийн байгууллага нэхэмжлэл гаргасан тохиолдолд “прокурор хамтран нэхэмжлэгчээр оролцох” гэж 41.3%, “Гуравдагч этгээдээр оролцох” гэж 58.7% нь хариулсан байна.

7. ИХШХША-д төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий прокурор оролцдог

ЭСЭХ


55 хариулт



7.Шүүгчдийн 76.4% нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд “төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий прокурор” оролцдог гэжээ.

8. Прокурорын оролцох иргэний маргааны төрлийг хуулиар тодорхойлох шаардлагатай юу

56 хариулт



Энэ нөхцөл байдлыг тодорхой болгох чиглэлээр прокурорын оролцох иргэний маргааны төрлийг хуулиар тодорхойлох шаардлагатай гэж оролцогчдийн 60,7% нь хариулсан байх бөгөөд дараахь маргааны төрлийг нээлттэй асуулгын хүрээнд тодорхойлжээ. Үүнд: төрийн эрх ашиг зөрчигдсөн, төрд учруулсан хохирол төлүүлэх, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудал, гэрээний бус үүрэг, гэм хорын маргаан, эрүүгийн гэмт

хэргийн улмаас төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учирсан тохиолдолд, цагаатгалын нөхөн олговор, байгаль орчинд хохирол учруулсантай холбоотой, нийтийн эзэмшлийн хөрөнгөд халдсантай холбоотой, төрийн байгууллага татан буугдсан, эрх залгамжлагч байхгүй хохирлын хувьд, татвар, нийгмийн даатгал, төрөөс олгосон зээлийн гэрээний маргаанд, хөдөлмөрийн маргаан буюу цалин хөлстэй холбоотой маргаан.

Гадаад Улсын хууль тогтоомжийн судалгаа

Хуулийн нэр	Хуулийн заалт, агуулга	Тодруулга /зорилго, онцлог, прокурор оролцох төрөл/
1. БНХАУ		
Прокурорын тухай хууль	<p>14 дүгээр зүйл</p> <p>Ардын прокурор нь иргэний процессын үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй.</p> <p>55 дугаар зүйл.</p> <p>Нэг төрлийн хэрэгт нэг талд нь олон этгээд, эсхүл тодорхой бус тооны этгээдийн нэхэмжлэлээр эхлүүлсэн маргаанд ардын шүүхээс нийтэд хандсан тодорхой агуулга бүхий мэдэгдэл гарган тогтоосон хугацаанд нэхэмжлэлээ гаргах боломжийн талаар мэдэгдэнэ.</p> <p>Ардын шүүхэд нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгчид өөрсдийн дундаас маргаан хэлэлцэх ажиллагаанд оролцох төлөөлөгчөө сонгох, ийнхүү тсонгогдсон төлөөлөгч нь оролцох боломжгүй бол шүүхээс нэхэмжлэгч нартай зөвшилцөн тохиролцож шүүх шийдвэрлэнэ.</p>	- Олон нийтийн эрх ашиг хамгаалах харилцаанд төлөөлөх эрх
Иргэний процессын хууль	<p>XVI бүлэг. Шийдвэрлэх ажиллагааны хяналт</p> <p>185 дугаар зүйл.</p> <p>Ардын шүүхийн аль шатанд гарсан хүчин төгөлдөр шийдвэрийг прокурор, ардын шүүхийн доод шатанд гарсан хүчин төгөлдөр шийдвэр, тогтоолыг дээд шатны прокурор дараахь нөхцөл байдал илэрсэн гэж үзвэл Ардын дээд прокурор, эсхүл дээд шатны ардын прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар эсэргүүцэл гаргана:</p> <p>1. Өмнө гаргасан шүүхийн шийдвэр болон тогтоол гаргах үндэслэлд хамаарах гол нотлох баримт хангалтгүй байсан;</p> <p>2. Өмнөх шүүхийн шийдвэр болон тогтоолд хууль хэрэглээний алдаа гарсан;</p> <p>Ардын шүүхийн процессын алдаа гаргасан нь шийдвэр, тогтоолын үнэн зөв байдалд нөлөөлсөн;</p> <p>Шүүхийн алба хаагч хэрэг шийдвэрлэхтэй холбоотой завшсан, хахууль авсан, өөрийн ашиг сонирхлын төлөө давуу тал үүсгэсэн, хуулийг урвуулан ашигласан.</p>	<p>-Прокурорын хяналтын хэлбэр, төрлийг тодотгон хуульчилсан</p> <p>Хүчин төгөлдөр шийдвэрийг хянах</p> <p>-Ашиг сонирхлын зөрчил</p> <p>-Гол нотлох баримт</p> <p>-Хууль хэрэглээний ноцтой зөрчил</p>

	<p>Хэрвээ орон нутгийн ардын прокурор өмнө хэсэгт заасан нөхцөл байдал байгааг илрүүлсэн бол дээд шатны прокурорт эсэргүүцэл гаргуулахаар хандана.</p> <p>186 дугаар зүйл.</p> <p>Ардын прокурорын эсэргүүцэл гаргасан хэргийг ардын шүүх дахин хэлэлцэнэ.</p> <p>187 дугаар зүйл.</p> <p>Ардын прокурор шүүхийн шийдвэр, тогтоолын эсрэг эсэргүүцлээ бигээр гаргана.</p> <p>188 дугаар зүйл.</p> <p>Ардын прокурорын эсэргүүцлээр хэргийг дахин шийдвэрлэж буй ардын шүүхээс шүүхэд төлөөлөх этгээдийг томилох талаар мэдэгдэнэ.</p>	
2. ОХУ		
Прокурорын байгууллагын тухай хууль	<p>27 дугаар зүйл. Прокурорын бүрэн эрх</p> <p>4. Иргэний болон захиргааны шүүх ажиллагааны журмаар иргэн, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдахаар бол хохирч буй этгээд эрүүл мэнд, нас барсан болон бусад шалтгаанаар шүүхэд өөрийн эрхээ хамгаалан мэтгэлцэх боломжгүй бол, эсхүл хэт олон тооны иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн болон бусад нөхцөл байдлын улмаас нийгмийн онцгой ач холбогдолтой бол прокурор шүүхэд хохирч буй хүмүүсийн ашиг сонирхлын өмнөөс нэхэмжлэл гарган, дэмжиж оролцоно.</p>	<p>-Олон нийтийн эрх ашиг</p> <p>- Н и й т и й н нийтлэг ашиг сонирхол</p>
Иргэний процессын хууль	<p>45 дугаар зүйл. Прокурор хэрэгт оролцох</p> <p>Прокурор ОХУ, ОХУ-ын субъект, орон нутгийн захиргааны ашиг сонирхол, иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд нэхэмжлэл гарган хандах эрхтэй.</p> <p>Иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэлийг зөвхөн тухайн иргэн эрүүл мэнд, нас, эрх зүйн чадамжгүй байдал болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрөө шүүхэд хандах боломжгүй тохиолдолд гаргана. Энэ хязгаарлалт нь иргэн өөрийн хөдөлмөр /албаны/ хүрээний болон үүнтэй шууд хамааралтай зөрчигдсөн болон маргаантай эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулахаар, гэр бүл, эх, эцэг, хүүхэд хамгааллаар, нийгмийн хамгаалал оролцуулаад нийгмийн хамгааллын асуудлаар, төрийн болон нутгийн захиргааны орон сууцны сангаас орон байраар хангагдах эрх, эрүүл мэндийн үйлчилгээг хамруулаад эрүүл мэндээ хамгаалах, эрүүл, аюулгүй амьдрах эрх, боловсролын эрхээ хамгаалуулахаар прокурорт хандсан үндэслэлээр гаргах нэхэмжлэлд хамаарахгүй.</p>	<p>- Орон нутгийн захиргааны ашиг сонирхол зөрчигдсөн</p> <p>- Өөрийгөө төлөөлөх чадамжгүй иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах</p> <p>- Орон байрнаас албадан гаргах,</p> <p>- Ажилд эгүүлэн тогтоох,</p> <p>- Эрүүл мэнд, амь насанд учруулсан хохирол нөхөн төлүүлэх</p>

	<p>2. Нэхэмжлэл гаргасан прокурор эвлэрэн хэлэлцэхээс бусад процессын бүх эрхийг эдэлж, шүүхийн зардал төлөхөөс бусад нэхэмжлэгчийн үүргийг хүлээнэ. Бусдын өмнөөс нэхэмжлэл гаргасан прокурор нэхэмжлэлээсээ татгалзвал, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй тухайн этгээд өөрөө, эсхүл хууль ёсны төлөөлөгч нь нэхэмжлэлээс татгалзсан хүсэлт өгөөгүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилнэ. Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тохиолдолд бусад этгээдийн хууль ёсны ашиг сонирхол, эрхэд нөлөөлөхөөргүй бол шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.</p> <p>3. Орон байрнаас албадан гаргах, ажилд эгүүлэн тогтоох, эрүүл мэнд, амь насанд учруулсан хохирол нөхөн төлүүлэх, мөн энэ хууль болон бусад хуульд заасан тохиолдолд прокурор өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээр процесст оролцоно. Хэрэг хянан шийдвэрлэх ажллагааны цаг, хугацааг мэдэгдсэн тохиолдолд прокурор ирээгүй нь хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.</p>	
--	--	--

3. Япон		
Иргэний хууль	<p>7 дугаар зүйл. Шүүхээс асран хамгаалалтыг тогтоох</p> <p>Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгох чадамжгүй этгээдэд тухайн этгээд, түүний гэр бүлийн гишүүн, төрөл садан, насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагч, насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагчийг хянан харгалзах эрх бүхий этгээд, төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагч, төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагчийг хянан харгалзах этгээд, төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслагч, төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслахыг хянан харгалзах этгээд, түүнчлэн прокурорын хүсэлтээр шүүх асран хамгаалалтыг тогтооно.</p> <p>10 дугаар зүйл. Асран хамгаалалтыг тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох</p> <p>Тус хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэслэл үгүй болсон бол гэр бүлийн шүүх тухайн этгээд, түүний эхнэр, нөхөр, (4 үеийн доторх) төрөл садан, асран хамгаалагч, (насанд хүрээгүй ба насанд хүрсэн этгээдийн асран хамгаалагч. Дор мөн адил), асран хамгаалагчийг хянан харгалзах этгээд (Насанд хүрээгүй ба насанд хүрсэн этгээдийн асран хамгаалагчийг хянан харгалзагч. Дор мөн адил), түүнчлэн прокурорын хүсэлтээр асран хамгаалалт тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p>	

	<p>11 дүгээр зүйл. Төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалалтыг тогтоосон шүүхийн шийдвэр</p> <p>Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг бүрэн хэмжээнд ойлгох чадваргүй этгээдэд Гэр бүлийн шүүх тухайн этгээд, түүний эхнэр/ нөхөр, (4 үеийн доторх) төрөл садан, асран хамгаалагч, асран хамгаалагчийг хянан харгалзах этгээд, төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслагч, төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслагчийг хянан харгалзах этгээд, түүнчлэн прокурорын хүсэлтээр шүүх төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагчийг тогтоож болно. Гэхдээ тус хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэслэл байгаа гэж үзсэн этгээд үүнд хамаарахгүй.</p> <p>14 дүгээр зүйл.Төлөөлөх эрхгүй асран хамгаалалтыг тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох.</p> <p>14.1 Тус хуулийн 11 дүгээр зүйлд заасан үндэслэл байхгүй болсон тохиолдолд Гэр бүлийн шүүх тухайн этгээд, түүний эхнэр, нөхөр, (4 үеийн доторх) төрөл садан, насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагч, насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагчийн харгалзагч, төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагч, төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагчийн харгалзагч, түүнчлэн прокурорын хүсэлтээр төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалалтыг тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p> <p>15 дугаар зүйл. Шүүхээс төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслахыг тогтоох</p> <p>15.1 Гэр бүлийн шүүх сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг бүрэн ойлгох чадваргүй болсон этгээдэд тухайн этгээд, түүний эхнэр, нөхөр, (4 үеийн доторх) төрөл садан, асран хамгаалагч, асран хамгаалагчийн харгалзагч, төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагч, төлөөлөх бүрэн эрхгүй асран хамгаалагчийн харгалзагч, түүнчлэн прокурорын хүсэлтээр төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслагчийг томилж болно. Гэхдээ тус хуулийн 7 дугаар зүйл ба 11 дүгээр зүйлд заасан үндэслэл байгаа гэж үзсэн этгээд үүнд хамаарахгүй.</p> <p>18 дугаар зүйл. Төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслалцаа тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох.</p> <p>18.1 Тус хуулийн 15.1-т заасан шалтгаан үгүй болсон тохиолдолд Гэр бүлийн шүүх тухайн этгээд, түүний эхнэр, нөхөр, (4 үеийн доторх) төрөл садан, насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагч, насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагчийн харгалзагч, төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслагч мөн түүний харгалзагч, прокурорын хүсэлтээр төлөөлөх хязгаарлагдмал эрхтэй туслагч томилсон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно.</p>	<p>-Асран хамгаалалт тогтоох</p> <p>-Иргэний эзгүйд эд хөрөнгө хамгаалах</p>
--	--	--

	<p>2 25 дугаар зүйл. Иргэний эзгүйд эд хөрөнгийг эрхлэн хамгаалах.</p> <p>25.1 Иргэн байнгын оршин сууж байсан болон гол төлөв амьдран суудаг байсан газраа орхихдоо эд хөрөнгөндөө эрхлэн хамгаалагчийг тогтоогоогүй бол Гэр бүлийн шүүх сонирхогч этгээд, прокурорын хүсэлтээр тухайн эд хөрөнгийг эрхлэн хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах тухай захирамж гаргаж болно. Иргэнийг эзгүй хойгуур эрхлэн хамгаалагчийн эрх мэдэл нь дуусгавар болсон бол адил байна.</p> <p>25.2 Өмнөх заалтын дагуу захирамж гарсны дараа иргэн эд хөрөнгөндөө эрхлэн хамгаалагчийг тогтоосон бол Гэр бүлийн шүүх эд хөрөнгийг эрхлэн хамгаалагч, сонирхогч этгээд мөн прокурорын хүсэлтээр тус захирамжийг хүчингүй болгоно.</p> <p>26 дугаар зүйл. Эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг өөрчлөх</p> <p>26.1 Иргэн эзгүй байх хоорондоо эд хөрөнгөндөө эрхлэн хамгаалагч тогтоосноос хойш амьд эсэх нь тодорхойгүй болсон бол гэр бүлийн шүүх сонирхогч этгээд, прокурорын хүсэлтээр эд хөрөнгө эрхлэн хамгаалагчийг өөрчилж болно.</p>	
<p>4. Япон</p>		
<p>Хууль зүйн яам байгуулах тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл. Төр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болох тохиолдолд Хууль зүйн сайд төрийг төлөөлнө.</p> <p>2 дугаар зүйл. Хууль зүйн сайд өмнөх зүйлд заасан ажиллагаанд оролцох газар бүхий албан тушаалтнуудтай байна.</p> <p>2.2. Хууль зүйн сайд өмнөх зүйлд заасан захиргааны байгууллагын удирдлага буюу харьяалалд байгаа хэрэг маргааныг шийдвэрлэх шаардлагатай гэж тогтоож болно. Энэ тохиолдолд холбогдох захиргааны байгууллагын саналыг сонссоны дараа тухайн захиргааны байгууллагын ажилтныг нэхэмжлэл гаргуулахаар Хууль зүйн сайд томилж болно. Томилогдсон этгээд нь Хууль зүйн сайдын удирдлага дор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.</p> <p>3. Хууль зүйн сайд өмнөх зүйлд дурдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар Орон нутгийн засаг захиргааны тухай хуулийн 1 дүгээр хэсгийн 2 дугаар зүйлийн 9.1-д заасан этгээдийг ажиллуулахаар томилно. Шаардлагатай гэж үзвэл орон нутгийн нийтийн эрх зүйн байгууллагын саналыг сонссоны дараа тухайн орон нутгийн төрийн байгууллагыг төлөөлөх этгээдийг Хууль зүйн сайд томилно. Томилогдсон этгээд нь Хууль зүйн сайдын удирдлага дор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.</p>	<p>Японы Хууль зүйн сайдын эрхлэх хүрээнд прокурорууд /kenji/ багтдаг.</p> <p>-Төр /засгийн газар/</p> <p>-Нийтийн захиргааны байгууллагууд /агентлаг, олон нийтийн байгууллага/</p>

<p>4. Хууль зүйн сайд нь өмнөх зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэгдмэл захиргааны байгууллагыг томилж болно. Бичиг хэргийн зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн нэгдмэл захиргааны байгууллагын саналыг сонссоны дараа тухайн байгууллагын ажилтнууд дотроос уг байгууллагыг төлөөлөх этгээдийг томилно. Томилогдсон этгээд нь Хууль зүйн сайдын удирдлага дор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно.</p> <p>3 дугаар зүйл. Өмнөх хэсэгт заасан заалтууд нь Хууль зүйн сайдыг 1 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульчийг томилж, оролцуулахад саад болохгүй.</p> <p>4 дүгээр зүйл. Хууль зүйн сайд шүүхийн зөвшөөрөлтэйгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томилогдсон этгээдэд өөрийн үзэл бодлыг илэрхийлэх бөгөөд тухайн Улсын нийтийн эрх ашиг, эсхүл Улсын эрх ашиг ноцтой зөрчигдсөн гэж үзвэл өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.</p> <p>5 дугаар зүйл. Захиргааны байгууллага 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан захиргааны байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан журмын дагуу ажилтныг томилон оролцуулж болно. Уг хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг хамаарна. Энэ тохиолдолд нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>2. Захиргааны дээд шатны байгууллагын албан тушаалтан өмнөх бүлэг, хэсэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орж байгаа тохиолдолд тухайн заалтад заасан захиргааны байгууллагын албан тушаалтан гэж тооцогдоно.</p> <p>3. 1 дүгээр хэсэгт заасан заалт нь захиргааны байгууллагын зүгээс хуульд заасан журмын дагуу хуульч томилоход саад болохгүй.</p> <p>6 дугаар зүйл. Захиргааны байгууллага нь Хууль зүйн сайдын удирдлага дор өмнөх зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааг оролцоно.</p> <p>2. Хууль зүйн сайд шаардлагатай гэж үзвэл өмнөх зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар хуульч томилох эрхтэй бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөөлөгч нь нэхэмжлэл гаргах болон бусад эрхийг эдэлнэ. Захиргааны байгууллагаас томилогдсон этгээдийг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу ажлаас нь чөлөөлж болно. Үүнд орон нутгийн байгууллага хариуцагчаар оролцох зэрэг тохиолдолд мөн адил хамаарна.</p>	
---	--

	<p>6.2 дугаар зүйл. Орон нутгийн захиргааны байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох гэж байгаа талаар Хууль зүйн сайдад урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>2. Тухайн орон нутгийн нийтийн удирдлагын байгууллагын асуудал нь өмнөх 2 хэсэгт заасан журмын дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох бөгөөд захиргааны байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болж байгаа тохиолдол хамаарна.</p> <p>Хууль зүйн сайд нь орон нутгийн захиргааны байгууллагын хүсэлтээр зөвлөмж өгөх, материал бүрдүүлэх зэргээр зааварчилгаа өгөх эрхтэй. Улсын эрх ашиг хөндөгдөж байгаа тохиолдолд уг эрхээ хэрэгжүүлнэ.</p> <p>3. Үндэсний засгийн газрын эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Хууль зүйн сайд орон нутгийн байгууллагын удирдлагатай энэ талаар зөвлөлдөх бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульчийн хувиар оролцох, үгүй бол хуульчийг томилж болно. Оролцож буй хуульч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гаргана.</p> <p>4. Хууль зүйн сайд өмнөх хэсэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд засгийн газрын ашиг сонирхлыг харгалзан үзэх шаардлагатай гэж үзвэл тухайн хэсэгт заасан орон нутгийн төрийн байгууллагын дарга, төрийн захиргааны байгууллагын ажилтнуудтай зөвлөлдөнө.</p> <p>5. Өмнөх хэсэгт заасан тохиолдолд Хууль зүйн сайд шаардлагатай гэж үзвэл тухайн орон нутгийн төрийн байгууллагын дарга, тухайн орон нутгийн төрийн байгууллагын асуудал эрхэлсэн сайд, Ерөнхий сайд эсвэл яам бүрийн сайд нартай зөвшилцсөний үндсэн дээр тухайн Улсын төрийн байгууллагын албан тушаалтнаар томилогдсон этгээд нэхэмжлэл гаргаж болно. Энэ тохиолдолд томилогдсон этгээд нь Хууль зүйн сайдын удирдлага дор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.</p> <p>6-3 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллага нь нэгж байгуулахтай холбоотой асуудлын талаар Хууль зүйн сайдад нэн даруй мэдэгдэнэ.</p> <p>2. Төрийн захиргааны төв байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах гэж байгаа, эсхүл захиргааны төв байгууллагын нэгж байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох гэж байгаа бол энэ тухай Хууль зүйн сайдад урьдчилан тайлагнана.</p> <p>3. Хууль зүйн сайд нь улс орны эрх ашгийг харгалзан үзэх шаардлагатай гэж үзвэл харьяалагдах захиргааны байгууллагад үүрэг даалгавар өгч болно.</p>	
--	---	--

	<p>4. Хууль зүйн сайд өмнөх хэсэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үндэсний засгийн газрын ашиг сонирхлыг харгалзан үзэх шаардлагатай гэж үзвэл харьяалагдах захиргааны байгууллагын дарга, тус байгууллагын ажилтнуудтай зөвлөлдөж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульчийн хувиар оролцох, үгүй бол хуульч томилно.</p> <p>5. Хууль зүйн сайд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн харьяалах сайдын саналыг сонссоны үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох агентлагийн албан тушаалтныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр томилж болно. Тухайн этгээд нь нэхэмжлэл гаргах эрхтэй.Томилогдсон этгээд нь Хууль зүйн сайдын удирдлага дор ажиллана.</p> <p>7 дугаар зүйл. Орон нутгийн нийтийн удирдлагын байгууллага, төрийн захиргааны төв байгууллага болон бусад нийтийн хуулийн этгээдийн талаар засгийн газрын зүгээс тухайлан заасан тохиолдолд Хууль зүйн сайдыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар хүсэлт гаргаж болно.</p> <p>2. Нийтийн удирдлагын байгууллага өмнөх хэсэгт заасан асуудлаар хүсэлт гаргасан тохиолдолд энэ тухай Дотоод хэргийн сайдад мэдэгдэнэ.</p> <p>3. 1 дүгээр зүйлд заасан асуудлаар хүсэлт гаргасан тохиолдолд Хууль зүйн сайд үндэсний засгийн газрын ашиг сонирхлыг харгалзан шаардлагатай гэж үзвэл тус газрын албан тушаалтнуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болно. Энэ тохиолдолд Дотоод хэргийн сайдын саналыг авна.</p> <p>4. Өмнөх хэсэгт заасан заалтууд нь орон нутгийн нийтийн удирдлагын байгууллага, захиргааны нэгдсэн байгууллага болон бусад нийтийн удирдлагын хуулийн этгээдийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр хуульч томилох, нэхэмжлэл гаргахад саад болохгүй.Хууль зүйн сайд, эсхүл уг хэсэгт заасны дагуу захиргааны байгууллагаас томилогдсон этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгч томилохоос бусад эрхийг эдэлнэ. Бусад эрх зүйн маргаангүй асуудлууд болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өмнөх заалтууд нэгэн адил хамаарна.</p> <p>9 дүгээр зүйл. Өмнөх заалтыг эвлэрүүлэн зуучлах болон бусад маргаангүй хэрэгт хэрэглэнэ. Энэ тохиолдолд 6-2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох” гэснийг “хэрэг хянан шийдвэрлэх тухай өргөдөл”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны асуудал” гэж “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хэрэг” гэж тус тус тусгах нь зүйтэй.</p> <p>10 дугаар зүйл. Орон нутгийн захиргааны байгууллагын асуудлаар аливаа хууль зүйн асуудалд өмнөх зүйлүүдийн нэгэн адил хамаарна.</p>	
--	---	--

5. ХБНГУ		
	<p>Нийтийн ашиг сонирхлын төлөөлөгч</p> <p>35 дугаар зүйл.</p> <p>1. Холбооны Засгийн газар Холбооны Захиргааны хэргийн шүүхэд Холбооны ашиг сонирхлыг төлөөлөх этгээдийг томилох бөгөөд хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэд байна. Холбооны Захиргааны хэргийн шүүх дэх холбооны ашиг сонирхлыг төлөөлөх этгээд нь холбооны Захиргааны хэргийн шүүхийн аль ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй. Энэ заалт нь зэвсэгт хүчинтэй холбоотой асуудалд хамаарахгүй. Тухайн нийтийн эрх ашгийн төлөөлөгч нь холбооны засгийн газрын удирдлага дор ажиллана.</p> <p>2. Холбооны захиргааны хэргийн шүүх нь холбооны эрх ашгийг төлөөлөгчийг оролцох нөхцөл боломжоор хангана.</p>	<p>-Нийтийн ашиг сонирхол зөрчигдсэн бол</p>
<p>Захиргааны хэргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</p>	<p>36 дугаар зүйл.</p> <p>1. Нийтийн эрх ашгийн төлөөлөгч нь Захиргааны хэргийн дээд шүүх болон захиргааны шүүхэд Холбооны хууль, мужийн хуульд заасан журмын дагуу оролцоно. Тухайн этгээд нь мужийн болон мужийн эрх бүхий этгээдүүдтэй холбоотой асуудлаар тодорхой хэрэгт төлөөлөх зорилготой байна.</p> <p>2. 35-р зүйлийн 2 дахь хэсэгт мөн адил хамаарна.</p> <p>37 дугаар зүйл.</p> <p>1. Холбооны Захиргааны хэргийн шүүхэд Холбооны эрх ашгийг төлөөлөх төлөөлөгч болон захиргааны дээд шатны албан тушаалтнууд нь бүтэн цагийн албан тушаалтан байх бөгөөд шүүгчийн албан тушаал эрхлэх нөхцөл, шаардлагыг хангасан болон энэ хуулийн Шүүхийн тухай хуулийн 110-р зүйлд заасан нөхцөлийг хангасан этгээд байна.</p> <p>2. Захиргааны хэргийн дээд шүүх болон захиргааны шүүхэд нийтийн эрх ашгийг төлөөлөх төлөөлөгч нь Германы Шүүхийн тухай хуулийн 174-р зүйлд заасан шаардлагыг хангасан этгээд байх бөгөөд 174-р зүйл нь хөндөгдөхгүй болно.</p>	
6. БНСУ		
<p>Иргэний процессын хууль</p>	<p>62 дугаар зүйл. Эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай этгээдийн төлөөлөгч</p> <p>Асран хамгаалагчгүй бага насны этгээд, эсхүл асран хамгаалагч нь маргааны тал болсон, ашиг сонирхол бүхий оролцогч, эсхүл төлөөлөх эрхгүй бол орон нутгийн захиргааны тэргүүн эсхүл Улсын прокурор процесс ажиллагаа удааширсны улмаас хохирол учирч болзошгүй, эсхүл дараахь тохиолдолд тусгай төлөөлөгч томилуулахаар шүүхэд хандаж болно:</p>	

<p>Прокурорын албаны тухай хууль</p>	<p>4 дүгээр зүйл. Прокурорын үүрэг 1.Прокурор бүр дараахь тохиолдолд нийтийн эрх ашгийн төлөөлөгчийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлнэ. 5. Төр маргааны болон захиргааны маргааны тал эсхүл оролцогч болж оролцох</p>	
<p>Иргэний хууль</p>	<p>9-14 дүгээр зүйл /Насанд хүрсэн этгээд эрх зүйн чадамжгүй болсон бол асран хамгаалагч тогтоох/, 22, 23, 27, 29 дүгээр зүйл /Сураггүй алга болсон хүний эд хөрөнгийн удирдлага, эд хөрөнгө эрхлэн хамгаалагчийн солих, сураггүй алга болсонд тооцох, сураггүй алга болсны үр дагавар, сураггүй алга болсон тооцсон шийдвэрийг хүчингүй болгох/, 44 дүгээр зүйл /үүсгэн байгуулагч эзэнгүй сангийн удирдлагыг шүүхээс томилуулах/, 63 /хуулийн этгээд удирдлагагүй болсны улмаас хохирол үүсэж болзошгүй нөхцөлд удирдлагыг томилох/, 83 /шүүхээс татан буулгагч томилох/, 84 / татан буулгагчийг шүүхээс огцруулах/, 818 /гэрлэлтийг хүчингүй болгуулах/, 837 /хүүхдийн асрамж өөрчлөх/, 847 /эцэг, эх байх эрхийг хязгаарлах/, 849 /хүүхэд нас барсны дараа эцэг, эх байсныг үгүйсгэх/ 864, 865 / тодорхой шалтгааны улмаас эцэг, эх байсныг үгүйсгэх/, 906 /төрөл садангийн холбоог хүчингүй болгох/, 908-5 /үрчлэлтийг хүчингүй болгох/, 909-2 /эцэг, эхийн эрх хэрэгжүүлэх этгээдийг томилох/, 924, 925, 932, 936, 938, 940 / эцэг, эх байх эрхийг хасах, эд хөрөнгийн удирдлагын болох төлөөллийн эрхийг хасах, бага насны хүүхдийн асран хамгаалагч томилох, насанд хүрсэн хүний асран хамгаалагч томилох, асран хамгаалагчийн болон төлөөлөх эрх, асран хамгаалагчийг солих/, 940-3, 940-4, 959-5, 959-10, 959-15, 1959-17 /бага насны хүүхдийн хамгаалагч томилох, насанд хүрсэн хүний хамгаалагч томилох, асран хамгаалагчийн захиран зарцуулах эрх, хязгаарлагдмал чадамжтай этгээдийн хамгаалагч, тусгай асран хамгаалагч, сайн дурын асран хамгааллын хамгаалагч томилох, сайн дурын асран хамгаалалд хязгаарлалт тогтоох/, 1019, 1023, 1053 /өв хүлээн авах, өвлөгдөх хөрөнгийн хадгалах, өвлөгчгүй хөрөнгийн удирдлага/</p>	<p>- үүсгэн байгуулагч эзэнгүй сангийн болон хуулийн этгээд удирдлагагүй болсны улмаас хохирол үүсэж болзошгүй нөхцөлд удирдлагыг томилуулах - онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд - өв хүлээн авах, өвлөгдөх хөрөнгийн хадгалах, өвлөгчгүй хөрөнгийн удирдлага</p>
<p>7. Казахстан</p>		
<p>Иргэний процессын хууль</p>	<p>8 дугаар зүйл. Хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөөг шүүхээр хамгаалах 1. Хүн бүр энэ хуульд заасан журмын дагуу өөрийн зөрчигдсөн болон маргаантай байгаа эрх, ашиг сонирхол, эрх чөлөөг хамгаалахаар шүүхэд хандах эрхтэй. 2. Төрийн байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд, иргэн энэ хуулиар тогтоосон журмын дагуу бусад этгээдийн болон тодорхой бус этгээдийн зөрчигдсэн болон маргаантай ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Прокурор нийгмийн болон төрийн ашиг сонирхол, иргэн, хуулийн этгээдийн эрхийг хамгаалах, тэдгээр үүрэг ногдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.</p>	<p>- нийгмийн болон төрийн ашиг сонирхол, иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээр үүрэг ногдуулахаар</p>

	<p>148 дугаар зүйл. Нэхэмжлэлийн агуулга, хэлбэр</p> <p>3. Төрийн болон нийгмийн ашиг сонирхлыг хамгаалахаар прокурорын гаргаж буй нэхэмжлэлд нийгмийн болон төрийн ашиг сонирхол хэрхэн хөндөгдөж байгаа, эсхүл зөрчигдөж байгаа үндэслэлийг заах, мөн хэрэглэвэл зохих хуулийг заасан байна.</p> <p>Прокурор иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө нэхэмжлэл гаргаж байгаа тохиолдолд уг этгээд нь өөрөө нэхэмжлэл гаргах боломжгүй байгааг нотолсон баримт гаргана. Нэхэмжлэлд ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйгээс бусад иргэн, хуулийн этгээд нэхэмжлэл гаргахыг зөвшөөрсөн болохыг нотолсон баримтыг хавсаргана.</p>	
--	---	--

ТАНИЛЦУУЛГА

/Зөвлөх Жаргалсайханы Оюунтунгалаг/

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас баталсан 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд төр, нийтийн эрх ашгийг хамгаалж иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох чиг үүргийг тодорхойлсон.

2002 Оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь төр, нийтийн эрх ашгаас илүүтэй хувь этгээд хоорондын ашиг сонирхлоо хамгаалсан мэтгэлцээнд суурилах үзэл баримтлалд үндэслэгдсэн бөгөөд прокурорыг төрийн байгууллагын хүсэлтээр оролцож болохоор зохицуулсан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээс гадна, өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар 2020 онд өөрчлөлт оруулсан. Гэвч “төрийн” болон “нийтийн” эрх ашиг, прокурорын нэхэмжлэл гаргах хүрээ, эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулаагүйн улмаас хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэл гарсаар байна. Тухайлбал, прокурорын гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлийн дийлэнх нь нэхэмжлэл гаргах эрхгүй, төр, нийтийн ямар эрх ашгийг төлөөлөх нь тодорхойгүй гэх үндэслэл заагдсан байна.

Энэхүү нөхцөл байдлыг шийдвэрлэхэд хуулийн зохицуулалтыг тодорхой, боловсронгуй болгох шаардлагатай байгаа тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, прокурорын тухай хууль болон төр, нийтийн эрх ашигт хамаарах хуулиудад дараах агуулгатай өөрчлөлт оруулахаар төсөлд тусгалаа. Үүнд:

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч төрийн байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд Прокурор гуравдагч этгээдээр оролцох;

2. Төр, нийтийн эрх ашигт учирсан учирсан хохирлыг нэхэмжлэх төрийн байгууллага байхгүй, эсхүл тухайн байгууллага нэхэмжлэл гаргахгүй байгаа, ашиг сонирхлын зөрчилтэй, хуульд прокурор нэхэмжлэл гаргахаар заасан зэрэг тохиолдолд прокурор өөрийн санаачилгаар нэхэмжлэл гарган оролцох;

3. Хувь этгээдийн хоорондын маргааны шийдвэрлэлт төр, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байвал шүүхийн санаачилгаар прокурор оролцуулах;

4. Төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх нийтлэг үндэслэлийг тодорхойлох;

Хуулийн төсөл батлагдахтай холбогдуулан шинээр зардал гарахгүй. Төр, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг барагдуулахаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор нэхэмжлэл гаргах, төрийн байгууллагын хүсэлтээр гуравдагч этгээдээр оролцох зэрэг асуудлыг нэг мөр болгох, оновчтой байдлаар томъёолон тодорхойлох зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачилсан болно.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан прокурорын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Ойн тухай хууль, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

/Зөвлөх Жаргалсайханы Оюунтунгалаг/

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.3.2-Т “Байгалийн нөөц баялгийн экологи-эдийн засгийн үнэлгээг бодитой тогтоож, хохирол барагдуулах хариуцлагын тогтолцоог бий болгоно” гэж, 3.5.4.1-Д “Бохирдуулагч нь төлбөр төлөх, учруулсан хохирлоо барагдуулах хариуцлага хүлээх механизмыг хэрэгжүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.6-д “гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх” талаар тус тус заажээ.

2002 Он Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь төр, нийтийн эрх ашгаас илүүтэй хувь этгээд хоорондын ашиг сонирхлоо хамгаалсан мэтгэлцээнд суурилах үзэл баримтлалд үндэслэгдсэн бөгөөд прокурорыг төрийн байгууллагын хүсэлтээр оролцож болох нэг заалттай батлагдсан. Төр, нийтийн эрх ашгийн зөрчлөөс үүсэлтэй хохирол арилгуулах асуудал, мөн хувь этгээдийн хоорондын маргааны шийдвэрлэлт төр, нийтийн эрх ашигт нөлөөлөх тохиолдол гарсаар байна.

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс төр, нийтийн эрх ашгийг хамгаалж прокурор оролцох чиг үүргийг тодорхойлсон.

2021 Оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан 14 хуульд өөрчлөлт

оруулсны дотор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох талаар өөрчлөлт оруулсан юм.

Дээрх хуулиудын хүрээнд төр, нийтийн эрх ашгийг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх этгээд прокурор байхаар тодорхойлсон боловч талуудын тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцэх зарчмаар явагдах иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох онцлог журам, үндэслэл тодорхой бус үлдсэн.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Прокурор төр, нийтийн эрх ашгийг төлөөлөн хохирол шаардаж иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох асуудал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн нэг заалтад ерөнхий байдлаар тусгагдсан. Ийнхүү нарийвчилсан зохицуулалтгүй байгаагаас прокурор иргэний хэрэгт оролцоход тодорхой бус, хүндрэлтэй байдал үүссээр ирсэн. Тухайлбал, Улсын Ерөнхий прокурорын газраас явуулсан “2020 онд Улсын хэмжээнд прокурорын бичсэн нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл, шийдвэрлэлтийн байдлын судалгаа”-аар анхан шатны шүүх прокурорын гаргасан нэхэмжлэлээс 101 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 104 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 12 нэхэмжлэлийг бүхэлд хангаж, 6 нэхэмжлэлийг хэсэгчлэн хангаж, 36 нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 3 хэргийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан дийлэнх хэсэгт буюу 67 хувьд нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэх үндэслэл заасан, 182 нэхэмжлэл буюу 64.3 Хувьд иргэний хэрэг үүсгэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан боловч 37.1 Хувьд нь хэргийг хүлээн авахаас татгалзах үндэслэл тогтоогдсон, прокурор нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Түүнчлэн, иргэний хэргийн анхан шатны шүүхүүдээс гаргасан прокурорын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 48 захирамж, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 46 захирамж, хэргийг хэрэгсэхгүй болгосон 20 шийдвэрт хийсэн дүн шинжилгээгээр “нэхэмжлэл гаргах эрх тодорхой бус”, “нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй”, “төрийн байгууллагын хүсэлтгүй”, “нэхэмжлэлийн шаардлага үндэслэл тодорхойгүй” зэрэг үндэслэл дийлэнх хувийг эзэлж байна.

Мөн нийслэлийн дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчдийн дунд явуулсан асуулгын судалгаагаар нийт шүүгчдийн 96.4 Хувь нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох прокурорын эрх зүйн байдлыг “тодорхой болгох шаардлагатай” гэж үзжээ.

Дээрх судалгаануудын дүнгээс үзэхэд прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь “оролцогч”-ын эрх зүйн байдлыг тодруулах буюу ямар тохиолдолд нэхэмжлэгчээр, ямар тохиолдолд гуравдагч этгээдээр оролцох болон өөрийн санаачилгаар төр, нийтийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргах үндэслэл, журмыг тодорхой болгох шаардлагатай байна.

Цаашид төр, нийтийн эрх ашигт учруулсан хохирлыг арилгахад прокурор оролцох шаардлага нэмэгдэх төлөвтэй байна. Тухайлбал, Азийн сангаас зохион байгуулсан Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн дүн шинжилгээний тайланд уг төрлийн гэмт хэргийн 5.7 Хувь нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр, 2.4 Хувь нь урьд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн тогтоол, магадлал хүчинтэй үндэслэлээр, 0.7 Хувь нь уг үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо больсон буюу эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль буцаан хэрэглэсэн үндэслэлээр тус тус хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэжээ. Авилга албан тушаалын гэмт хэргийн онцлогоос хамаарч хэрэг бүртгэлтийн шатанд хохирогч, иргэний нэхэмжлэгч тогтоогдоогүйн улмаас төр, нийтийн эрх ашиг хөндөгдсөн хэргүүдэд хохирол гаргуулах асуудал хангалтгүй байгаа гэж судлаачид дүгнэсэн байна. Тодруулбал, 2017-2019 онуудад нийт хээл хахуулийн 109 гэмт хэрэг тогтоогдсоноос 13,732,365,987 төгрөгийн хохирол учирсан гэх тоо мэдээ гарсан бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хохирлын асуудал бүрэн шийдвэрлэгддэггүй гэжээ.

Төр, нийтийн эрх ашигт учирсан хохирлыг барагдуулахаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гаргах ажиллагаа хангалттай бус явагдаж байгаагийн нэг гол шалтгаан прокурорын нэхэмжлэл гаргах эрх тодорхой бус байгаатай холбоотой.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар “төрийн” болон “нийтийн” эрх ашиг гэдгийг тухайлан тодорхойлоогүй, прокурорын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдол, нэхэмжлэл гаргах үндэслэлийг нарийвчлан зохицуулаагүй учраас хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэл гарсаар байгаа нь дээрх судалгаануудаас харагдана. Улсын Дээд шүүхээс 2002 онд гаргасан 263 дугаар тогтоолоор баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлан хэрэглэх тухай зөвлөмжид 31 дүгээр зүйлд заасны дагуу прокурор оролцох

үндэслэлийг товч тодорхойлсон байдаг. Прокурорын байгууллагын хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, нэхэмжлэл гаргах журмыг “Прокурор шүүхэд төрийг төлөөлөх аргачилсан заавар”-ын хүрээнд тодорхойлж байна.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд хамаарах асуудлыг Улсын Дээд шүүхийн зөвлөмж болон Улсын Ерөнхий прокурорын баталсан аргачилсан заавар зэрэг тухайн байгууллагын практик, арга зүйн, зөвлөмжилсөн баримт бичгийн хүрээнд зохицуулах нь учир дутагдалтай бөгөөд хууль хэрэглээний хувьд заавал биелэгдэх үр дагавар үүсгэдэггүй.

Иймд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцох хүрээ, эрх хэмжээний асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхой болгох хэрэгцээ шаардлага байна.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дараах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Үүнд:

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцох эрх зүйн байдлыг тодорхой болгох;
2. Прокурорын төр, нийтийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргах хүрээг тодорхой болгох;
3. Иргэний хэргийн маргаанд төр, нийтийн эрх ашиг хөндөгдөх тохиолдолд шүүхийн санаачилгаар прокурорыг оролцуулах талаар тусгах;
4. Дээрх өөрчлөлттэй холбоотойгоор прокурорын тухай хуульд болон бусад хуульд төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалан нэхэмжлэл гаргах зохицуулалтыг тусгах.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараахь эерэг үр дүн гарна:

- Төрийн болон нийтийн эрх ашигт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тогтолцоо боловсронгуй болох;

- Төрд учирсан хохирлыг барагдуулснаар нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар багасна;

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй. Учир нь одоогийн прокурорын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүний хүрээнд биелүүлж буй чиг үүргийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуультай уялдуулсан, тодорхой болгох чиглэлээр хуулийн төслийг боловсруулсан болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой нийцүүлнэ. Энэхүү төсөлтэй уялдуулан Прокурорын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Авлигын эсрэг хууль, эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Ойн тухай хууль, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

/Зөвлөх Жаргалсайханы Оюунтунгалаг/

2022 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурьдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/ 31 дүгээр зүйлийн 31.4, 31.5, 31.6, 31.7 дахь хэсэг:

“31.4. Энэ зүйлийн 31.1 дэх хэсэгт зааснаар төрийн байгууллага хүсэлт гаргасан тохиолдолд прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцоно.”

“31.5. Прокурор энэ зүйлийн 31.1 дэх хэсэгт зааснаар өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар дараахь тохиолдолд нэхэмжлэл гаргана.

“31.5.1. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх;

31.5.2. Төрийн өмчийн зүйлтэй холбоотой маргаан;

31.5.3. Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;

31.5.4. Нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон;

31.5.5 Энэ зүйлийн 31.5.1-31.5.3-Т заасан маргааныг харьяалсан байгууллага байхгүй, эсхүл тухайн байгууллага нэхэмжлэл гаргаагүй, нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь ашиг сонирхлын зөрчилтэй;

31.5.6. Хуульд заасан бусад үндэслэл.”

“31.6. Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж нэхэмжлэл гаргахад энэ хуулийн 62 дугаар зүйлд зааснаас гадна төрийн болон нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж буй үндэслэл, хэрэглэвэл зохих хуулийг болон хохирлын нөхөн төлбөрийг шилжүүлэх төрийн санг заасан байна.”

“31.7. Шүүхээс гарах шийдвэр төрийн болон нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байвал шийдвэр гарахаас өмнө зохигчийн хүсэлтээр эсхүл шүүхийн санаачилгаар прокурор оролцуулах талаар прокурорын байгууллагад мэдэгдэнэ.”

2/ 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэг:

“36.6. Энэ зүйлд заасан журам хуулийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход үл хамаарна.”

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй.

1. 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт “төрийн нэрийн өмнөөс ” гэснийг “төрийг төлөөлөн” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “хамгаалж байгаа” гэснийг “хамгаалахаар хуульд заасан” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 Дүгээр зүйл: Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий 20.5 дахь хэсэг нэмсүгэй.

“20.5. Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалан иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцох зохион байгуулалтын журам, аргачлалыг Улсын ерөнхий прокурор батална.”



Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 Дүгээр зүйл: Авлигын эсрэг хуулийн 34 дүгээр зүйлд доор дурьдсан агуулгатай 34.2 дахь хэсэг нэмсүгэй.

“34.2. Энэ зүйлийн 34.1-д заасан хохирлыг арилгуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 37.5 дахь хэсэг нэмсүгэй.

“37.5. Энэ зүйлийн 37.1, 37.3, 37.4 дэх хэсэгт заасан нөхөн төлбөрийг барагдуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурьдсан агуулгатай хэсэг нэмсүгэй.

1/ 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг:

“32.3. Энэ хуулийн 32.1.1-Д зааснаар байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан бол прокурор гуравдагч этгээдээр оролцож болно. 37.1, 37.3, 37.4 дэх хэсэгт заасан нөхөн төлбөрийг барагдуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”

2/ 58 дугаар зүйлийн 58.3 дахь хэсэг:

“58.3. Энэ хуулийг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг барагдуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: ойн тухай хуульд доор дурьдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/ 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг:

“25.3. Энэ зүйлийн 25.1.1-Д зааснаар ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд прокурор гуравдагч этгээдээр оролцож болно.”

2/ 47 дугаар зүйлийн 47.3 хэсэг:

“47.3. Энэ хуулийг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг барагдуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: өрийн удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 45.5 дахь хэсэг нэмсүгэй.

“45.5. Энэ зүйлийн 45.4-т заасан этгээд төрд учруулсан хохирлыг төлж барагдуулаагүй бол прокурор нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрхтэй.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 42.6 дахь хэсэг нэмсүгэй.

“42.6. Энэ хуулийг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан бол уг хохирлыг арилгуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”



Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 82.2 дахь хэсэг нэмсүгэй.

“82.2. Энэ хуульд заасныг зөрчиж төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан этгээд хохирлыг барагдуулаагүй тохиолдолд прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”



Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмсүгэй.

“16.3. Энэ зүйлийн 16.1, 16.2 дахь хэсэгт заасан этгээд энэ хуулийг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан бол уг хохирлыг арилгуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”

2 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай тухай хуулийн 16.3 Дахь заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй.

“16.3” гэснийг “16.4” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 70.2 Дахь хэсэг нэмсүгэй.

“70.2. Энэ хуулийг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг барагдуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл: эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд доор дурьдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмсүгэй.

“24.5. Энэ хуулийг зөрчсөний улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг барагдуулахаар прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй.”



ГАРЧИГ

3

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**

55

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН, ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**

119

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ
МАТЕРИАЛУУД**

131

**АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

169

**ТӨР, НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ПРОКУРОР ТӨЛӨӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХТОЙ
ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛУУД**

